CECInvestment
СИ-И-СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК

"CECI" ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ	"Си И Си Ая ассет ван ТЗК" ХХК
ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА	"Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК
ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ҮНЭТ ЦААСНЫ НЭГЖИЙН НЭРЛЭСЭН ҮНЭ	100,000 төгрөг
ҮНЭТ ЦААСНЫ НИЙТ ТОО ШИРХЭГ	30,000 ширхэг хүртэл
ҮНЭТ ЦЛЛСНЫ ҮНИЙН ДҮН	3,000,000,000 төгрөг хүртэл
ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ /ЖИЛИЙН/	18.0%
ҮНЭТ ЦААСНЫ ХУГАЦАА	24 сар

001

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

“Си и Си Ая Ассет Ван ТЗК” ХХК /цаашид “Үнэт цаас гаргагч” эсхүл “ТЗК” гэх/ нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-ийн холбогдох журмуудын дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй 30,000 ширхэг хүртэлх буюу нийт 3,000,000,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох “Си И Си Инвестмент ББСБ” ХХК /цаашид “Анхны үүрэг гүйцэтгүүлэгч” эсхүл “Үүсгэн байгуулагч” гэх/-аас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багц болгон шилжүүлэн худалдан авахад зарцуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу зээл олгох, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж, зах зээлд эзлэх байр суурыа өргөжүүлэхэд бүрэн зарцуулна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийх ажиллагааг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй болно. Мөн Хороо үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв үнэт цаасанд эрсдэл үүсвэл Хороо хариуцахгүй болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн төсөөлөл, тооцоолол, мэдээлэл, мэдэгдэл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хөндлөнгийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй мөн тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт байхгүй гэдгийг баталж байна.

Энэхүү танилцуулгад тусгасан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо болон Улаанбаатар үнэт цаасны бирж бүртгэсэн нь уг баталгаат үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш бөгөөд түүний агуулсан аливаа мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг Хороо болон Бирж хариуцахгүй! Баталгаат үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, баталгаат үнэт цаасны танилцуулга, баталгаат үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь энэ баримт бичигт агуулсан мэдээлэл, хавсаргасан баримт бичиг нь үнэн зөв, бүрэн бөгөөд хуурамчаар бүрдүүлсэн ямар нэгэн баримт бичиг байхгүй гэдгийг албан ёсоор баталж байна. Энд заасан мэдэгдэл нь худал байх тохиолдолд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь дангаар болон хамтын журмаар хариуцлага хүлээхийг хүлээн зөвшөөрч байна.

Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад шаардлагатай бүхий л мэдээллийг энэхүү Үнэт цаасны танилцуулгад агуулахыг зорьсон боловч тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл гарсан тохиолдолд Үнэт цаас гаргагч “Си и Си Ая Ассет Ван ТЗК” ХХК болон Андеррайтер “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-тай танилцуулгад тусгагдсан хаягаар хандана уу.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7139569
9025080098

9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

002

1. АГУУЛГА

2. Хүснэгтийн жагсаалт 5

3. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД 7

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 8

1.1. Үнэт цаасны хураангуй танилцуулга 9

1.2. Хөрөнгө оруулалтын онцлог, давуу тал 11

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 13

2.1. Хуулийн этгээдийн бүртгэл 14

2.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө 14

2.3. Хувьцаа эзэмшигчийн бүтэц 14

2.4. Үүсгэн байгуулагчийн тухай 15

2.5. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт 15

2.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал 16

2.7. Төлөөлөн Удирдах зөвлөл 16

2.8. Үйл ажиллагаа 20

2.8.1. Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал 20

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур үзүүлэлтүүд 21

2.8.2. Хөрөнгийн багцын тойм 24

2.8.3. Худалдах, худалдан авах гэрээ 28

2.8.4. Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ 31

2.8.5. Үйл ажиллагааны ерөнхий тайлбар 33

2.9. Санхүүгийн үйл ажиллагаа 48

2.9.1. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл 48

2.9.2. Орлогын тайлангийн төсөөлөл 49

2.9.3. Мөнгөн гүйлгээний төсөөлөл 50

2.10. Үнэт цаас гаргагчийн дансны мэдээлэл 51

2.11. Үнэт цаас гаргагч татан буугдах 51

3. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ / ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ 52

3.1. Танилцуулга 53

3.2. Бүтэц, зохион байгуулалт, засаглал 54

3.3. Зээлийн үйл ажиллагаа 59

3.4. Санхүүгийн голлох үзүүлэлтүүд 61

3.5. Эрсдэлийн удирдлага 64

4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 67

4.1. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр 68

4.2. Үнэт цаасны хүүгийн түвшин тогтоох үндэслэл 68

4.3. Үнэт цаас эзэмшигчийн эрх 69

4.4. Үнэт цаас гаргагчийн үүрэг 69

4.5. Үнэт цаасны эрсдэл 70

5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН 75

5.1. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага 76

5.2. Монгол Улсын банк бус санхүүгийн салбарын нөхцөл байдал, цаашдын чиг хандлага 85

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ БАНК ТӨК
ГЧ2842 7769869
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ХХК ХХК
TDB SECURITIES
9021 10883
5254494
TDB SECURITIES

003

6. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ 92

6.1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр 93

6.2. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө 93

6.3. Зохицуулагч байгууллагын шийдвэр 93

6.4. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах 94

6.5. Анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл 94

6.6. Үнэт цаасны хуваарилалт 94

6.7. Үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар 94

6.8. Арилжааны төлбөр тооцоо, хоёрдогч зах зээлийн арилжаа 96

7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ 97

7.1. Андеррайтер 98

7.2. Зээлийн шинжилгээ гаргагч 100

7.3. Хуулийн зөвлөх 101

7.4. Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл 103

8. Хавсралт 105

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
ХХК

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
9021110883
TDB SECURITIES

2. Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөл 9
Хүснэгт 2: Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцын мэдээлэл 10
Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд оролцогч талууд 10
Хүснэгт 4: Бусад баримт бичгүүд 10
Хүснэгт 5: Хуулийн этгээдийн бүртгэл 14
Хүснэгт 6: Хөрөнгийн мэдээлэл 14
Хүснэгт 7: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ерөнхий мэдээлэл 15
Хүснэгт 8: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хөрөнгийн мэдээлэл, 2025 оны 2 дугаар улирал 15
Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга 18
Хүснэгт 10: Хөрөнгийн багцын тойм мэдээлэл 24
Хүснэгт 11: Хамгийн их дүнтэй зээлүүд 25
Хүснэгт 12: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшний тархалт 28
Хүснэгт 13: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн барьцаа хангалтын харьцаа 28
Хүснэгт 14: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ерөнхий мэдээлэл 42
Хүснэгт 15: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ТУЗ-ийн гишүүд 43
Хүснэгт 16: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл 45
Хүснэгт 17: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 48
Хүснэгт 18: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 49
Хүснэгт 19: Үнэт цаас гаргагчийн зардлын төсөөлөл 50
Хүснэгт 20: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 50
Хүснэгт 21: АУГ-ийн хураангуй танилцуулга, 2025 оны II дугаар улирлын байдлаар 53
Хүснэгт 22. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн мэдээлэл 54
Хүснэгт 23. Анхны үүрэн гүйцэтгүүлэгчийн эцсийн өмчлөгчийн танилцуулга 56
Хүснэгт 24: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл. 57
Хүснэгт 25: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн гишүүд 57
Хүснэгт 26: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх захирал 59
Хүснэгт 27. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл 59
Хүснэгт 28: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, 2025 оны II улирал 62
Хүснэгт 29: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн удирдлага 64
Хүснэгт 30. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хамгаалалтын бүсийн ангилал, эрсдэлийн төрлөөр 66
Хүснэгт 31: Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, 2022-2025 оны I улирал 76
Хүснэгт 32: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал 78
Хүснэгт 33 : Монгол улсын инфляцын таамаглал 78
Хүснэгт 34: Дэлхийн томоохон уул уурхайн компаниудын зэсийн олборлолт, 2024 он, 2028 оны төсөөлөл 84
Хүснэгт 35: Банк бус санхүүгийн салбарын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, 2021.I-2025.I 87

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ
АССЕТ ВАНТ
ХХК
ШТЧ2842 9969569
9025080098

ТИ ЛИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ААК
TDB SECURITIES
9021110883
5251494
TDB SECURITIES

Зургийн жагсаалт

Зураг 1: ХБҮЦ-ны хүүгийн түвшний харьцуулалт 11
Зураг 2. Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал 20
Зураг 3: Зээлийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээний тархалт, зээлийн тоогоор 25
Зураг 4: Зээлийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээний тархалт, үлдэгдэл дүнгээр 25
Зураг 5: Зээлийн хөрөнгийн олгосон огнооны тархалт, зээлийн тоогоор 26
Зураг 6: Зээлийн хөрөнгийн олгосон огнооны тархалт, үлдэгдэл дүнгээр 26
Зураг 7: Зээлийн хөрөнгийн хугацаа, зээлийн тоогоор 26
Зураг 8: Зээлийн хөрөнгийн үлдэгдэл хугацааны тархалт, үлдэгдэл дүнгээр 27
Зураг 9. Зээлийн үлдэгдэл хугацааны тархалт, тасалбар болгосон өдрөөр 27
Зураг 10: Зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн огнооны тархалт, зээлийн тоогоор 27
Зураг 11: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн бүтэц, зохион байгуулалт 44
Зураг 12: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт 54
Зураг 13: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц 56
Зураг 14. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт зээлийн багц, бүтээгдэхүүний төрлөөр, тэрбум төгрөг 60
Зураг 15: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц 64
Зураг 16: ХБҮЦ-ны хүүгийн түвшний харьцуулалт 68
Зураг 17: Нээлттэй зах зээлд бүртгэлтэй ХБҮЦ-ны хүү 69
Зураг 18: ДНБ-ий өсөлтөд эзлэх салбаруудын оролцооны түвшин, 2025 оны I улирал 77
Зураг 19: Монгол Улсын бодлогын хүүгийн түвшин, 2022-2025 оны I улирал 79
Зураг 20: Дотоодын зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт, 2020 оны IV улирлаас 2025 оны I улирал 79
Зураг 21: Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт, 2025 оны I улирал 80
Зураг 22: Монгол Улсын гадаад валютын албан нөөц (ГВАН) болон төгрөгийн ам.доллартой харьцах ханш, 2015-2025 оны I улирал 81
Зураг 23: Монгол улсын төсвийн орлого, зарлага, их наяд төгрөг, 2015-2025 оны I улирал 81
Зураг 24: Монгол улсын экспорт, импорт, тэрбум ам.доллар, 2014-2025 оны I улирал 82
Зураг 25: Экспорт, импорт бүтээгдэхүүний төрлөөр, нийт экспорт, импортод эзлэх хувь, 2025 оны I улирал 83
Зураг 26: Монгол Улсын ГШХО-ын орох урсгал, ДНБ-д эзлэх хувь, 2012-2025 оны I улирал 83
Зураг 27: Монгол Улсын ГШХО-ын орох урсгалын бүтэц, салбараар, 2020-2025 оны I улирал 84
Зураг 28: Банк бус санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд, 2025 оны I улирал 85
Зураг 29: Банк бус санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд, 2021.I – 2025.I 86
Зураг 30: ББСБ-ын тоо, хөрөнгийн интервалаар, 2025 оны I улирал 87
Зураг 31: Нийт харилцагч болон зээлдэгчийн тоо, 2021.I – 2025.I, мянган ширхэг 87
Зураг 32: Салбарын нийт зээлийн хэмжээ, зээлийн бүтцээр, 2021.I-2025.I, тэрбум төгрөг 89
Зураг 33: Нийт олгосон ба төлөгдсөн зээл, 2022.I-2025.I, тэрбум төгрөг 89
Зураг 34: Нийт олгосон зээл, ангиллалаар, 2022.I-2025.I, тэрбум төгрөг 89
Зураг 35: Банк болон ББСБ-аас шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, хувь 90
Зураг 36: ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо, 2021.I – 2025.I он 90
Зураг 37: Салбарын болон нээлттэй бонд гаргасан ББСБ-уудын өсөлт, 2021-2024 он 90
Зураг 38: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө 93
Зураг 39: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар 95

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ
АССЕТ
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
9021110883
TDB SECURITIES

3. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ / АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ / ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

“Си И Си Инвестмент ББСБ” ХХК

Хаяг:	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Нью хоризонс оффис, 7 давхар 702 тоот
Утас:	(976) 7772 5511
Э-шуудан:	info@ceci.mn
Вэб хуудас:	www.ceci.mn

АНДЕРРАЙТЕР

“Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК

Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа хөгжлийн банкны байр, 1401 тоот
Утас:	(976) 11 311914, (976) 7010 0261
Э-шуудан:	info@tdbsecurities.mn
Вэб хуудас:	www.tdbsecurities.mn

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Өмгөөллийн “ЭмДиЭс Энд Хаанлекс” ХХН

Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
Утас:	(976) 1133-0048
Э-шуудан:	info@mdsa.mn
Вэб хуудас:	www.mdsa.mn

ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ

“Релаэнс секюритиз аудит” ХХК

Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Сакура тауэр, 5 дугаар давхар, 508 тоот
Утас:	(976) 8810 4785, (976) 9906 9630
Э-шуудан:	info@rsa.com
Вэб хуудас:	www.rsa.mn

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ

“Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК

Хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот
Утас:	(976) 11 328267, (976) 9401 8267
Э-шуудан:	info@mik.mn
Вэб хуудас:	www.mik.mn

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АС
ASSET BA
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
9021110883
TDB SECURITIES

01

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Үнэт цаасны хураангуй танилцуулга

"Си и Си Ая Ассет Ван ТЗК" ХХК нь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд дараах нөхцөлийн дагуу санал болгож байна. Үүнд:

Хүснэгт 1: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөл

Үнэт цаас гаргагч	"Си и Си Ая Ассет Ван ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Си И Си Инвестмент ББСБ" ХХК
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	"Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК
Үнэт цаасны төрөл	Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаас гаргах валют	Төгрөг
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
Үнэт цаасны тоо ширхэг	30,000 ширхэг хүртэлх
Үнэт цаасны нийт үнийн дүн	3,000,000,000 (гурван тэрбум) төгрөг хүртэл
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	18.0% /жилийн/
Үнэт цаасны хүү төлөгдөх давтамж	Улирал тутам
Үнэт цаасны хүү тооцох суурь хоног	365 хоног
Үнэт цаасны үндсэн төлбөр төлөгдөх хэлбэр	- 12 дахь сард 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг - 18 дахь сард 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг - 24 дэх сард 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг
Үнэт цаасны төлбөр төлөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт болох үндсэн болон хүүгийн төлбөр
Үнэт цаасны барьцаа	Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө бүхий хөрөнгийн багц, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд
Үнэт цаасны хүүд ногдох орлогын албан татварын хувь	5% (Давхар татварын гэрээтэй улс орны иргэн, хуулийн этгээдийн хувьд тус гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ).
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Си И Си Инвестмент ББСБ" ХХК-иас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багцлан худалдан авах
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК

Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргаагүй болно. Түүнчлэн үнэт цаас гаргахтай холбоотойгоор аливаа санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоолгоогүй болно.

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй ХБҮЦ-ны хөрөнгийн багц дараах байдалтай байна. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 716956
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Хүснэгт 2: Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцын мэдээлэл

Хөрөнгийн багцын үнийн дүн	3.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө
Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн тоо	154 зээл
Хөрөнгийн багц дахь зээлдэгчдийн тоо	154 зээлдэгч
Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур	Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцсэн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө байх бөгөөд санхүүгийн 27, хуулийн 6 шалгуур үзүүлэлтийг хангасан байхаар ТЗК-ийн ТУЗ-ийн тогтоолоор баталсан байна.

Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд оролцогч талууд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч / Үйлчилгээ үзүүлэгч	“Си И Си Инвестмент ББСБ” ХХК
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	“Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК
Аудитор	“Мүүрь аудит” ХХК
Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлт цуглуулах данс байрших банк	“Худалдаа хөгжлийн банк” ХХК
Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах данс байрших банк	“Худалдаа хөгжлийн банк” ХХК

Хүснэгт 4: Бусад баримт бичгүүд

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой журмууд	- Компанийн дүрэм; - ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; - Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам; - Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих журам; - Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон үйлчилгээ үзүүлэгчийг сонгох, солих тухай журам; - Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам; - Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлөх журам; - Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам; - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам.
Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогч талуудтай байгуулах гэрээнүүд	- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ; - Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ; - Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ; - Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;
Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд оролцогчидтой байгуулсан гэрээнүүд	- Андеррайтер-зуучлалын үйлчилгээний гэрээ; - Харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гэрээ /Зээлийн шинжилгээ/; Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ;
Бусад гэрээ	- Санхүүгийн тайланд аудит хийх ажлын гэрээ; - Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7168
9025080
ТИДИЙ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

1.2. Хөрөнгө оруулалтын онцлог, давуу тал

Тогтмол өндөр хүүтэй хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны хүүгийн хувь хэмжээ нь 2025 оны 6 дугаар сарын эцсийн байдлаарх банкны салбарын 24 сарын хугацаатай шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүүтэй харьцуулахад жилийн ойролцоогоор 4.5 хувиар, 2025 оны 7 дугаар сарын байдлаарх арилжааны банкнуудын 24 сарын хугацаатай хадгаламжийн зарласан дундаж хүүгээс 5.5 хувиар тус тус өндөр байна.

Зураг 1: ХБҮЦ-ны хүүгийн түвшний харьцуулалт



Эх сурвалж: Монголбанк, Хүү, хугацааны тайлан;
Арилжааны банкнуудын цахим хуудас;
Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж, Чингис хаан хөрөнгийн бирж

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хүү нь 2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн байдлаарх системийн нөлөө бүхий 5 банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн зарласан хүүгээс 5.5%-иар, бүх арилжааны банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн зарласан хүүгээс 4.9%-иар тус тус өндөр байна.

Бодит өгөөжийн түвшин өндөр

Хөрөнгө оруулагч нь ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг улирал тутам хүлээн авснаар дахин хөрөнгө оруулалт хийж, бодит өгөөжийн түвшнийг нэмэгдүүлэх боломжтой. Мөн нээлттэй хүрээнд санал болгож буй үнэт цаасны хувьд биржийн бус зах зээлд гаргасан хаалттай бонд болон банкны хадгаламжийн хүүгийн орлоготой харьцуулахад татварын давуу талыг эдлэх боломжтой байдаг. Тухайлбал биржийн бус зах зээлд гаргасан хаалттай бонд болон хадгаламжийн хүүгийн орлогоос 10%-ийн татвар төлдөг бол биржээр дамжуулан нээлттэй хүрээнд санал болгож буй ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 5%-ийн татвар төлдөг байна.

Шалгуур үзүүлэлт хангасан хөрөнгийн багц

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг сонгохдоо Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шалгуур, шаардлагыг хангуулахаас гадна хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны эргэн төлөлтийг баталгаажуулах зорилгоор санхүүгийн 27 шалгуур болон хуулийн 6 шалгуур үзүүлэлтүүдийг сонгон авсан. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэхийг хөндлөнгийн хууль болон аудитын байгууллагаар түүвэрлүүлэн шалгуулж, хараат бус хөндлөнгийн дүгнэлт гаргуулах замаар Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн чанар, хуулийн эрдэлийг баталгаажуулсан.

Эрсдэлийн түвшин багатай хөрөнгийн багц

ХБҮЦ нь хувийн төлөлттэй хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөөр баталгаажсан бөгөөд энэ нь хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт хугацаа хэтрэхгүйгээр товлосон хугацаандаа орж ирэх, Үнэт цаасны хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх бололцоог бүрдүүлнэ. Хэрэв тухайн хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь шалгуур үзүүлэлт хангахгүй болсон, чанаргүй болсон эсхүл ХБҮЦ-ны төлбөр төлөхөд хүндрэл учруулахаар нөхцөл байдал үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлийн

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ХХК
ШТЧ2842 7155869 9025080098
ТИ ДИ СИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах зохицуулалтууд холбогдох гэрээ хэлцлүүдэд тусгагдсан болно.

Найдвартай эргэн төлөлт

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагч руу шилжүүлж буюу худалдаж буй хөрөнгийн багцын нийт үлдэгдэл 3.3 тэрбум төгрөг, хөрөнгийн багцын жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 33.7 сар, жигнэсэн дундаж сарын хүү 2.9 хувь мөн зээл, барьцаа хөрөнгийн үнэлгээний жигнэсэн дундаж харьцаа 67.6 хувь байгаа бөгөөд ТЗК-ийн мөнгөн урсгалын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт буюу ТЗК-д орох мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны төлбөр болох хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийг гүйцэтгэхэд хангалттай түвшинд байна.

Ахлах төлбөр төлөх дараалал

Үнэт цаас гаргагчийн “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-д заасны дагуу ХБҮЦ-ны хүүгийн болон үндсэн төлбөр нь тэргүүн ээлжид буюу Үнэт цаас гаргагчийн төлөх бусад төлбөрүүдээс хамгийн эхэнд төлөгдөхөөр зохицуулагдсан болно. Мөн хөрөнгө оруулагчийн шаардлагыг энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц дахь бүх эрхээр хангана.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ ЭЙ
АССЕТ МЭНЭЖМЕНТ ТЗК
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

02

ҮЙЛЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

2.1. Хуулийн этгээдийн бүртгэл

Үнэт цаас гаргагч болох "Си И Си Ая Ассет Ван ТЗК" ХХК нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 42 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.7 болон 62.1.16 дахь заалт, Үүсгэн байгуулагч болох "Си И Си Инвестмент ББСБ" ХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, "Си И Си Инвестмент ББСБ" ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч "Си И Си групп" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 25/004 тоот шийдвэр, "Си И Си групп" ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч "Юнайтэд прожектс корпорэйшн" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 25/047 тоот шийдвэрийг тус тус үндэслэн үүсгэн байгуулагджээ.

Үнэт цаас гаргагч нь Хорооны 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 281 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор олгосон ТЗ 315/78 дугаартай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй байна.

Хүснэгт 5: Хуулийн этгээдийн бүртгэл

Компанийн нэр	"Си и Си Ая Ассет Ван ТЗК" ХХК
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2025.06.20
Хувийн хэргийн дугаар	9011880714
Регистрийн дугаар	7169569
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан огноо	2025.07.24
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	ТЗ 315/78
Биржид бүртгэлтэй эсэх	Үгүй
Хаяг	Улаанбаатар, Хан-Уул, 18-р хороо, Их Монгол Улс, Стадион оргил, 22, Моннис бьюлдинг 3 давхар
Утас	(976) 7772 5511
Вэб хуудас	www.ceci.mn

2.2. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө

Хүснэгт 6: Хөрөнгийн мэдээлэл

Зарласан хувьцааны тоо	1,000 ширхэг
Гаргасан хувьцааны тоо	1,000 ширхэг
Хувьцааны төрөл	Энгийн хувьцаа
Нэрлэсэн үнэ	1,000.0 (нэг мянга) төгрөг
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,000,000.0 (нэг сая) төгрөг
Хувьцаа эзэмшигчийн онооссон нэр	"Си И Си Инвестмент ББСБ" ХХК
Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийг эзлэх хувь	100 хувь

2.3. Хувьцаа эзэмшигчийн бүтэц

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169569 9025080098

ТИ ЛИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
9021110883
5251494
TDB SECURITIES

Үүсгэн байгуулагч болох “Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 (нэг мянга) ширхэг энгийн эрхийн хувьцааг буюу нийт гаргасан хувьцааны 100 хувийг дангаар эзэмшдэг Үнэт цаас гаргагчийн цорын ганц хувьцаа эзэмшигч байна.

2.4. Үүсгэн байгуулагчийн тухай

Үнэт цаас гаргагчийн Үүсгэн байгуулагч болох “Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь 2013 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр үүсгэн байгуулагдсан ба 2014 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Хорооноос ТЗ 101/399 тоот банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. Тус компани нь 2025 оны 2 дугаар улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа ба өөрийн 3 салбар, хамтрагч байгууллагын 3 цахим сувгаараа дамжуулан 22,000 орчим хувь хүн, ААН-үүдэд зээлийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 7: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Компанийн нэр	**“Си И Си Инвестмент ББСБ” ХХК**
Үүсгэн байгуулагдсан огноо	2013.11.01
Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо	2013.11.06
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	000295546
Хувийн хэргийн дугаар	9015005056
Регистрийн дугаар	5765919
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	- Зээлийн үйл ажиллагаа эрхлэх; - Санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх; - Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх.
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	ТЗ 101/399
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, Нью хоризонс оффис 7 давхар 702 тоот
Утас	(976) 7772 5511
Э-шуудан	info@ceci.mn
Вэб хуудас	www.ceci.mn

Хүснэгт 8: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хөрөнгийн мэдээлэл, 2025 оны 2 дугаар улирал

Зарласан хувьцааны тоо	5,000,000 ширхэг
Гаргасан хувьцааны тоо	5,000,000 ширхэг
Хувьцааны төрөл	Энгийн хувьцаа
Нэрлэсэн үнэ	1,000.0 (нэг мянга) төгрөг
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	5.0 тэрбум төгрөг
Өөрийн хөрөнгийн хэмжээ	9.7 тэрбум төгрөг
Нийт хөрөнгийн хэмжээ	17.4 тэрбум төгрөг

2.5. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын компанийн хувьд Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа эрхэлнэ. Шаардлагатай ажил, үйлчилгээг холбогдох гэрээний үндсэн дээр Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Үйлчилгээ үзүүлэгч, Захиргааны үйлчилгээ үзүүлэгч, Аудитын үйлчилгээ үзүүлэгчээр гүйцэтгүүлнэ. Компанийн бүтэц,

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ АССЕТ ВАНК ХХК
ШТЧ2842 169569 9025080098
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

зохион байгуулалт, удирдлага, бусад оролцогч, тэдгээрийн эдлэх эрх, үүргийг Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам", холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээгээр нарийвчлан зохицуулна.

2.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. дэх заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Үнэт цаас гаргагчийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад дараах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэхээр заажээ. Үүнд:

- Хорооны зөвшөөрлийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Үнэт цаас гаргагчийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах ба энэ тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Дүрэмд нэмэлт өөрчлөлтийг хөрөнгө оруулагчдад ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх;
- Үнэт цаас гаргагчийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Үнэт цаас гаргагчийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- Хуульд заасан бусад асуудал.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос баталсан холбогдох журам болон Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасантай зөрчилдөхгүй эрх эдэлж, үүрэг хүлээхээр заасан байна. Үүний хүрээнд хувьцаа эзэмшигч нь доор дурдсан болон бусад хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь Хорооноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй;
- Үнэт цаас гаргагчийн эсрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Үнэт цаас гаргагчийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор аливаа хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Үнэт цаас гаргагчид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх эрхгүй;
- Хууль болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийг татан буулгахаар хүсэлт гаргах эрхгүй байна.

2.7. Төлөөлөн Удирдах зөвлөл

Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэн эрх

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ хэрэгжүүлэхээр заасан байна. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компаниин дүрмиин хэрэгжилтийг хангуулах;
- Компаниин хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- Хөрөнгө итгэмжлэн удирлагч, үйлчилгээ үзүүлэгч болон хөндлөнгийн аудиторыг Хөрөнгөөр батлагдаагүй үнэт цаасны тухай хууль болон холбогдох журмын дагуу сонгох;
- ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагыг сонгохгүй бөгөөд Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэнд Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ ЭЙ АССЕТ МЭНЭЖМЕНТ ХХК
ШТЧ2842 169569
9025080098

TDB SECURITIES
TDB SECURITIES

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч, болон хөндлөнгийн аудитортой байгуулсан гэрээнд заасан эрх үүргийн дагуу тэдгээрт хяналт тавих, шаардлагатай тохиолдолд солих;
- Компанийн дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- ТУЗ нь Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20-р зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулж, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлснээс хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно;
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хангуулах мөн хэрэгжүүлэх;
- Компанийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;
- ТУЗ-ийн шийдвэр, холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлээс нэмж, хасах, солих;
- Хөрөнгө оруулагчдад мэдээллийг тогтмол, цаг тухайд нь хүргэх;
- Компанийн нээлттэй хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
- Хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, Компанийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдгийг эрх хүлээн авагчийн эзэмшилд шилжүүлэх бөгөөд эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь эрх хүлээн авагчтай бүх талаар хамтран ажиллах;
- Компанийн дүрэм, баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, баталгаат үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагын биелэлтийг хангах;
- Компанийн дүрэм, үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас гаргах өргөдлийг мөрдлөг болгон ТЗК байгуулагдсан гэдэгт баталгаа гаргах;
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хороо болон Улаанбаатар үнэт цаасны биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотоодоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- Хуульд заасан бусад.

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн ТЗК татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 12 тоот "Журам батлах тухай" тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба тус журмаар ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрх, зохион байгуулалттай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Тус журамд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэмд заасан үндэслэлээр томилох ба ТУЗ нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар тусгасан байна. Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д заасан шаардлага болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нэмэлт шаардлагыг хангасан байхаар заажээ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7169
9025080
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ТЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүд

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь хэсэгт Төлөөлөн Удирдах зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар заасан байна.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хурлын 25/047 тоот шийдвэрээр Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн дарга, 1 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар томилсон байсан бол Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хурлын 25/007 тоот Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн чөлөөлөх, томилох тухай шийдвэрээр Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 1 ердийн гишүүн болон 1 хараат бус гишүүнийг чөлөөлж 2 хараат бус гишүүн томилсон байна.

Мөн Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 02 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилсон байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт 9: Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга

Нэр, албан тушаал	Товч намтар
 **А.Гэрэлт-Од** ТУЗ-ийн дарга	**Боловсрол** - ХУИС – Орчуулагч; - СЭЗИС – Санхүү Удирдлага, Магистр; - ОУСДС – Эдийн засагч. **Ажлын туршлага** - 2024 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК-д үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, - 2022 – 2024 – МИК Холдинг ХК, Дотоод аудитор; - 2019 – 2022 – Улаанбаатар Капитал ХХК, Аудитор; - 2009 – 2019 – Улаанбаатар Хотын банк, Дотоод аудитор.
 **Л. Хонгорзул** ТУЗ-ийн хараат бус гишүүн	**Боловсрол** - Millennium city academy, Лондон – Санхүүч, MBA; - СЭЗДС – Банкны менежмент, Магистр; - ШУТИС-ХоМТС – Мэдээллийн технологич, Бакалавр. **Ажлын туршлага** - 2024 – Одоо – Дижитал информэшин ассессмент ХХК, Олон улсын гэрээт аудитор; - 2024 – 2024 – Инфо сек плас ХХК, ISO27001 төслийн зөвлөх; - 2017 – 2022 – МИК ОССК ХХК, Үйл ажиллагааны эрсдэлийн ахлах шинжээч; - 2014 – 2017 – Вэма ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал; - 2006 – 2014 – Капитрон банк ХХК, Эдийн засагч, Эрсдэлийн шинжээч, Эрсдэлийн Удирдлагын газрын захирал; - 2002 – 2006 – Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Программист.



Б.Түмэннасан
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол
- МУИС – Эрх зүйч;
- МУИС - Хууль зүйн сургууль, Эрх зүйч.

Ажлын туршлага
- 2024 – Одоо – Ньюком Групп, Хуульч;
- 2024 – 2024 – Наран Мандал Энтерпрайзес ХХК, Хууль, комплайнсын хэлтсийн дарга;
- 2023 – 2024 – Ай Ди Эм Эн ХХК, Хуульч;
- 2023 – 2023 – Таван богд Трэйд ХХК, Хуулийн ахлах зөвлөх;
- 2020 – 2023 – МИК Рийл Эстэйт ХХК, Хуульч;
- 2017 – 2019 – МИК ОССК ХХК, Хуульч.



Х.Батцэцэг
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Боловсрол
- МУИС – Эрх зүйч.

Ажлын туршлага
- 2022 – Одоо – Юнайтэд прожектс корпорэйшн ХХК, Оффис менежер, захирлын туслах;
- 2016 – 2022 – Нью яармаг хаусинг прожект ХХК, Захиргааны ажилтан;
- 2010 – 2016 – Энержи ресурс ХХК, Захиргааны ажилтан, хүний нөөц.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг Үүсгэн байгуулагчтай байгуулсан “Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ” болон Үнэт цаас гаргагчийн “Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хэрэгжүүлнэ.





019

2.8. Үйл ажиллагаа

2.8.1. Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд үүсгэн байгуулагдсан “Си и Си Ая Ассет Ван ТЗК” ХХК буюу Үнэт цаас гаргагчийн үнэт цаасжуулах хэлцлийн үйл ажиллагаа нь дараах шат дараалалтай явагдана. Үүнд:

Зураг 2. Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглал



Тайлбар:

1. Үнэт цаас гаргагчийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багцлан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авахтай холбоотой түүнд тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-аас тогтоох;
2. Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авч буй хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь талуудын тохиролцсон санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг шалгах зорилгоор хөндлөнгийн зээлийн шинжилгээ гаргагч болон хуулийн зөвлөх компани нь тус тусын арга аргачлалаар зээлийн хөрөнгийг түүвэрлэн сонгон авах замаар бие даасан, хараат бус дүгнэлтийг гаргах;
3. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт эрх бүхий зохицуулах байгууллагад хүргүүлж, ХБҮЦ гаргах зөвшөөрөл авах;
4. Эрх бүхий зохицуулах байгууллага нь зөвшөөрөл олгосноор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгох замаар анхдагч зах зээлийн арилжаар зохион байгуулах, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх, арилжаа амжилттай болсон талаар Хороонд тайлан хүргүүлэх;
5. Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэх буюу худалдан авч, хөрөнгийн багцыг бүртгэснээр хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжсэнд тооцох бөгөөд автомашины фидуцийн барьцааны эрхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлснээр хөрөнгө оруулагчийн шаардлагыг зээлийн хөрөнгө, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүдээр хангах боломжтой болно;
6. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн шилжүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169508 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110 8 52251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан 25/05 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд Үнэт цаас гаргагч нь гэрээний хүрээнд тохиролцсон шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө, түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд болох Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэн буюу худалдан авч, тус гэрээнд заасан үнийг төлөхөөр заасан байна.

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд тусгасан нөхцөл, санхүүгийн 27 болон хуулийн 6 шалгуур үзүүлэлтийг хангасан байх ба Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй талуудтай хамтран ажиллах үүрэг хүлээхээр тусгажээ.

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн Зээлийн шинжилгээ гаргагч байгууллага болох "Релаэнс секюритиз аудит" ХХК, хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг хөндлөнгийн Хуулийн фирм болох "Өмгөөллийн ЭмДиЭс Энд Хаанлекс" ХХН тус тус багцын хөрөнгөөс санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн данснуудад хөндлөнгийн шинжилгээ хийж, бие даасан хараат бус дүгнэлт гаргасан байна.

Хуулийн шалгуур үзүүлэлтүүд

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь дараах 6 хуулийн шалгуур үзүүлэлт хангасан ба үүнээс 3 шалгуур нь хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд, 3 шалгуур нь түүний барьцаа хөрөнгийн хувьд тавигдсан шалгуур үзүүлэлтүүд байна. Үүнд:

I. Зээлийн хөрөнгийн хувьд

1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг фидуци/барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
3. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;

II. Барьцаа хөрөнгийн хувьд

1. Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлборийг гаргуулах боломжтой байх,
2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас омно дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамаарууллан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
3. Фидуцийн гэрээ үүнээс төгөлдөр болгохоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрдөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
ASSET BAN ТЭ
ХХК
ШТЧ2842 7169
9025080099

TDB SECURITIES
TDB SECURITIES

Хөндлөнгийн хууль зүйн шинжилгээний товч дүгнэлт

“Өмгөөллийн ЭмДиЭс Энд Хаанлекс” ХХН нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан “Хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний хүрээнд Үнэт цаас гаргагчийн “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авахаар тохиролцсон Автомашины фидуци бүхий 154 зээлийн хөрөнгөөс 26 зээлийн хөрөнгийг түүвэрлэн авч, сонгогдсон зээлийн хөрөнгүүдийн хувьд хуулийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг шалган баталгаажуулж, 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг бэлтгэсэн. Тус тайлангаар санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэсэн 26 зээл нь хуулийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан гэж үзсэн байна.

Түүнчлэн хуулийн фирм нь “Си И Си Ая Ассет Ван ТЗК” ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгохтой холбогдуулан 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр Хууль зүйн дүгнэлт гаргасан бөгөөд дүгнэлтээр ТЗК нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах шийдвэр, ТЗК-ийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогчид нь ашиг сонирхлын зөрчилгүй болоод үнэт цаасны танилцуулга дахь хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв болохыг тодорхойлж дүгнэлт гаргасан байна.

Зээлийн дүн шинжилгээний тайлан болон Хуулийн дүгнэлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт баримт бичгээс үзнэ үү.

Санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь дараах 27 санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан ба үүнээс 19 шалгуур нь хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд, 6 шалгуур нь зээлдэгчийн хувьд, 2 шалгуур нь түүний барьцаа хөрөнгийн хувьд байна.Үүнд:

I. Зээлийн хөрөнгийн хувьд

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлэх;
2. Хөрөнгийн багцад дараахь хөрөнгийг оруулаагүй байх:
   - дуусаагүй барилга, сул чөлөөтэй газрын барьцаа;
   - зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хуульд заасан эрх бүхий этгээдээс тогтоосон хэмжээнээс хэтэрсэн барьцаат зээл;
   - хугацаа хэтэрсэн хөрөнгө.
3. Хөрөнгийн багцаас орох орлого нь баталгаат үнэт цаасны дагуу хүлээсэн үүргийг (багцад багтсан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг) гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх;
4. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр (хөрөнгө дэх зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр) нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас багагүй байх;
5. Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг зээл олгох үйл ажиллагаанд баримтладаг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан;
6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс тогтоосон хэмжээний урьдчилгаа төлбөр, холбогдох хүүгийн шимтгэл, төлбөрийг төлсөн байх;
7. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;
8. Зээлийн санхүүжилтийн дүн нь бүрэн олгогдсон байх;
9. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;
10. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;
11. Тасалбар болгох өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгчийн үүрэг хүлээсэн нийт зээл нь Үнэт цаас гаргагчид өмнө нь худалдагдаагүй, төлөгдөөгүй, өр төлбөрийн үүрэггүй байх;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7168569 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
5511494
TDB SECURITIES

022

12. Тасалбар болгосон өдрөөрх хөрөнгийн багцын олгосон зээлийн жигнэсэн дундаж хэмжээ 20 сая төгрөгөөс ихгүй байх;
13. Хөрөнгийн багц дахь нэг зээлийн хүүгийн хэмжээ сарын 2.3%-иас багагүй, тогтмол төлөгдөх нөхцөлтэй байх;
14. Хөрөнгийн багцын жигнэсэн дундаж зээлийн хүүгийн хэмжээ сарын 2.7%-иас багагүй байх;
15. Тасалбар болгосон өдрөөрх хөрөнгийн багц дахь нэг зээлийн үлдэгдэл хугацаа 10 сараас доошгүй байх;
16. Тасалбар болгосон өдрөөрх хөрөнгийн багцын жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа 30 сараас доошгүй байх;
17. Үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа өдрийн байдлаар зээлийн үлдсэн хугацаа нь зээлийн нийт хугацааны 30%-иас доошгүй байх;
18. Тасалбар болгосон өдрөөрх жигнэсэн дундаж зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) нь зээлийн багцын хувьд 75%-иас хэтрэхгүй байх, тухайлсан зээлийн хувьд 80%-иас хэтрэхгүй байх;

ЗҮХ = (Анх олгосон эсвэл дахин санхүүжүүлсэн зээлийн хэмжээ) / (Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ)

19. Зээлийн багцын мэдээлэл нь зээлийн үндсэн баримттай нийцэж байх.

II. Зээлдэгчийн хувьд

1. Монгол Улсад оршин суудаг Монгол Улсын иргэн байх;
2. Эрх зүйн чадамжтай, 18-аас дээш настай байх;
3. Үндсэн зээлдэгч нь 6 сараас багагүй хугацаанд хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн алба хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байх. Үндсэн зээлдэгчийн орлого хүрэлцэхгүй тохиолдолд хамтран зээлдэгчийн орлогыг судлах;
4. Зээлдэгчийн өрхийн орлогын хэмжээ сарын 800,000 төгрөгөөс доошгүй байх;
5. Зээл олгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
   - 2025.01.01-ний өдрөөс өмнө олгосон зээлүүдийн хувьд зээлдэгчийн өр орлогын харьцаа нь нийт орлогын 80%-иас илүүгүй байх;
   - 2025.01.01 - 2025.04.01-ний өдрийн хооронд олгосон зээлүүдийн хувьд зээлдэгчийн өр орлогын харьцаа нь нийт орлогын 70%-иас илүүгүй байх;
   - 2025.04.01-ний өдрөөс хойш олгосон зээлүүдийн хувьд зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) нь нийт орлогын 60%-иас илүүгүй байх;

ӨОХ = Тухайн зээлийн сарын төлбөр / (Сарын орлого)

6. Зээл олгосон өдрийн байдлаар Үндсэн болон хамтран зээлдэгч нь Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн /хувь хүний хувьд 15 хоногоос дээш, хуулийн этгээдийн хувьд 30 хоногоос дээш хэтэрсэн/, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй, шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй байх;

III. Барьцаа хөрөнгийн хувьд

1. Фидуцийн гэрээний зүйл нь зээл олгох өдрийн байдлаар даатгалд даатгагдсан байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх);
2. Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх.

Зээлийн шинжилгээ гаргагчийн хараат бус дүгнэлт

УЛААНБААТАР ХОТ
СИ И С
ASSET BAN
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
9021110883
TDB SECURITIES

“Релаэнс секюритиз аудит” ХХК нь Үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцсон ажил үйлчилгээний дагуу Хөрөнгийн багцаас санамсаргүй түүврийн аргаар 35 зээлийн хөрөнгийг сонгон авч, сонгогдсон зээлийн хөрөнгүүдийн хувьд санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар хараат бус зээлийн шинжилгээг Үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцсон шинжилгээний горимын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Зээлийн шинжилгээ гаргагч нь 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн “Ажил үйлчилгээний үр дүнгийн тайлан”-гаар сонгогдсон 35 зээл нь зээлийн хөрөнгө, зээлдэгч, барьцаа хөрөнгө болон багцын хувьд тавигдаж байгаа нийт 27 санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзсэн байна.

Зээлийн шинжилгээний тайлантай холбоотой дэлгэрэнгүйг хавсралт баримт бичгээс үзнэ үү.

2.8.2. Хөрөнгийн багцын тойм

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны баталгаа болох 2025 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багц нь 154 зээлдэгчийн нийт 3.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан 154 зээлийн гэрээнээс бүрдсэн ба тасалбар болгох өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 10: Хөрөнгийн багцын тойм мэдээлэл

Хөрөнгийн төрөл	Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө
Хөрөнгийн чанар	100 хувь хэвийн төлөлттэй зээлийн хөрөнгө
Зээлийн хөрөнгийн үлдэгдэл дүн	3,311,176,917.90 төгрөг
Анх олгосон дүн	4,114,298,076.27 төгрөг
Зээлийн хөрөнгийн тоо	154 зээл
Зээлдэгчдийн тоо	154 зээлдэгч
Зээлийн дундаж үлдэгдэл	21,501,149 төгрөг
Жигнэсэн дундаж хүү (сар)	2.91%
Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа	43.7
Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа	33.7
Жигнэсэн дундаж зээл, үнэлгээний харьцаа (LTV)	67.6%


Хөрөнгийн багцын төвлөрлийн талаар

Хөрөнгийн багц дахь 154 зээлээс 61.7 хувь нь 20 сая хүртэлх үлдэгдэл дүнтэй байгаа нь зээлийн төвлөрөл харьцангуй бага байгааг харуулж байна. Харин зээлийн үлдэгдлийн хэмжээний хувьд 6.9 хувийг 0-10 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээл, 30.6 хувийг 10-20 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээл, 24.1 хувийг 20-30 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээл тус тус эзэлсэн буюу 30 сая төгрөг хүртэлх үлдэгдэл дүнтэй 127 ширхэг зээл нийт зээлийн хөрөнгийн талаас дээш буюу 61.6 орчим хувийг эзэлж байна. Харин 30-85 сая төгрөг хүртэлх 27 зээл нийт зээлийн багцын 38.4 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүний 9.3 нэгж хувийг 30-40 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээл, 13.9 хувийг 40-50 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээл, 8.5 нэгж хувийг 50-60 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээл, үлдсэн 6.7 хувийг 60 сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэй 3 зээл бүрдүүлжээ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭ
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Зураг 3: Зээлийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээний тархалт, зээлийн тоогоор



Зураг 4: Зээлийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээний тархалт, үлдэгдэл дүнгээр



Хөрөнгийн багц дахь хамгийн өндөр дүнтэй зээл нь 84.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба хамгийн их дүнтэй 10 зээлүүд нь нийт хөрөнгийн багцын 18.2%-ийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11: Хамгийн их дүнтэй зээлүүд

Төрөл	Үлдэгдэл, төгрөг	Хөрөнгийн багцад эзлэх хувь
Хамгийн их дүнтэй 1 зээл	84,115,819.4	2.5%
Хамгийн их дүнтэй 5 зээл	340,711,461.1	10.3%
Хамгийн их дүнтэй 10 зээл	603,100,520.3	18.2%
Хамгийн их дүнтэй 20 зээл	1,042,032,324.2	31.5%


Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн олгосон огнооны талаар

Хөрөнгийн багц дахь анхны зээл нь 2023 оны 1 дүгээр сард олгогдож, сүүлчийн зээл нь 2025 оны 7 дугаар сард олгогдсон байна. Зээлүүдийг олгосон огнооны тархалтаар авч үзвэл 2023 оны 1 болон 2 дугаар улиралд олгогдсон зээлийн тоо хөрөнгийн багцад хамгийн бага байгаа буюу ту тус 1 ширхэг байгаа бол 2024 оны 2 дугаар улиралд олгогдсон зээлийн тоо хамгийн их буюу 36 ширхэг байна.


УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗ
ХХК
ШТЧ2842 7169
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Зураг 5: Зээлийн хөрөнгийн олгосон огнооны тархалт, зээлийн тоогоор



Зураг 6: Зээлийн хөрөнгийн олгосон огнооны тархалт, үлдэгдэл дүнгээр



Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хугацааны талаар

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн жигнэсэн дундаж анхны хугацаа нь 43.7 сар байгаа ба хамгийн богино хугацаатай олгогдсон зээл нь 12 сарын хугацаатай, хамгийн урт хугацаатай нь 55 сарын хугацаатай байна. Зээлийн хөрөнгийн дийлэнх буюу 91 ширхэг нь 48 сарын хугацаатай олгогдсон байна.

Зураг 7: Зээлийн хөрөнгийн хугацаа, зээлийн тоогоор



Харин зээлийн үлдэгдлийн хугацаагаар 24 ба түүнээс дээш сарын үлдэгдэлтэй зээлийн тоо 113 байгаа бөгөөд туз зээлүүл нь нийт хөрөнгийн бүтцын 83.8% буюу 2.8 тэрбум төгрөгийг бүрдүүлж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ
ХХК
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

Зураг 8: Зээлийн хөрөнгийн үлдэгдэл хугацааны тархалт, үлдэгдэл дүнгээр



Зураг 9. Зээлийн үлдэгдэл хугацааны тархалт, тасалбар болгосон өдрөөр



Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн талаар

Хөрөнгийн багц дахь зээлүүдийн ихэнх буюу 48.7% нь 2028 онд эргэн төлөгдөхөөр байгаа бөгөөд тус зээлүүд нь үлдэгдэл дүнгээрээ нийт хөрөнгийн багцын 52.8%-ийг бүрдүүлж байна. Харин 2028 оны эцэс гэхэд төлөгдөж дуусах зээлийн нийт үлдэгдэл дүн нь нийт хөрөнгийн багцын 73.7 хувийг, зээлийн тоогоороо 82.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 10: Зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн огнооны тархалт, зээлийн тоогоор



Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшин

Зээлийн багцын нийт зээлийн 39.0 хувь нь сарын 2.9 хувь буюу түүнээс бага хүүтэй байгаа бол тус зээлүүдийн тасалбар болгосон өдрийн үлдэгдэл дүн нь нийт зээлийн багцын 40.0 хувийг эзэлж байна. Нийт зээлүүдээс хамгийн олон нь буюу 88 зээл нь сарын 3.0 хувийн хүүтэй байгаа бол сарын 3.1 болон 3.5 хувийн хүүтэй зээл

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ АССЕТ ВАН ТЭК ХХК
ШТЧ2842 7169569
9025080098
ТИ ДИ ВИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

хамгийн бага буюу тус тус 3 зээл байна. Зээлийн багцын жигнэсэн дундаж сарын хүү нь 2.9 хувь, хамгийн өндөр хүү нь 3.5 хувь бөгөөд хамгийн бага зээлийн хүү нь 2.5 хувийн дүнтэй байна.

Хүснэгт 12: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хүүгийн түвшний тархалт

№	Зээлийн хүү	Зээл		Анх олгосон зээл		Зээлийн үлдэгдэл дүн	
		Тоо	Эзлэх хувь	Хэмжээ, төгрөг	Эзлэх хувь	Хэмжээ, төгрөг	Эзлэх хувь
1	2.5%	12	284,525,000.0	284,525,000.0	7.0%	228,548,665.8	6.9%
2	2.6%	6	185,307,000.0	185,307,000.0	4.5%	152,495,130.5	4.6%
3	2.7%	11	279,140,000.0	279,140,000.0	6.8%	224,349,645.4	6.8%
4	2.8%	12	368,100,000.0	368,100,000.0	9.0%	312,321,975.6	9.4%
5	2.9%	19	506,500,000.0	506,500,000.0	12.1%	407,449,456.1	12.3%
6	3.0%	88	2,264,036,076.3	2,264,036,076.3	55.0%	1,827,525,170.6	55.2%
7	3.1%	3	162,240,000.0	162,240,000.0	4.0%	119,665,086.7	3.6%
8	3.5%	3	64,450,000.0	64,450,000.0	1.6%	38,821,787.2	1.2%
Нийт		**154**	**100.0%**	**4,087,598,076.3**	**100.00%**	**3,311,176,917.9**	**100.00%**
Хамгийн бага		**2.4%**					
Хамгийн их		**3.5%**					
Жигнэсэн дундаж хүү		**2.9%**					

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн барьцаа хангалт

Барьцаа хангалт буюу хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн анх олгосон дүн болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хөрөнгийн багцын хувьд жигнэсэн дундаж үзүүлэлтээр 67.6 хувь байгаа буюу багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Хүснэгт 13: Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн барьцаа хангалтын харьцаа

№	LTV	Зээлийн тоо		Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээлийн үлдэгдэл дүн	
		Тоо	Эзлэх хувь	Дундаж дүн, төгрөг	Дүн, төгрөг	Эзлэх хувь
1	20.0-30.0%	3	1.9%	32,833,333	20,887,035	0.6%
2	30.0-40.0%	7	4.5%	94,714,286	236,970,266	7.2%
3	40.0-50.0%	7	4.5%	80,500,000	223,565,804	6.8%
4	50.0-60.0%	22	14.3%	41,195,455	487,690,812	14.7%
5	60.0-70.0%	40	26.0%	37,572,500	863,333,079	26.1%
6	70.0-80.0%	75	48.7%	34,477,067	1,478,729,922	44.7%
Нийт		**154**	**100.0%**		**3,311,176,917.9**	**100.00%**
Хамгийн бага		**20.0%**				
Хамгийн их		**80.0%**				
Жигнэсэн дундаж LTV		**67.6%**				

2.8.3. Худалдах, худалдан авах гэрээ

Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нар нь 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр 25/05 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг хангасан Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгө, түүний авлагын баталгаа эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ ЛИЗИНГ ХХК
ШТЧ2842 7169569
9025080058

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

түүний дагалдах эрхүүдийг Үнэт цаас гаргагчид худалдан шилжүүлэх, Үнэт цаас гаргагч нь тус гэрээнд заасан үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна.

"Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-гээр Үнэт цаас гаргагч нь хэлцэл биелэх өдөр дараах хөрөнгө болон түүнд дагалдах эрхийг хөрөнгийн багц болгон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлэх буюу худалдан авч, тус гэрээнд заасан үнэ болох 3.0 тэрбум төгрөгийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид худалдахаар харилцан тохиролцжээ. Үүнд:

- Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлийн хөрөнгийн хувьд түүний авлагын шаардах эрх буюу Зээлийн гэрээний дагуу Зээлдэгчийн төлбөл зохих үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү зэрэг төлбөрийг шаардах, төлбөр цуглуулах, нэхэмжлэл гаргах, Зээлийн төлөлтийг хүлээж авахтай холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхүүд, мөн холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүд;
- Автомашины зээлийн авлагын шаардах эрхийг баталгаажуулж буй Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасны дагуу фидуцийн зүйлүүдийн өмчлөх эрхийг барьцаалах, Гэрээнд заасан барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлж, захиран зарцуулахтай холбоотой бүхий л эрх;
- Автомашины болон жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой хохирол нөхөн төлөхийг шаардах эрх;
- Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан Автомашины зээлийн хөрөнгөтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, Эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, Зээлдэгч болон түүний хамтран зээлдэгч бусад Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдэд холбогдуулан шаардлага гаргах, шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх;
- Зээлийн хөрөнгөтэй холбоотой бүхий л баримт бичгүүд, үүнд зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, даатгалын гэрээний баталгаа, Фидуцийн гэрээ, Фидуцийн хөрөнгөтэй холбоотой баримт бичиг болон бусад зээл, барьцаа, батлан даалтын хөрөнгөтэй холбоотой баримт бичгүүдийг шилжүүлэн авч, хадгалах эрх.

"Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдах хөрөнгийн хэмжээг хэлцэл биелэх өдрийн байдлаарх хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох ба уг дүн нь хэлцэл биелэх үнэ болох 3.0 тэрбум төгрөгөөс багагүй байна.

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулалтаас татан төвлөрүүлэх дүнг амжилттай татан төвлөрүүлсэн тохиолдолд хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш ажлын 3 өдөрт багтаан тус гэрээний үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

Хөрөнгө шилжүүлэх буюу худалдах

Үнэт цаас гаргагч нь тус гэрээнд заасан үнийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрэн төлж, хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчийн өмчлөлд бүрэн шилжүүлэх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хэлцэл биелэх өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан хөрөнгийн болон барьцааны эрхийн холбогдох бүртгэлийг хийнэ.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцын бүх эрх, ашиг сонирхол, үр ашгийн цорын ганц, эрхийн доголдолгүй эцсийн өмчлөгч тул хэлцэл биелэх өдрийн байдлаар болон уг өдрөөс хойших хугацаанд аливаа эрхийн доголдолгүй хөрөнгийн багцыг Үнэт цаас гаргагчид шилжүүлнэ.

Хөрөнгийн бүртгэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгийн багцыг өөрийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд холбогдох эрхүүдийн хамт шилжүүлэн бүртгэх үйл ажиллагааг Үнэт цаас гаргагчтай хамтран хэрэгжүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ СИ И СИ АЙ ЭССЕТ ВАН ТЗК ХХК ШТҮ2842 7169569 9025080098

СИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ХХК ТДБ SECURITIES 5251494 9021110883 TDB SECURITIES

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн жагсаалтад тусгагдсан автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн бүртгэлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар гүйцэтгүүлнэ. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай бүр Хөрөнгийн жагсаалтыг шинэчилнэ.

Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн барьцаа

Үнэт цаас гаргагч нь худалдан авч буй хөрөнгийн багц дахь автомашины зээлийн хөрөнгийн авлагын шаардах эрхийг баталгаажуулах зорилгоор Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг гэрээний хүрээнд худалдаж буй Хөрөнгийн багц дахь Автомашины зээлийн хөрөнгийн Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд заасны дагуу Үнэт цаас гаргагчид барьцаалуулна. Ингэхдээ Зээлдэгчээс зөвшөөрөл авах шаардлагатай бол Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь уг зөвшөөрлийг авах ажлыг өөрийн зардлаар, бие даан хариуцна.

Талууд нь Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний хавсралтаар фидуцийн зүйл болох автомашинуудын жагсаалтыг баталж, үнэт цаас гаргагч нь холбогдох бүртгэлийг эрх бүхий байгууллагад хийлгүүлэх бөгөөд уг жагсаалтад тусгагдсан фидуцийн зүйлийн мэдээлэл болон холбогдох бүртгэлийг хөрөнгийн багцад өөрчлөлт орох тухай бүрт шинэчилнэ.

Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасны дагуу фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг үл маргах журмаар шилжүүлэн авах эрхтэй бөгөөд Үнэт цаас гаргагч нь уг өмчлөх эрхийн дагуу Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүхий л эрхийг хэрэгжүүлж, фидуцийн зүйлийг захиран зарцуулах, түүнээс олох орлогыг авах эрхтэй байна.

Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл үүссэн тухай мэдсэн даруй фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдсоноор тухайн мэдэгдэлд заасан хугацааны дотор фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэх буюу шилжсэнд тооцож, эрх бүхий байгууллагын хөрөнгийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажиллагааг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хийж гүйцэтгэх эрхтэй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон бусад шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэхүү үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд заасан Фидуцийн зүйлийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэхгүй, барьцаалахгүй болон бусад аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй, түүний эрхийн байллыг доройтуулахгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь фидуцийн зүйлээс барьцаалуулсан шаардлагыг хангуулах эрхтэй цор ганц эрх бүхий этгээд байна.

Талуудын баталгаа, мэдэгдэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгөтэй холбоотой дараах баталгаа болон мэдэгдлийг Үнэт цаас гаргагчид гаргасан байна. Үүнд:

1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Хэлцэл биелэх өдрийн байдлаар Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан болно.
2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон Фидуцийн зүйл нь аливаа эрхийн болон биет байдлын хувьд доголдолгүй, өмчийн маргаангүй, дан ганц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд байх бөгөөд тэдгээрийг Үнэт цаас гаргагчийн өмчлөлд шилжүүлэхэд аливаа хязгаарлалт байхгүй болно.
3. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө, фидуцийн зүйлтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, Зээлийн гэрээ болон Фидуцийн гэрээнд зааснаас өөр нэмэлт үүрэг байхгүй болно.
4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгч болон Зээлдэгчийн хамааралтай этгээд, Фидуцийн зүйлтэй холбоотой дараах сөрөг нөлөөтэй байж болохуйц аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл дампуурлын хэрэг үүсгэх талаар мэдэгдэл, мэдээлэл аваагүй болно. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169
9025080058
TDB SECURITIES
TDB SECURITIES

- Зээлдэгч болон түүний хамааралтай этгээдийн Хөрөнгөтэй холбоотой хүлээсэн үүргээ биелүүлэх чадвар доройтоогүй байна.
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон Фидуцийн зүйлтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх хэрэгжих нөхцөл, эрхийн хүчин төгөлдөр байдал Гэрээний үргэлжлэх хугацаанд бүрэн хангагдсан байна.

5. Зээлдэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой аливаа үүргээ Хэлцэл биелэх өдөр хүртэл хэрэгжүүлж биелүүлсэн байх, үүргийн зөрчил бий болсон тохиолдолд уг зөрчлийг арилгасан, ийнхүү арилгасан зөрчлийг Үнэт цаас гаргагчид хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч болон Аудитор шалган баталгаажуулах боломжтой байна.
6. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд Зээлийн баримт бичгүүд, Зээлийн данс бүртгэл болон Зээлийн хувийн хэрэг нь зохих ёсоор бүрэн гүйцэт бүртгэгдэж, хадгалагдах бөгөөд Хэлцэл биелэх өдрийн байдлаар уг баримт бичиг нь бүрэн гүйцэт ба шинэчлэгдсэн байдлаар Үнэт цаас гаргагчийн өмчлөлд шилжсэн байна.
7. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон Фидуцийн зүйлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа үүсээгүй байна.
8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргээ бүрэн биелүүлж байгаа бөгөөд Зээлийг санхүүжүүлсэн эх үүсвэр нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан хориглогдсон эх үүсвэр биш болно.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дараах нийтлэг баталгаа болон мэдэгдлийг Үнэт цаас гаргагчид гаргасан байна. Үүнд:

- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд эдгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр, журам, хууль тогтоомжийг зөрчихгүй болно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээгээр зээлийн хөрөнгийг худалдах буюу шилжүүлэх, фидуцийн зүйлийг барьцаалуулах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л бэлтгэл ажлыг хангасан болно.
- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээнд хавсаргасан баримт бичиг, мэдээ, мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт болно.

Түүнчлэн тус гэрээгээр хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах, талуудын эрх, үүргийг тусгасан байна.

2.8.4. Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ

Үнэт цаас гаргагч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нар нь 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр 25/06 тоот “Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ”-г байгуулсан бөгөөд тус гэрээгээр “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу шилжүүлж буй хөрөнгийн багц дахь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг Үнэт цаас гаргагчид барьцаалуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна.

Барьцааны зүйл нь талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний хүрээнд тодорхойлогдсон хөрөнгийн нэг хэсэг бөгөөд уг хөрөнгөтэй салшгүй холбоотой байна.

Барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах

Талуудын хооронд байгуулагдсан Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон Үнэт цаас гаргагчийн баталсан Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад өөрчлөлт орсон тохиолдолд тухайн хөрөнгө болон түүнтэй холбогдон барьцааны зүйлд мөн өөрчлөлт орж, барьцаа хөрөнгийн жагсаалт шинэчлэгдэнэ.

Барьцаагаар хангагдах шаардлага

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7169
9025080098

ТДБ ЭНД ЭЙ ЦЭНЭГЛЭЛТ ҮНЭТ ЦААС ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Барьцаагаар хангагдах шаардлага нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан худалдах хөрөнгө болон түүний дагалдах эрхээр тодорхойлогдоно.

Барьцааны баталгаажилт

Үнэт цаас гаргагч нь барьцааны эрхийг баталгаажуулах зорилгоор тус гэрээний хавсралтад заасан барьцаа хөрөнгийн жагсаалт дахь барьцааны зүйл тус бүрээр хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг үйлдэж, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу тээврийн хэрэгсэл тус бүрийн сериал дугаараар Хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

Барьцааны зүйлтэй холбоотой мэдэгдэл
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь барьцааны зүйлтэй холбоотой аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг Эрх бүхий байгууллага, Зээлдэгч болон бусад аливаа этгээдээс хүлээн авсан тохиолдолд энэ талаар Үнэт цаас гаргагчид Ажлын 3 өдөрт бичгээр мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Тэргүүн ээлжид шаардлага хангуулах

Үнэт цаас гаргагч нь тус гэрээний дагуу барьцаалж буй барьцааны зүйлээр бусад аливаа шаардлагаас тэргүүн ээлжид үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Барьцааны зүйлийг бусдад шилжүүлэх болон барьцаалахгүй байх

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тус гэрээ хүчин төгөлдөр үргэлжлэх хугацаанд зээлдэгчийн зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдэхээс бусад тохиолдолд барьцааны зүйлийн өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр бусад этгээдэд шилжүүлэхгүй, барьцаалахгүй, тийнхүү шилжүүлэхээр амлахгүй байх үүрэгтэй.

Барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах

Зээлийн хөрөнгөтэй холбоотой хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах нөхцөл байдал үүссэн, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг буцаан худалдан авах үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах замаар фидуцийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлж захиран зарцуулна.

Үнэт цаас гаргагч нь Барьцаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Фидуцийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай мэдэгдлийг бичгээр болон цахим хэлбэрээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлнэ.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн мэдэгдлийг хүлээж авсан буюу хүлээж авсанд тооцогдох өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор фидуцийн зүйлийн өмчлөх эрх нь Үнэт цаас гаргагчид үл маргах журмаар шилжинэ. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь татан буугдах, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг хэрэгжүүлэгч байхгүй болсон зэрэг шалтгааны улмаас мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь энэ заалтыг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

Үнэт цаас гаргагч нь фидуцийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх бүртгэлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран холбогдох эрх бүхий байгууллагад хийлгэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хамтран ажиллах боломжгүй байх эсхүл хамтран ажиллахаас үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийн бүртгэлийг бие даан эрх бүхий байгууллагад хийлгэнэ.

Үнэт цаас гаргагч нь фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш түүнийг гуравдагч этгээдэд худалдан борлуулах, захиран зарцуулах эрхтэй байна.

Баталгаа, мэдэгдэл

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ
АССЕТ ВАН ТЗ
ХХК
ШТЧ2842 7169109
9025080059

ТИ ДИ СИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дараах баталгаа, мэдэгдлийг гаргасан байна. Үүнд:

1. Барьцааны зүйлийн цор ганц хууль ёсны өмчлөгч мөн болохыг;
2. Барьцааны зүйлд аливаа гуравдагч этгээдийн барьцааны эрх, шаардах эрх үүсээгүй, барьцааны зүйл нь аливаа эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг;
3. Барьцааны зүйлийн хууль ёсны өмчлөлийг баталгаажуулахад шаардлагатай бүхий л бүртгэлийг холбогдох байгууллагуудад хийлгэсэн бөгөөд эдгээр нь хүчин төгөлдөр хэвээр байгаа болохыг;
4. Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг байгуулах, биелүүлэх болон түүнтэй холбоотойгоор хийсэн аливаа хэлцэл нь Монгол Улсын хууль, тогтоомж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үүсгэн байгуулах болон бусад баримт бичгүүдтэй зөрчилдөхгүй болохыг;
5. Барьцааны эрх нь тус гэрээгээр үүсэж байгаа бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шийдвэр, хүсэлтээр эсхүл Анхны үүрэг гүйцэтгүүлэгч дампуурсан нь уг эрх хүчингүй болох үндэслэл болохгүй болохыг.
6. Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг байгуулах, биелүүлэх бүрэн эрхтэй бөгөөд түүнтэй холбоотой бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан болохыг;
7. Гаргаж өгсөн бүхий л мэдээлэл нь тухайн мэдээллийг гаргаж өгсөн өдрийн байдлаар үнэн зөв, бүрэн, тодорхой бөгөөд төөрөгдүүлсэн утга агуулагдуй болохыг;
8. Үнэт цаас гаргагчийн эрхэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болохуйц үр дагавартай, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эсхүл барьцааны зүйлд холбогдох шүүхийн, арбитрын болон эвлэрүүлэн зуучлалын маргаан байхгүй болохыг үүгээр баталсан байна.

2.8.5. Үйл ажиллагааны ерөнхий тайлбар

Үнэт цаас гаргагч болох “Си и Си Ая Ассет Ван ТЗК” ХХК нь үнэт цаасжуулах хэлцлийг амжилттай хэрэгжүүлснээр үндсэн үйл ажиллагаа нь дараах загварын хүрээнд явагдана. Үүнд:

1. Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай “Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулсны хүрээнд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг зээлдэгчдээс цуглуулан, зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд хуримтлуулна;
2. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад үнэт цаасны төлбөр болох үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлнө;
3. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагчтай “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ” байгуулах ба хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тус гэрээ болон Үнэт цаас гаргагчийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам” болон бусад журмуудад нийцүүлэн Үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг гүйцэтгэнэ;
4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь холбогдох журам, гэрээнд заасны дагуу зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон толбор цуглуулах дансны мэдээллэлд үндэслэн зээлийн эргэн төлөлт, багцын эргэн төлөлт, Төлбөр цуглуулах данснаас хийж байгаа зарцуулалт, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх ХБҮЦ-ны төлбөр зориулалтын бусаар захиран зарцуулагдахаас сэргийлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллана;
5. Үнэт цаас гаргагчийн холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу эрх бүхий байгууллагууд болон хөрөнгө оруулагчдад тогтоосон хугацаанд хүргэж ажиллана;
6. Үнэт цаас гаргагч нь хөндлөнгийн аудитортой гэрээ байгуулах замаар үйл ажиллагаанд аудит хийлгэнэ.

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 04 тоот тогтоолоор “Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам”-ыг баталсан бөгөөд Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 12 тоот тогтоолоор үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дараах журмуудыг тус тус баталсан байна. Үүнд:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
2. Хөрөнгө итгэмжлэн удирдах журам;
3. Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам;
4. Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам;
5. Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам;
6. Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7188589 90250800
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ТЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

7. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам.

Түүнчлэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 12-1 тоот тогтоолоор "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам"-ыг баталсан байна.

Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-аар Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд гаргаж буй автомашины зээлийн авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийн хангах фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулах, бүртгэлийг хөтлөх, хөрөнгийн багцын болон зээл тус бүрийн чанарт хяналт тавих, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөх, болон Үнэт цаас гаргагчийн холбогдох хууль тогтоомж, журам, гэрээгээр хүлээх төлбөрийн үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагч, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан байна.

Төлбөр цуглуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын ажил үүрэг

Төлбөр цуглуулахад Үйлчилгээ үзүүлэгч нь дараах голлох ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулсан байна. Үүнд:

1. Хөрөнгийн багц дахь зээл тус бүрийн сар бүрийн эргэн төлөлтийг зээлдэгчээс цуглуулж, хөрөнгийн багцын эргэн төлөлтийг Үнэт цаас гаргагчид шилжүүлнэ;
2. Зээлийн эргэн төлөлтийг цуглуулахдаа зээлийн эргэн төлөлтийн графикийг үндэслэх бөгөөд зээлийн эргэн төлөлтийн графикийг Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид гаргаж өгнө;
3. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө тус бүрийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлөлт болон хуримтлагдсан хүү, зээлийн хөрөнгийн үлдэгдэл, хугацаа хэтэрсэн хоног, түүнд хуримтлагдсан хүүгийн дүн, илүү төлөлтийн мэдээлэл зэргийг Зээлийн эргэн төлөлтийн графиктай нь тулган бүртгэсэн зээлийн данс бүртгэлийн тайланг сар бүрийн сүүлд нэгтгэн гаргаж, дараа сарын ажлын 5 өдрийн дотор Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид Үнэт цаас гаргагчийн зээлийн эргэн төлөлтийн дансны баталгаажсан дэлгэрэнгүй хуулганы хамт ирүүлнэ;
4. Зээлийн эргэн төлөлт болох багцын эргэн төлөлтийг Үнэт цаас гаргагчийн зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд сар бүрийн 04-ний өдөрт цуглуулах ба цуглуулах өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр шилжүүлнэ;
5. Хуримтлагдсан Зээлийн эргэн төлөлт болох Багцын эргэн төлөлтийг бүтэн дүнгээр нь Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах дансанд дээрх заалтад заасан өдрийн дараагийн өдөрт багтаан шилжүүлнэ. Хэрэв Багцын эргэн төлөлтийг шилжүүлэх өдөр нь амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөрт багтаан шилжүүлнэ;
6. Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зөвшөөрлийн дагуу ХБҮЦ-ны Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд Зээлдэгчийн хүсэлт, бусад шалтгаанаар Зээлийн гэрээ, төлбөрийн хуваарь болон бусад нөхцөлд өөрчлөлт оруулсан бол энэ талаарх мэдээллийг Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс ажлын 2 өдөрт багтаан цахим шуудангаар болон бичгээр мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт, оорчлолт орсноор Хөрөнгийн багц дахь зээлийн хорогийн хувьд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс болон Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон, Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны төлбөр төлөх чадварт сөргөөр нөлөөлөхүйц гэж Хөрөнгө итгэмжлэн удирдагч, эсхүл Үнэт цаас гаргагчийн зүгээс үзсэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авна;
7. Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийг бусад хөрөнгөнөөс ялгаж, тусад нь бүртгэнэ;
8. Хөрөнгийн багц дахь зээл бүрийн хувийн хэрэг, материал, түүнтэй холбоотой бичмэл бичиг, мэдээллийг хадгалах, хамгаалах, өөрийн зээлийн багцаас тусад нь Үнэт цаас гаргагчруу шилжүүлсэн зээлийн дансуудын бүртгэлийг үнэн зөв бүртгэж хөтөлнө;
9. Шаардлагатай тохиолдолд Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гарган хүргүүлэх, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг, зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гарган хүргүүлэх, өөрийн гаргасан

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169569 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу боловсруулах бөгөөд гаргасан дүгнэлтийн үнэн зөв, бүрэн гүйцэт байдлыг бие даан хариуцна;

10. Хөрөнгийн багцтай холбоотой баримт бичиг, мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгч хадгалах бөгөөд Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зүгээс хүсэлт тавьсны дагуу холбогдох баримт бичигтэй танилцах боломжийг хангаж ажиллана;
11. Зээлийн эргэн төлөлт цуглуулах данснаас гүйлгээ хийх, удирдах эрхтэй бөгөөд тус журамд заасны дагуу багцын эргэн төлөлтийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхээс бусад зорилгоор зээлийн эргэн төлөлт цуглуулах дансан дахь мөнгөн хөрөнгийг зарцуулахгүй, зарлагын гүйлгээ хийх эрхгүй байна;
12. Тус журам болон гэрээнд тусгасан нөхцөл болон Үнэт цаас гаргагч, эсхүл хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаа, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, албан хүсэлтийн дагуу үйлчилгээг үзүүлнэ;
13. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд зээлдэгчтэй харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө Үнэт цаас гаргагчийг төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн графикт заасан хугацаанд цуглуулж, Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
14. Холбогдох данс, бүртгэл, тайланд зөрүү гарсан бол зөрүүг илрүүлсэн өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгө итгэмжлэн удирдагчтай тооцоо нийлж, алдааг засах арга хэмжээ авна;
15. Үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг үнэт цаасны хөрөнгийн багцад буй зээлдэгчид хүргүүлнэ;
16. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, холбогдох журам болон гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт Үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулна;
17. Өөрийн үйл ажиллагааны улмаас Үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллана;
18. Төлбөр цуглуулах үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор гарсан аливаа шимтгэл, хураамж нь үйлчилгээний хөлсөд багтсан бөгөөд үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас тусад нь нэхэмжлэх эрхгүй байна;
19. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү журамд заасан үйлчилгээг үзүүлэхдээ Үнэт цаас гаргагчид гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэх чадамжтайгаа илэрхийлэн бичгээр баталгаа гаргана;
20. Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах албан тушаалтныг томилон ажиллуулах бөгөөд тухай албан тушаалтны холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлнэ. Хэрэв Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчтай харилцах албан тушаалтан өөрчлөгдсөн бол энэ талаар Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид ажлын 2 өдрийн дотор цахим шуудангаар эсхүл бичгээр мэдэгдэнэ;
21. Хууль тогтоомж болон журамд заасан бусад.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөр цуглуулах үйл ажиллагаанд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулсан байна. Үүнд:

1. Үйлчилгээ үзүүлэгчээс Үнэт цаас гаргагчийн төлбөр цуглуулах данс руу шилжүүлж буй багцын эргэн төлөлтийг зээлийн данс бүртгэлтэй тулгаж, хяналт тавих;
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багц дахь зээлийн багцын чанар, эргэн төлөлтөл хяналт тавьж, гар бүр зээлийн багцын маягын тайланг үйлчилгээ үзүүлэгчээс хүлээн авах, хөрөнгийн багц дахь зээлд хугацаа хэтрэлт үүссэн нөхцөлд зээлийн эргэн төлөлтийг хийлгэх арга хэмжээг Үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хэрэгжүүлэх, үилчилгээ үзүүлэгчээс эргэн төлөлтийн үр дүн авч, хянах;
3. Үнэт цаас гаргагчийг төлөөлж шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гаргуулах, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг болон зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гаргуулан авч, түүнд хяналт тавих;
4. Үйлчилгээ үзүүлэгч нь ХБҮЦ-ны багцын эргэн төлөлтийг хуваарийн дагуу Үнэт цаас гаргагчийн төлбөр цуглуулах данс руу шилжүүлээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийг ажлын 10 хоногт багтаан уг зөрчлийг арилгах талаар мэдэгдэл хүргүүлэх;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЭК ХХК
ШТЧ2842 7168869 9025080068

ТДБ СЕКЬЮРИТИС ХХК
TDB SECURITIES
9021168 9251494

5. Үйлчилгээ үзүүлэгчийн хэвийн үйл ажиллагаа доголдсон, зохицуулагч байгууллагын зүгээс үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд нь хязгаарлалт тавьсан, гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай аливаа зөвшөөрлийг цуцалсан, дампуурах нөхцөл байдал бий болсон болон ХБҮЦ-ны хөрөнгийн багцын хяналт болон эргэн төлөлтийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч этгээдийн зөрчлийн тохиолдол гэж үзэн, шинээр үйлчилгээ үзүүлэгчийн томилох ажиллагааг Үнэт цаас гаргагчтай хамтран "Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам"-ын дагуу хэрэгжүүлэх;
6. Үнэт цаас гаргагч болон үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах ажилтныг томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх, үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг Үнэт цаас гаргагч болон үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх, хэрэв тухайн ажилтан өөрчлөгдсөн бол энэ талаар Үнэт цаас гаргагч болон үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх;
7. Төлбөр цуглуулах данснаас хийж байгаа зарцуулалт, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх ХБҮЦ-ны төлбөр зориулалтын бусаар захиран зарцуулагдахаас сэргийлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
8. Хууль тогтоомж болон журамд заасан бусад.

Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйл ажиллагаанд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр зохицуулсан байна. Үүнд:

1. Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь Төлбөр цуглуулах данснаас зөвхөн дор заасны дагуу зарцуулалт хийх бөгөөд Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх ХБҮЦ-ны төлбөр зориулалтын бусаар захиран зарцуулагдахаас сэргийлж ажиллана. Энэхүү ажиллагаанд Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Үнэт цаас гаргагч хяналт тавин ажиллана.
2. Үнэт цаас гаргагчийн Төлбөр цуглуулах дансанд цугларсан Багцын эргэн төлөлтөөс зөвхөн дараах гүйлгээг гүйцэтгэнэ. Үүнд:
   - Үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрийг ҮЦТХТ-ийн данс руу шилжүүлэх;
   - Үнэт цаас эзэмшигчдийг иргэн бол Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч, Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчөөр, эсхүл хуулийн этгээд бол Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчөөр тус тус ангилан холбогдох татварын хувь хэмжээг тодорхойлон татвар ногдуулж төсөвт төлөх бөгөөд Давхар татварын гэрээтэй улс орны иргэн болон хуулийн этгээдийн хувьд төлөх буюу суутгах татварын хувь хэмжээг тухайлсан гэрээний дагуу тогтооно;
   - Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой доорх зардлуудыг төлөх. Үүнд:
     - Аж ахуй нэгжийн орлогын албан татвар;
     - Төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал;
     - Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
     - Хөндлөнгийн аудитын төлбөр;
     - Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, түрээс, үйл ажиллагааны зардал,
     - Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
     - Тодорхой нөхцөл;
     - Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн хөрөнгө худалдан авах;
     - Бусад ТЗК-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлууд.
   - Дээрх төлбөрүүдийг бүрэн төлж гүйцэтгэсэн тохиолдолд үлдсэн сул мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах зорилгоор Үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлэн Үнэт цаас гаргагчийн дүрэм, холбогдох журам, гэрээнд заасны дагуу байршуулах.

Мөн тус журамд Үнэт цаасны төлбөрийг төлөх, төлбөрийн зарцуулалтын талаар доорх зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хамт төлбөрүүдийг нийлүүлэгч нь төсөв гарган батлах бөгөөд төлбөрүүдийг тухай бүр Төлбөр цуглуулах данснаас шууд төлнө.

УЛААНБААТАР ХОТ СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЭЖ ХХК ШТЧ2842 7169599 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК TDB SECURITIES

2. Үнэт цаас гаргагч нь журамд дурдсанаас бусад зардал гаргахгүй бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэр, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө болон Үнэт цаасны төлбөрийг төлөхөд зайлшгүй зардал гаргах шаардлага үүсвэл ТУЗ-ийн хурлаар уг асуудлыг хэлэлцэж, зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ-ийн тогтоолд заасан хэмжээгээр уг зардлыг нэмж гаргана.

Үнэт цаас гаргагчийн төлбөрийн дараалал

ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө[1]. Үүнд:.

1. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
2. ХБҮЦ-ны хүүгийн орлогын албан татвар;
3. ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
4. Үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор үүссэн зардал (Андеррайтер, зээлийн шинжилгээ гаргагч, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр, үнэт цаас танилцуулах аяны зардал);
5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
6. Хөндлөнгийн аудитын төлбөр;
7. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, түрээс, үйл ажиллагааны зардал;
8. Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
9. Захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
10. Бусад Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлууд;
11. Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д заасны дагуу сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг байршуулах;
12. Журамд заасан бусад зардал.

Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ

Үнэт цаас гаргагч нь үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчтай "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх" гурван талт гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээгээр нэг талаас үйлчилгээ үзүүлэгч нь зээлдэгчтэй харилцаж, хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цаг тухайд нь цуглуулан, Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, зээл тус бүр болон хөрөнгийн багц дахь зээлийн чанарт хяналт тавих, тус гэрээнд заасны дагуу хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үзүүлэх болон нөгөө талаас хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг

Үйлчилгээ үзүүлэгч нь тус гэрээний хүрээнд дараах чиг үүрэгтэй байхаар талууд харилцан тохиролцжээ. Үүнд:

1. Тус гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас түүнд бичгээр өгсөн зааварчилгаа, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, албан хүсэлтийн дагуу үйлчилгээг үзүүлэх;
2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд зээлдэгчтэй харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээ авч зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө Үнэт цаас гаргагчийг төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн графикт заасан хугацаанд Үнэт цаас гаргагчид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
3. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө тус бүрийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлөлт болон хуримтлагдсан хүү, зээлийн хөрөнгийн үлдэгдэл, хугацаа хэтэрсэн хоног, түүнд хуримтлагдсан хүүгийн дүн, илүү төлөлтийн мэдээлэл зэргийг зээлийн эргэн төлөлтийн графиктай нь тулган бүртгэсэн зээлийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайланг сар бүрийн сүүлд гаргаж, дараа сарын ажлын 5 өдрийн дотор Үнэт цаас

[1] Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий байгууллагуудад төлөх үүрэг хүлээж буй төлбөр болон Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулахтай холбоотой үүсэх зөрүүг төлбөрийн дарааллыг харгалзахгүй, бүхий бүр төлж барагдуулна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ ЭССЕТ ВАН ТЭЙ ХХК
ШТЧ2842 7186569
9025080098
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ХХК
TDB SECURITIES

гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид ТЗК-ийн зээлийн эргэн төлөлтийн дансны баталгаажсан дэлгэрэнгүй хуулганы хамт ирүүлэх;

4. Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн зөвшөөрлийн дагуу ХБҮЦ-ны Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд зээлдэгчийн хүсэлт, бусад шалтгаанаар зээлийн гэрээ, төлбөрийн хуваарь болон бусад нөхцөлд өөрчлөлт оруулсан бол энэ талаарх мэдээллийг Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс ажлын 2 өдөрт багтаан цахим шуудангаар болон бичгээр мэдэгдэнэ. Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноор хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс болон "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон, Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны төлбөр төлөх чадварт сөргөөр нөлөөлөхүйц гэж хөрөнгө итгэмжлэн удирдагч, эсхүл Үнэт цаас гаргагчийн зүгээс үзсэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу арга хэмжээ авах;
5. Хөрөнгийн багц дахь зээл бүрийн хувийн хэрэг, материал, түүнтэй холбоотой баримт бичиг, мэдээллийг хадгалах, хамгаалах, өөрийн зээлийн багцаас тусад нь Үнэт цаас гаргагч руу шилжүүлсэн зээлийн дансдын бүртгэлийг үнэн зөв бүртгэж хөтлөх;
6. Шаардлагатай тохиолдолд Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гарган хүргүүлэх, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг, зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гарган хүргүүлэх, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу боловсруулах бөгөөд гаргасан дүгнэлтийн үнэн зөв, бүрэн гүйцэт байдлыг бие даан хариуцах;
7. Үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг ХБҮЦ-ны хөрөнгийн багцад буй зээлдэгчид хүргүүлэх;
8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон тус гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ямагт Үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах;
9. Өөрийн үйл ажиллагааны улмаас Үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх бөгөөд сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллах;
10. Хууль тогтоомж болон журамд заасан бусад.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүрэг

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тус гэрээний хүрээнд дараах чиг үүрэгтэй байхаар талууд харилцан тохиролцжээ. Үүнд:

1. Үйлчилгээ үзүүлэгчээс Үнэт цаас гаргагчийн төлбөр цуглуулах данс руу шилжүүлж буй багцын эргэн төлөлтийг зээлийн данс бүртгэлтэй тулгаж, хяналт тавих;
2. Хөрөнгийн багц дахь зээлийн багцын чанар, эргэн төлөлтөд хяналт тавьж, сар бүр зээлийн багцын чанарын тайланг үйлчилгээ үзүүлэгчээс хүлээн авах, хөрөнгийн багц дахь зээлд хугацаа хэтрэлт үүссэн нөхцөлд зээлийн эргэн төлөлтийг хийлгэх арга хэмжээг үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчээс эргэн төлөлтийн үр дүн авч, хянах;
3. Үнэт цаас гаргагчийг төлөөлж шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах үйлчилгээтэй холбоотой аливаа дүгнэлт гаргуулах, түүнд шаардагдах мэдээлэл, баримт бичиг болон зээлийн эргэн төлөлтийн дансны хуулга, түүний үлдэгдлийн талаарх мэдээллийг гаргуулан авч, түүнд хяналт тавих;
4. Үйлчилгээ үзүүлэгч нь ХБҮЦ-ны багцын эргэн төлөлтийг хуваарийн дагуу ТЗК-ийн төлбөр цуглуулах данс руу шилжүүлээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийг ажлын 10 хоногт багтаан уг зөрчлийг арилгах талаар мэдэгдэл хүргүүлэх;
5. Үйлчилгээ үзүүлэгчийн хэвийн үйл ажиллагаа доголдсон, зохицуулагч байгууллагын зүгээс үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд нь хязгаарлалт тавьсан, Гэрээнд заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай аливаа зөвшөөрлийн нүшлэсэн, лицензүүрах нөхцөл бийлэл бий болсон болон ХБҮЦ-ны Хөрөнгийн багцын хяналт болон эргэн тололтийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч этгээдийн Зорчлийн тохиолдол гэж үзэн, шилээр үйлчилгээ үзүүлэгчийн холилох ажиллагааг ТЗК-тай хамтран "Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам"-ын дагуу хэрэгжүүлэх;
Үнэт цаас гаргагч болон үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах ажилтныг томилох бөгөөд түүнтэй холбоо барих мэдээлэл, түүний эрх үүрэг болон бусад шаардлагатай мэдээллийг Үнэт цаас гаргагч болон

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7100569
9025080098

ТДБ ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЦК ХХК
TDB SECURITIES

үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх, хэрэв тухайн ажилтан өөрчлөгдсөн бол энэ талаар Үнэт цаас гаргагч болон үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх;

7. Хууль тогтоомж болон журамд заасан бусад.

Үйлчилгээ үзүүлэгч

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "Үйлчилгээ үзүүлэгч нь үүрэг гүйцэтгэгч буюу зээлдэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна" гэж тодорхойлсон ба мөн тус хуулийн 19 дугаар зүйлийн 19.8 дахь хэсэгт Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх боломжтой байхаар заажээ. Үүний хүрээнд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 10 тоот "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоолоор Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох "Си И Си Инвестмент ББСБ" ХХК-тай болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулахыг зөвшөөрсөн ба тус гэрээний хүрээнд үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх бүрэн чадамжтай болох тухай баталгаа, мэдэгдлийг мөн тусгасан байна.

Үйлчилгээ үзүүлэгч нь "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-гээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй эсвэл холбогдох хууль, журамд заасан бусад үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тус гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ байгуулах эрхтэй ба үүнтэй холбогдох харилцааг "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ", Үнэт цаас гаргагчийн "Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам" болон бусад холбогдох хууль тогтоомж, журмаар нарийвчлан зохицуулжээ. Мөн тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн Үнэт цаас гаргагчид үзүүлэх үйлчилгээний хөлс нь улирал тутам 18.0 сая төгрөг байхаар тохирсон байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдах журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-аар хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах замаар хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөр болон бусад үүргийг гүйцэтгэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлэн хадгалах, удирдахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчдын хоорондын харилцааг зохицуулсан байна.

Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн тайлан, мэдээлэлд үндэслэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэн авсан хөрөнгийн багц дах зээлийн хөрөнгө нь ХБҮЦтХ-ийн 9 дүгээр зүйл болон Үнэт цаас гаргагчаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангахааргүй болсон тохиолдолд энэ талаар үнэт цаас гаргагчид нэн даруй мэдэгдэнэ.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн шийдвэрт үндэслэн хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулж болно. Үүнд:

1. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих;
2. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх;
3. Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэгчээс сар бүр ирүүлсэн хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл болон Үнэт цаас гаргагчийн төлбөр цуглуулах дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зээлийн эргэн төлөлтийн графикийн дагуу тулган баталгаажуулах замаар, хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд хяналт тавьж ажиллах ба тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүнийг илрүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор энэ тухай Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэж, тус журамд тусгасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗ
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

TDB SECURITIES

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих нөхцөл

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь доор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, журамд заасны дагуу шаардлага хангасан хөрөнгөөр солино. Үүнд:

1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны төлбөр төлөх чадварт сөргөөр нөлөөлөхүйц байна гэж Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзсэн;
2. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-нд заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;
3. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь хуанлийн 30 болон түүнээс дээш хоногоор хэтэрсэн бөгөөд цаашид зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон нь холбогдох баримтаар нотлогдсон;
4. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоног хэтэрсэн;
5. Зээлийн хөрөнгийн шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн (Зээлдэгч нас барсан, сураггүй алга болсон, төлбөрийн чадваргүй болсон, зээл болон фидуцийн зүйлтэй холбоотой асуудлаар маргаан үүссэн, Зээлдэгчээс гомдол, санал гарсан гэх мэт).

Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх нөхцөл

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөтэй холбоотой дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлж болох бөгөөд энэхүү нэмэгдүүлэх хөрөнгө нь хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур үзүүлэлт хангасан байна. Үүнд:

-Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1 дэх заалтад заасны дагуу Баталгаат үнэт цаасны Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь мөн тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангахгүй болсон;
-Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон.

Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдах нөхцөл

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь доор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдана. Үүнд:

1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасан Шаардлага хангахгүй хөрөнгийг солих зорилгоор Орлуулах хөрөнгийн жагсаалтыг Үнэт цаас гаргагчид гаргаж өгөөгүй, эсхүл уг жагсаалтад багтсан зээлийн хөрөнгө нь шаардлага хангаагүй тохиолдолд тухайн хөрөнгийн багцын шаардлага хангаагүй хэсгийг хэсэгчлэн болон бүтнээр нь буцаан худалдах;
2. Үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөртэй холбоотой төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцон Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь үлдэгдэл дүнгээр буцаан худалдаж болно;
3. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 30 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн бөгөөд Зээлдэгч цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон эсхүл Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд;
4. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцон Хөрөнгийн багцыг буцаан худалдаж болно.

Үнэт цаас гаргагчийн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагч ийн нэрийн өмнөөс Төлбөр цуглуулах данснаа хуримтлагдсан Багцын эргэн төлөлтөөс Үнэт цаас гаргагчийн Төлбөрийн дараалалын дагуу төлөгдөх хуваарьт төлбөрийн

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ АССЕТ ВАНТЗ ХХК
ШТЧ2842 7168959 9025080658

ТИЙДИЙН СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

үүргүүдийг гүйцэтгэх хүртэл хугацаанд болон гүйцэтгэсний дараа сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг Үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлэн холбогдох хууль, тогтоомж болон зохицуулагч байгууллагын журам, зааварт нийцсэн санхүүгийн хэрэгсэлд байршуулах замаар хөрөнгө оруулалт хийж болох бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь уг хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөжтэй холбоотой шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж, ТЗК-ийн төлбөрийн чадварт аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л хүчин чармайлтыг гарган ажиллана.

Үнэт цаас гаргагчийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулахтай холбоотойгоор "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

-Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаатай холбоотой харилцааг холбогдох хууль, журам болон "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-гээр зохицуулах бөгөөд тус хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэл, өгөөжийг Үнэт цаас гаргагч хариуцна;
-Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг хийсэн тохиолдолд хагас улирал бүр тухайн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д танилцуулна;
-Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын дуусах хугацааг Үнэт цаас гаргагчийн төлбөр гүйцэтгэх чадвар, ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарь, түүний төлөх боломжтой байдлаар уялдуулж ажиллана;
-Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг хийхийн өмнө болон хийснээс хойших хугацаанд тухайн хөрөнгө оруулалт нь аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсгэх, эрсдэл дагуулахаар байна гэж Хөрөнгө итгэмжлэн удирдагч эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ үзсэн тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтыг зогсоож, шаардлагатай мөнгөн хөрөнгийг гарган авах үйл ажиллагааг цаг алдалгүй зохион байгуулна;
-Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт байршуулахдаа Үнэт цаас гаргагчийг төлөөлөн гэрээ байгуулах, зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт байршуулахтай холбоотой Төлбөр цуглуулах данснаас холбогдох төлбөр гүйцэтгэх талаар Захиргааны үйлчилгээ үзүүлэгчид даалгавар өгөх, бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээ

Үнэт цаас гаргагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлох зорилгоор "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-г байгуулсан байна.

Тус гэрээний дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн хувьд түүний эргэн төлөлтийг үйлчилгээ үзүүлэгчээс хүлээн авах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөх, Үнэт цаас гаргагчийн хууль тогтоомж, журам болон гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд хамтрах, хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцүүлэн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг удирдах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэхээр харилцан тохиролцсон байна.

Уг гэрээнд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас эзэмшигчдийн өмнө дараах голлох үүргийг хүлээнэ. Үүнд:

- Өөрийн үйл ажиллагаанд тус гэрээ болон Үнэт цаас гаргагчийн батлан мөрдөж буй журмуудын холбогдох зохицуулалтыг тусгах гэрээнд нийцүүлэн дагаж мөрдөх;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн авлагын шаардах эрхийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгын хүрээнд Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн Фидуцийн болон шаардах эрхийн барьцааны эрхийг Хөдлөх эд хөрөнгийн цахим мэдээллийн санд бүртгүүлсэн эсэхэд хяналт тавих;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс батлагдсан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавих;

СИ И СИ АЙ ACCET ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169569 9025080098
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883 5251494
TDB SECURITIES

- Хөрөнгийн багцад хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбогдох хугацаанд Хөрөнгийн багцад холбогдох өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлэх багцын эргэн төлөлтийг хүлээн авах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөх, хууль тогтоомж, журам, гэрээгээр хүлээсэн болон холбогдох бусад төлбөр тооцоог хийхтэй холбоотойгоор үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмыг баримтлан хэрэгжүүлэх, хяналт тавих;
- Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг хийсэн тохиолдолд энэ тухай хагас улирал бүр Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д тайлагнах;
- Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн Хөрөнгийн багцыг эзэмших, бүртгэх, хяналт тавих;
- Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн Хөрөнгийн багцыг удирдах.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл үүргээ биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой болсон тохиолдолд тус гэрээг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн шийдвэрээр цуцалж, Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журамд заасны дагуу шинэ хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгож, гэрээ байгуулна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч

Хүснэгт 14: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ерөнхий мэдээлэл

“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК	
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо:	2006.11.14
Хувийн хэргийн дугаар:	9011019084
Регистрийн дугаар:	5096235
Үйл ажиллагааны чиглэл:	- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах; - Орон сууцны салбарт бизнесийн зөвлөгөө өгөх; - Хөрөнгө итгэмжлэн удирдах.
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот
Утас:	11-328267, 11-317933
Вэб хуудас:	www.mik.mn
Цахим шуудан:	info@mik.mn

“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК нь Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэх зорилгоор хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдээр дамжуулан гадаад, дотоодын зах зээл дээр дунд болон урт хугацааны санхүүжилтийг босгох замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх санхүүгийн зуучлагч компани хэлбэрээр байгуулагдсан.

“МИК ОССК” ХХК нь Хорооноос 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 510/01 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2013 оноос хойш хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулсан 37 тусгай зориулалтын компаниудаа хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг явуулж байна.

Хувьцаа эзэмшигч

“МИК ОССК” ХХК-ийн цорын ганц хувьцаа эзэмшигч нь Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “МИК Холдинг” ХК бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг дангаар хэрэгжүүлдэг байна.

Төлөөлөн Удирдах зөвлөл

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ МАНТЭЙ ХХК
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд үүнээс 6 нь ердийн гишүүн, 3 нь хараат бус гишүүн байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар "МИК ОССК" ХХК ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт 15: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ТУЗ-ийн гишүүд

Нэр, албан тушаал	Товч намтар
Ч.Хашчулуун ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн	Эдийн засагч мэргэжилтэй ба Монгол Улсын Их Сургуулийн Дэд профессор. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны дарга, Санхүү, аудитын хорооны гишүүн.
А.Энхжин ТУЗ-ийн ердийн гишүүн	Санхүүч мэргэжилтэй ба Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Тогтвортой хөгжлийн хорооны гишүүн.
Б.Сайнзаяа ТУЗ-ийн ердийн гишүүн	Бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжилтэй ба Монгол Улсын Хөгжлийн банкны Төслийн санхүүжилтийн газрын захирал. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн.
М.Мөнхбаатар ТУЗ-ийн ердийн гишүүн	Банк санхүүч мэргэжилтэй ба "Азиа дайверсифайд рийл истэйт фанд нэг" ХХК-ийн Зөвлөх. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүн.
Т.Даваажав ТУЗ-ийн ердийн гишүүн	Банк санхүүч мэргэжилтэй ба Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хорооны гишүүн.
Н.Сэргэлэн ТУЗ-ийн ердийн гишүүн	Нягтлан бодогч мэргэжилтэй ба Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Тогтвортой хөгжлийн хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн.
Б.Үүрцайхбаатар ТУЗ-ийн ердийн гишүүн	Банк санхүүч мэргэжилтэй ба Капитрон банкны Гүйцэтгэх захирал. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн.
А.Анар ТУЗ-ийн хараат бус гишүүн	Эдийн засагч, хөрөнгө оруулалтын менежмент мэргэжилтэй ба "Синержи Фанд Солюшн УЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал. "МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүн.


УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ
АССЕТ ВАН
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251104
TDB SECURITIES

Э.Шижир ТУЗ-ийн хараат бус гишүүн	Санхүүч, мэдээлэл зүйч мэргэжилтэй ба Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийн удирдагч. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хорооны дарга болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо, Тогтвортой хөгжлийн хорооны гишүүн.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар хөрөнгө итгэмжлэн удирдагчийн байгууллагын бүтэц зохион байгуулалт дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 11: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн бүтэц, зохион байгуулалт



Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын баг дараах байдалтай байна. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
ASSET MANAGEMENT
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ГИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Хүснэгт 16: Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл

Нэр, албан тушаал	Мэдээлэл
 **Б.Гантулга** Гүйцэтгэх захирал	Б. Гантулга нь МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг санхүүч, эдийн засагч мэргэжлээр бакалавр, Австралийн Үндэсний Их сургуульд санхүүгийн салбарын магистрын зэрэгтэй төгссөн байна. Тэрээр Сангийн яаманд мэргэжилтэн, Олон улсын валютын санд Стэндбай хөтөлбөр хариуцсан ажилтан, Азийн хөгжлийн банкны хувийн хэвшлийн газарт хөрөнгө оруулалт хариуцсан ажилтан, “УБ Капитал” ХХК-ийн Дэд захирал, Улаанбаатар хотын банканд Газрын захирал, Сангийн яаманд Зээл, тусламжийн бодлого, Засгийн газрын өрийн удирдлага эрхэлсэн Газрын захирлаар тус тус ажиллаж байсан нийт 20 гаруй жилийн ажлын туршлагатай. 2017 оноос хойш “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдож одоог хүртэл ажиллаж байна.
 **Д.Отгонбилэг** Эрсдэл хариуцсан дэд захирал	Д.Отгонбилэг нь МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. Тэрээр Сэргээн босголт банканд эдийн засагч, Хадгаламжийн банканд хянан шалгагч, Интер банканд Ахлах хянан шалгагч, Улаанбаатар хотын банканд Газрын захирал болон Худалдаа, хөгжлийн банканд Гүйцэтгэх захирлын орлогч зэрэг албан тушаалд ажиллаж байсан нийт 27 жилийн ажлын туршлагатай. “МИК ОССК” ХХК-ийн Эрсдэл хариуцсан Дэд захирлын албан тушаалд 2021 оноос хойш томилогдон ажиллаж байна.
 **Ц.Батбаяр** Бизнес хөгжил хариуцсан дэд захирал	Ц.Батбаяр нь МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн бакалавр, Японы ОУ-ын их сургуулийн Эдийн засгийн чиглэлээр магистрын зэрэгтэй төгссөн. Тэрээр Барилга, хот байгуулалтын яаманд Захиргааны хэлтсийн мэргэжилтэн, УИХ-ын Тамгын газарт референт судлаач, Эдийн засгийн хөгжлийн яаманд Концессын хэлтсийн дарга, Засгийн газрын хөрөнгө оруулалтын газарт Концессын хэлтсийн дарга, Нийслэлийн үйлдвэрлэл инновацын газарт Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргаар ажиллаж байсан туршлагатай. “МИК Рийл Эстэйт” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар 2019 оноос хойш, “МИК ОССК” ХХК-ийн 2021 оноос хойш Бизнес, хөгжил хариуцсан Дэд захирлаар томилогдон ажиллаж байна.
 **Г.Сансар** Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Г.Сансар нь СЭЗИС-ийн Нягтлан бодогч мэргэжлээр бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. Тэрээр Улаанбаатар хотын банканд дилерээр, “МИК ОССК” ХХК-д 2015 оноос 2022 оны хооронд Эрсдэлийн удирдлагын газрын үйл ажиллагааны эрсдэлийн ахлах мэргэжилтэн, Хөрөнгө зохицуулалтын газар болон Санхүүгийн удирдлагын газрын захирлуудаар тус тус ажилласан; 2022 оноос хойш Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын албан томилогдон ажиллаж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7
9025080
TDB SECURITIES
TDB SECURITIES



М.Золжаргал
Санхүү хариуцсан дэд захирал

М.Золжаргал нь СЭЗИС-ийг нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн бөгөөд мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэг болон татварын мэргэшсэн зөвлөхийн гэрчилгээтэй байна.

Тэрээр "Эрнст энд Янг Аудит Монголиа" ХХК-д ахлах аудитор, "Улаанбаатар Капитал" ХХК-д дотоод аудитор, "Хуавэй Технолоши" ХХК-д татварын менежерээр тус тус ажиллаж байсан нийт 11 жилийн ажлын туршлагатай бөгөөд 2024 оны 10 дугаар сараас "МИК ОССК" ХХК-ийн Санхүүгийн удирдлагын газрын захирал, 2025 оны 2 дугаар сараас Санхүү хариуцсан дэд захирлаар томилогдон ажиллаж байна.

Бусад үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 04 тоот тогтоол, 2025 оны 8 дугаар сарын 28-ний өдрийн 12 тоот тогтоолоор батлсны хүрээнд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

Хөндлөнгийн аудиторыг сонгох, солих тухай журам

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн аудиторт тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, гэрээнд тусгах мэдээлэл, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулагдсан тусгай зориулалтын компани тул бүтэц зохион байгуулалтын хувьд онцлог бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагаа нь Компанийн тухай хуулиас гадна "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль", Хорооноос батлсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Биржийн "Бүртгэлийн журам" болон Үнэт цаас гаргагчийн "Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу нарийвчлан зохицуулагдахаар байна.

Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам

Энэхүү журмын зорилго нь Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгө итгэмжлэн удирдагчид тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, гэрээнд тусгах мэдээлэл, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журам

Тус журмаар Үнэт цаас гаргагч нь биржийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, ХБҮЦ-ны төлбөрийг үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам

Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИЭЙ АССЕТ МЭНЭЖМЕНТ ХХК
ШТҮ2842 7169569 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

Энэхүү журмын дагуу үнэт цаас эзэмшигчид болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн Үнэт цаас гаргагчийн мэдээ, мэдээллийг үнэн зөв олон нийтэд хүргэх, үүргийн хэрэгжилтийг "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ний үндсэн дээр хөрөнгө итгэмжлэн удирдагч гүйцэтгэх ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь гэрээний хэрэгжилтийг хянана.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.9 дэх заалт, Хорооноос баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам" болон Биржээс баталсан "Бүртгэлийн журам"-д тус тус заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржээр дамжуулан анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журам"-аар зохицуулсан байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ
ХХК
ШТЧ2002 7169569
9025080088

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251491
TDB SECURITIES

2.9. Санхүүгийн үйл ажиллагаа

“Си и Си Ая Ассет Ван ТЗК” ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн “Си И Си Ая ассет ван ХХК-ийг үүсгэн байгуулах тухай” 25/004 тоот шийдвэрээр үүсгэн байгуулагджээ. Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1,000 ширхэг гаргасан энгийн хувьцаа бүхий 1,000,000 (нэг сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 11 тоот “Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай” тогтоолоор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулах хугацааны буюу 2025-2027 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

2.9.1. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн байдлын тайланг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлтийг нэгтгэн дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 17: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	2025У3	2025У4	2026У1	2026У2	2026У3	2026У4	2027У1	2027У2	2027У3
Бэлэн мөнгө	354.7	737.1	1,157.0	1,554.4	959.4	1,324.4	695.6	1,061.1	423.7
Нийт зээл	3,129.6	2,903.1	2,650.0	2,368.3	2,087.3	1,819.6	1,550.5	1,269.4	982.3
Нийт хөрөнгө	**3,484.3**	**3,640.2**	**3,807.0**	**3,922.7**	**3,046.7**	**3,144.0**	**2,246.1**	**2,330.5**	**1,406.0**
ХБҮЦ-ны өглөг	3,034.5	3,034.5	3,034.5	3,034.5	2,034.5	2,034.5	1,034.5	1,064.5	86.5
ХБҮЦ	3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0	2,000.0	2,000.0	1,000.0	1,000.0	-
Хуримтлуулж тооцсон хүү	34.5	34.5	34.5	34.5	34.5	34.5	34.5	64.5	86.5
Нийт өр төлбөр	3,034.5	3,034.5	3,034.5	3,034.5	2,034.5	2,034.5	1,034.5	1,064.5	86.5
Хувьцаат капитал	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
Тухайн жилийн ашиг, алдагдал	81.3	155.9	166.8	115.6	124.0	97.3	102.1	54.3	53.6
Хуримтлагдсан ашиг	367.5	448.9	604.8	771.6	887.2	1,011.2	1,108.5	1,210.7	1,264.9
Нийт өөрийн хөрөнгө	449.8	605.8	772.6	888.2	1,012.2	1,109.5	1,211.6	1,266.0	1,319.5
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	**3,484.3**	**3,640.3**	**3,807.1**	**3,922.7**	**3,046.7**	**3,144.0**	**2,246.1**	**2,330.5**	**1,406.0**

2.9.2. Орлогын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь үйлчилгээ үзүүлэгчээс хүлээн авах багцын эргэн төлөлтөөс орох орлого болон Үнэт цаас гаргагчийн гаргаж буй ХБҮЦ-ны төлбөр болон үйл ажиллагаатай холбоотой гарах зардлуудад үндэслэн орлого, зардал болон мөнгөн урсгалаа дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

Хүснэгт 18: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	2025У3	2025У4	2026У1	2026У2	2026У3	2026У4	2027У1	2027У2	2027У3
Хүүгийн орлого	120.8	346.0	319.4	289.6	257.3	226.2	195.9	165.1	132.9
Бусад орлого	1.3	12.6	21.5	31.2	40.3	26.1	34.3	19.6	27.9
Хүүгийн зардал	(34.5)	(135.0)	(135.0)	(135.0)	(135.0)	(90.0)	(90.0)	(75.0)	(67.0)
Цэвэр хүүгийн орлого	87.5	223.6	205.9	185.8	162.6	162.3	140.2	109.7	93.8
Үйл ажиллагааны зардал	(6.3)	(41.3)	(39.0)	(38.8)	(38.6)	(40.4)	(38.2)	(37.9)	(34.2)
Татварын өмнө ашиг	81.3	182.3	166.8	147.0	124.0	121.9	102.1	71.7	59.5
Татварын зардал	-	(26.4)	-	(31.4)	-	(24.6)	-	(17.4)	(6.0)
Цэвэр ашиг	81.3	155.9	166.8	115.6	124.0	97.3	102.1	54.3	53.6

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь чанаргүй зээлийн ангилалд шилжих, анх худалдан авах үед тавигдсан холбогдох шаардлага, шалгуурыг хангахгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ", хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" болон "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-ын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн хөрөнгийг холбогдох шаардлага, шалгуурыг хангасан зээлийн хөрөнгөөр солих, солих боломжгүй тохиолдолд буцаан худалдан авах үүрэгтэй билээ. Өөрөөр хэлбэл, Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь 100% хэвийн зээлийн хөрөнгөөс бүрдэх болно.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь дараах зардлуудыг орлогын тайлангийн төсөөлөлдөө оруулсан байна. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТӨК
ХХК
ШТЧ2842 7339569
9025020098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Хүснэгт 19: Үнэт цаас гаргагчийн зардлын төсөөлөл

№	Зардлын зориулалт	Давтамж
1	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр	Улирал тутам
2	Хөндлөнгийн аудитын үйлчилгээний зардал	Жил бүр
3	ТУЗ-ийн цалингийн зардал	Улирал тутам
4	Систем, программ хангамжийн зардал	Сар бүр
5	Үйлчилгээ үзүүлэгчийн зардал	Улирал тутам
6	Захиргааны үйлчилгээний үзүүлэгчийн зардал	Улирал тутам

2.9.3. Мөнгөн гүйлгээний төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулах хугацааны мөнгөн урсгалын төлөвлөгөө дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 20: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

	2025У3	2025У4	2026У1	2026У2	2026У3	2026У4	2027У1	2027У2	2027У3
Цэвэр ашиг	81.3	155.9	166.8	115.6	124.0	97.3	102.1	54.3	53.6
Хуримтлагдсан хүүгийн мөнгөн урсгал	34.5	135.0	135.0	135.0	135.0	90.0	90.0	75.0	67.0
Зээлийн үндсэн төлбөрийн мөнгөн урсгал	70.0	226.5	253.1	281.7	281.0	267.8	269.1	281.1	287.1
ХБҮЦ хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал	-	(135.0)	(135.0)	(135.0)	(135.0)	(90.0)	(90.0)	(45.0)	(45.0)
ХБҮЦ үндсэн төлбөрийн мөнгөн урсгал	-	-	-	-	(1,000.0)	-	(1,000.0)	-	(1,000.0)
Хадгаламжийн орлого	1.3	12.6	21.5	31.2	40.3	26.1	34.3	19.6	27.9
Нийт мөнгөн урсгал	**184.5**	**369.8**	**398.4**	**366.1**	**(635.2)**	**338.9**	**(663.1)**	**345.9**	**(665.2)**
Мөнгөн хөрөнгийн эхний баланс	184.5	370.3	752.8	1,172.7	1,570.0	975.0	1,340.1	711.2	1,076.7
Мөнгөн хөрөнгийн эцсийн баланс	**370.3**	**752.8**	**1,172.7**	**1,570.0**	**975.0**	**1,340.1**	**711.2**	**1,076.7**	**439.4**

УЦААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАНТЭЖ
ХХК
ШТЧ2842 7009569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

2.10. Үнэт цаас гаргагчийн дансны мэдээлэл

Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах данснуудад хяналт тавьж ажиллана. Үүнд:

Зээлийн эргэн төлөлт цуглуулах данс гэж Зээлдэгчдээс Зээлийн эргэн төлөлтийг цуглуулах, Багцын эргэн төлөлтийг Төлбөр цуглуулах дансанд шилжүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн нэр дээр Худалдаа хөгжлийн банканд тусгайлан нээсэн данс байна.

Төлбөр цуглуулах данс гэж Үнэт цаас гаргагчийн Үйлчилгээ үзүүлэгчээс шилжүүлсэн Багцын эргэн төлөлтийг хүлээж авч, Үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр, Үнэт цаас гаргагчийн гэрээгээр болон холбогдох хууль тогтоомж, журмаар хүлээсэн төлбөрийн үүргүүдийг Төлбөрийн дарааллын дагуу гүйцэтгэх, Үнэт цаас эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг удирдах зорилгоор Худалдаа хөгжлийн банканд тусгайлан нээсэн данс байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой бусад данснууд

Үнэт цаасны данс гэж Үнэт цаас гаргагч нь биржийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөрийг байршуулах зорилгоор Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд нээлгэсэн данс байна.

2.11. Үнэт цаас гаргагч татан буугдах

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий тусгай зориулалтын компани тул Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооны холбогдох журамд тусгасны дагуу дараах тохиолдолд татан буугдана. Үүнд:

- Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
- Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагч бүцаан худалдан авсан;

Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан. Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн эсвэл баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагч бүцаан худалдан авсан тохиолдолд татан буулгах шийдвэрийг Үнэт цаас гаргагч эсхүл Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч гаргана. Үнэт цаас гаргагч нь баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан тохиолдолд Хорооны хүсэлтийг үндэслэн шүүх татан буулгах шийдвэрийг гаргана.

Үнэт цаас гаргагч татан буугдах тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу түүний хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Татан буулгах үйл ажиллагааны зардал;
2. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр;
3. ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
4. ХБҮЦ-ны үндсэн төлбөр;
5. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
6. Аудитын үйлчилгээний төлбөр;
7. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллаагай холбоотой зардал;
8. Бусад Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-өөс батлагсан төсвийн дагуу гарах зардал;
9. Үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ АССЕТ МЭНЭЖМЕНТ ХХК
ШТЧ2842 7169569 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

03

АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ/ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ

3.1. Танилцуулга

“Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь 2013 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр “Юнайтэд Прожектс Корпорэйшн” ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд 2014 оны 8 дугаар сарын 27-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 304 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш зээлийн үйл ажиллагаа, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх болон богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах гэсэн 4 тусгай зөвшөөрлийг авсан байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2022 оноос үйл ажиллагаагаа эрчимжүүлэн зах зээлд санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд санал болгож, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр одоогийн байдлаар өөрийн 3 салбар, хамтрагч байгууллагуудын Pocket, ZeelMe, MCredit гэсэн 3 цахим сувагтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь 2023 онд Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоонд нэгдэж ББСБ-ын нэгдсэн мэдээлэлтэй байх, ажилтнуудаа тогтмол сургалтад хамруулан ажиллах боломжтой болсон байна. 2025 оны 1 дүгээр сараас шинэ залуу жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн удирдлагын зөвлөгөө өгөх, хөнгөлөлттэй санхүүжилт олгох зорилготой “Боловсрол бидний ирээдүй” өсөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 21 хувийн дунд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулж, хөтөлбөрийн хамрах хүрээг өргөжүүлсэн байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хэрэглээний зээл, бизнесийн зээл, автомашины зээл, үл хөдлөх хөрөнгийн зээл, ногоон зээл, сургалтын төлбөрийн зээл, боловсролыг дэмжих зээл гэсэн 7 төрлийн зээлийн үйлчилгээг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна.

Хүснэгт 21: АҮГ-ийн хураангуй танилцуулга, 2025 оны II дугаар улирлын байдлаар

Хураангуй үйл ажиллагааны үзүүлэлтүүд	
Харилцагчдын сегмент	Иргэдийн зах зээл; Бизнесийн зах зээл.
Үйл ажиллагааны чиглэл	Зээлийн үйл ажиллагаа; Итгэлцлийн үйлчилгээ; Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх.
Салбарын тоо	3 салбар
Нийт ажилтны тоо	17 ажилтан
Нийт харилцагчдын тоо	22171 харилцагч (үлдэгдэлтэй харилцагчдын тоо)
Хураангуй санхүүгийн үзүүлэлтүүд	
Нийт хөрөнгө	17.4 тэрбум төгрөг
Эздийн өмч	9.7 тэрбум төгрөг
Нийт зээлийн багц	13.7 тэрбум төгрөг
Чанаргүй зээлийн хувь	4.86 %
Хүүгийн орлого	2.1 тэрбум төгрөг
Цэвэр ашиг	609.0 сая төгрөг

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТӨ
ХХК
ШТЧ2842 7 69569
9025 88098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Хүснэгт 22. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн мэдээлэл

Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт	Хэмжээ, төгрөг	Хорооноос зөвшөөрөл олгосон огноо	Хорооны тогтоолын дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, төгрөг
	400,000,000.0	2014.08.27	№304	400,000,000.0
Нэмэгдүүлсэн	4,000,000,000.0	2015.08.28	№246	4,400,000,000.0
Нэмэгдүүлсэн	600,000,000.0	2025.05.22	№204	5,000,000,000.0


Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь салобартаа шинэ жишиг тогтоож, эдийн засгийн хөгжилд эерэг хувь нэмэр оруулах зорилгоор “Ухаалаг хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ” гэсэн уриатайгаар ажилладаг. Энэхүү зорилгынхоо хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдийн өсөлтийг дэмжих бизнесийн зээл, боловсролыг дэмжих сургалтын төлбөрийн зээл, байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай хэрэглээ, бизнесийг дэмжих ногоон зээл болон бусад зээлээс бүрдсэн нийт 13.8 тэрбум орчим төгрөгийн зээлийг 22,000 орчим иргэн, байгууллагад олгоод байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО	АЛСЫН ХАРАА
Шинэ жишиг тогтооно.	Хүмүүн капиталын чадамжийг технологийн хөгжилтэй уялдуулан ухаалаг хөрөнгө оруулагч болно.

3.2. Бүтэц, зохион байгуулалт, засаглал

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч болох “Си И Си Инвестмент ББСБ” ХХК нь Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 25/003 тоот тогтоолоор өөрийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан бөгөөд үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар энэ нь дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 12: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт




Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт энгийн хувьцааны 100 хувийг "Си И Си Групп" ХХК эзэмшиж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ АССЕТ ВАН ТЗ ХХК
ШТЧ2842 7169789 9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES

Зураг 13: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Хүснэгт 23. Анхны үүрэн гүйцэтгүүлэгчийн эцсийн өмчлөгчийн танилцуулга

Нэр, албан тушаал	Товч намтар
 **Х.Гиймаа** ТУЗ-ийн дарга	**Боловсрол** - Хүнсний технологийн академи, Украйн улс, Технологи инженер, Бакалавр. **Ажлын туршлага** - 2025 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, ТУЗ-ийн дарга; - 2021 – Одоо – Нью яармаг хаусинг прожект ХХК, ТУЗ-ийн гишүүн; - 2016 – Одоо – Талх чихэр ХХК, ТУЗ-ийн гишүүн; - 2007 – 2017 – Хүнсчдийн холбоо, Гүйцэтгэх захирал, Сүүний зөвлөлийн дарга; - 1995 – 2007 – ГУМ сүүний үйлдвэр, Ерөнхий захирал; - 1993 – 1995 – Хүнсний эрдэм шинжилгээ зураг төслийн институт, Эрдэм шижилгээний ахлах ажилтан; - 1985 – 1993 – Улаанбаатар хотын сүүний үйлдвэр, Чанарын хэлтсийн дарга, Ерөнхий технологич; - 1983 – 1985 – Эрдэнэт хотын хүнсний комбинатад сүү үйлдвэр, Үйлдвэрийн дарга.

Компанийн нэгдлийн бүтэц

Хараат компани

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани" гэж тодорхойлсон бөгөөд Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хараат компанигүй байна.

Охин компани

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
ASSET MANAGEMENT
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES

эзэмшдэг бие даасан компанийг охин компани" гэж тодорхойлсон бөгөөд Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь "Си И Си Ая ассет ван ТЗК" ХХК (РД: 5765919) гэх нэг охин компанитай байна.

Үнэт цаас гаргагч буюу "Си И Си Ая ассет ван ТЗК" ХХК нь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгын хүрээнд үүсгэн байгуулагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын компани байна.

Нэгдмэл сонирхолтой этгээд

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт зааснаар "толгой компани, түүнтэй тус хуулийн 6.1 (хараат компани), 6.3 (охин компани), 6.8 (хараат болон охин компанийн үргэлжилсэн хэлхээ холбоо) дэх хэсгүүдэд заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл" гэж, 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэгт зааснаар "нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани" гэж тус тус тодорхойлсон.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээд дараах байдалтай байна.

Хүснэгт 24: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Компанийн нэр	Регистрийн дугаар	Хамаарал бүхий компаниуд дах шууд болон шууд бус эзэмшлийн хувь
1	"Юнайтедпрожектс корпорейшн" ХХК	5517427	Х.Гиймаа 100.0%
2	"Си И Си групп" ХХК	5727138	"Юнайтедпрожектс корпорейшн" ХХК 100.0%
3	"Си И Си капитал" ХХК	5332702	"Си И Си групп" ХХК

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Төлөөлөн Удирдах зөвлөл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Төлөөлөн Удирдах зөвлөл нь Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагыг хангасан 5 гишүүнээс бүрдэх бөгөөд дор хаяж нэг гишүүн нь хараат бус гишүүн байхаар заажээ.

Хүснэгт 25: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ТУЗ-ийн гишүүд

Нэр, албан тушаал	Товч намтар
 **Х.Гиймаа** ТУЗ-ийн дарга	**Боловсрол** - Хүнсний технологийн академи, Украйн улс, Технологи инженер, Бакалавр. **Ажлын туршлага** - 2025 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, ТУЗ-ийн дарга; - 2021 – Одоо – Нью яармаг хаусинг прожект ХХК, ТУЗ-ийн гишүүн; - 2016 – Одоо – Талх чихэр ХХК, ТУЗ-ийн гишүүн; - 2007 – 2017 – Хүнсчдийн холбоо, Гүйцэтгэх захирал, Сүүний зовлолийн дарга; - 1995 – 2007 – ГУМ сүүний үйлдвэр, Ерөнхий захирал; - 1993 – 1995 – Хүнсний эрдэм шинжилгээ зураг төслийн институт, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан; - 1985 – 1993 – Улаанбаатар хотын сүүний үйлдвэр, Чанарын хэлтсийн дарга, Ерөнхий технологич;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169569 9025080098

СЕКЬЮРИТИС УЦК ХХК
TDB SECURITIES
9021113 5251404

- 1983 – 1985 – Эрдэнэт хотын хүнсний комбинатад сүү үйлдвэр, Үйлдвэрийн дарга.



Ц.Уганбаяр
ТУЗ-ийн ердийн гишүүн

Боловсрол
- ШУТИС-КТМС, Бизнесийн удирдлага, Бакалавр.

Ажлын туршлага
- 2024 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн;
- 2022 – Одоо – Юнайтэд Прожектс Корпорэйшн ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн;
- 2012 – 2016 – Нью яармаг хаусинг прожект ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2008 – 2011 – Зам тээвэр хот байгуулалтын яам, Сайдын зөвлөх.



Н.Урантуяа
ТУЗ-ийн ердийн гишүүн

Боловсрол
- СЭЗИС, Санхүүгийн менежер, Магистр;
- МУИС, Эдийн засагийн сургууль, Санхүү менежер, Бакалавр.

Ажлын туршлага
- 2025 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн;
- 2024 – Одоо – Юнайтэд Прожектс Корпорэйшн ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2022 – 2025 – Си И Си Инвестмент ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2020 – 2023 – Нью яармаг хаусинг прожект ХХК, Санхүү хариуцсан захирал;
- 2014 – 2018 – Мобиком Корпораци, Стратегийн шинжилгээний хэлтсийн менежер;

* - 2007 – 2014 – Ньютел ХХК, Төлөвлөлтийн менежер.



Б.Баярмаа
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол
- МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүйч
- МУИС, Эдийн засгийн сургууль, Банкны эдийн засагч

Ажлын туршлага
- 2024 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн;
- 2023 – Одоо – Тэрбум мод сан, Гүйцэтгэх захирал;
- 2021 – 2022 – Богд банк ХХК, Гүйцэтгэх захирлын орлогч;
- 1997 – 2021 – Худалдаа хөгжлийн банк, Эдийн засагч - Гүйцэтгэх захирлын орлогч.



П.Ундрах-Эрдэнэ
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Боловсрол
- МУИС, Хууль зүйн сургууль, Эрх зүйч, Бакалавр.

Ажлын туршлага
- 2024 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, ТУЗ-ийн ердийн бус гишүүн;
- 2015 – Одоо – Өмгөөллийн цэц мэргэн ХХН, Гүйцэтгэх захирал;
- 2013 – 2015 – Хас Банк, Эрх зүйн шинжээч;
- 2011 – 2013 – Кредит Монгол ББСБ ХХК, Хуульч;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТӨ
ХХК
ШТЧ2842 7169556
9025080098

Гүйцэтгэх удирдлага

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу Гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн сонгосон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм болон ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч бөгөөд Компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.

"Юнайтэд Прожектс Корпорэйшн" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2025 оны 05 сарын 22-ны өдрийн 25/036 тоот шийдвэрээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гүйцэтгэх захирлаар Б.Азжаргалыг томилсон байна.

Хүснэгт 26: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх захирал

Нэр, албан тушаал	Товч намтар
 **Б.Азжаргал** Гүйцэтгэх захирал	**Боловсрол** - СЭЗИС – Бизнес удирдлага, магистр; - МУБИС – Эдийн засагч, бакалавр. **Ажлын туршлага** - 2025 – Одоо – Си И Си Инвестмент ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал; - 2023 – 2024 – Инвескор проперти ХХК, Борлуулалт хариуцсан захирал; - 2011 – 2022 – Худалдаа Хөгжлийн Банк ХК, Эдийн засагч - Салбарын захирал.

3.3. Зээлийн үйл ажиллагаа

"Си И Си Инвестмент ББСБ" ХХК нь ногоон зээл, бизнесийн зээл, сургалтын төлбөрийн зээл, боловсролыг дэмжих зээл, автомашины зээл, үл хөдлөх хөрөнгийн зээл болон хэрэглээний зээлээс бүрдсэн нийт 7 төрлийн 29 зээлийн бүтээгдэхүүнийг иргэд болон байгууллагад санал болгож ажилладаг байна.

Хүснэгт 27. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл

Бүтээгдэхүүн	Нөхцөл	Бүтээгдэхүүний төрөл
Ногоон зээл	▪ Зээлийн хэмжээ 300 сая төгрөг хүртэл; ▪ Хугацаа 1-60 сар хүртэл; ▪ Хүү 2.5 хувь.	▪ Ногоон бизнесийн зээл ▪ Ногоон хэрэглээний бүтээгдэхүүний зээл ▪ Ногоон автомашин худалдан авах зээл ▪ Ногоон орон сууц худалдан авах зээл
Бизнесийн зээл	▪ Зээлийн хэмжээ 300 сая төгрөг хүртэл; ▪ Хугацаа бүтээгдэхүүнээс хамаарч 24- 36 сар хүртэл; ▪ Хүү 2.7-2.9 хувь.	▪ Бизнесийн зээл ▪ ПОС орлого барьцаалсан зээл ▪ Түрээсийн зээл ▪ Баталгаат зээлийн шугам ▪ Үйлчилгээний талбайн түрээсийн зээл
Сургалтын төлбөрийн зээл	▪ Зээлийн хэмжээ 10 сая төгрөг хүртэл; ▪ Хугацаа 12 сар; ▪ Хүү 1.5-2.5 хувь.	▪ Сургалтын төлбөрийн зээл
Боловсролыг дэмжих зээл	▪ Зээлийн хэмжээ 10 сая төгрөг хүртэл; ▪ Хугацаа 12 сар; ▪ Хүү 2.5-3.0 хувь.	▪ Боловсролыг дэмжих зээл ▪ Олон улсын арга хэмжээнд оролцоход зориулсан зээл
Автомашин зээл	▪ Зээлийн хэмжээ бүтээгдэхүүнээс хамаарч 2-200 сая төгрөг хүртэл; ▪ Хугацаа 12-60 сар; ▪ Хүү 2.4-3.0 хувь.	▪ Шинэ автомашин худалдан авах зээл /0 км/ ▪ Гаальтай автомашин худалдан авах зээл ▪ Дугаартай автомашин худалдан авах зээл ▪ Цахилгаан автомашин худалдан авах зээл ▪ Автомашины барьцаалсан зээл

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАНТЗ
ХХК
ШТЧ2842 7168
9025080068

SECURITIES
5251494
SECURITIES

		▪ Шинэ мотоцикл худалдан авах зээл /0 км/ ▪ Шинэ мопед худалдан авах зээл /0 км/
Үл хөдлөх хөрөнгийн зээл	▪ Зээлийн хэмжээ 30 - 300 сая төгрөг хүртэл; ▪ Хугацаа 20-60 сар ▪ 0.0-3.0 хувь.	▪ Орон сууц худалдан авах зээл ▪ Орон сууц барьцаалсан зээл ▪ Агуулах худалдан авах зээл ▪ Авто зогсоол худалдан авах зээл ▪ Авто зогсоол барьцаалсан зээл
Хэрэгдээний зээл	▪ Зээлийн хэмжээ 50-200 сая төгрөг хүртэл ▪ Зээлийн хүү бүтээгдэхүүнээс хамаарна ▪ Зээлийн хугацаа бүтээгдэхүүнээс хамаарна	▪ М кредит зээл ▪ Покет цахим зээл ▪ Зээлми цахим зээл ▪ Хэрэглээний лизинг ▪ Итгэлцэл барьцаалсан зээл

2025 оны 2 дугаар улирлын байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн цэвэр зээлийн багцын нийт дүн өмнөх оны мөн үеэс 83.4 хувиар өссөн байгаа бол 2022-2024 оны хугацаанд жилд дунджаар 76.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн тайлант улирлын байдлаар нийт зээлийн багцын дийлэнх буюу 64.0 хувийг цахим зээл, 31.8 хувийг автомашины зээл, 2.4 хувийг орон сууц барьцаалсан зээл, үлдсэн 1.8 хувийг бусад 4 төрлийн зээл тус тус бүрдүүлж байна. Сүүлийн 3 жилийн 2 дугаар улирлын үзүүлэлтээр цахим зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.0 хувиас 64.0 хувь болж ихэссэн бол бизнесийн зээлийн эзлэх хувь 37.2 хувиас 0.7 хувь болж буурчээ.

Зураг 14. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт зээлийн багц, бүтээгдэхүүний төрлөөр, тэрбум төгрөг



Эх сурвалж: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн 2022,2023,2024 оны аудитлагдсан тайлан, 2024.II болон 2025.II улирлын СЗХ-д хүргүүлсэн тайлан

2025 оны 2 дугаар улирлын байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт зээлийн багцын 99.99 хувийг иргэнд олгосон зээл, үлдсэн хэсгийг аж ахуйн нэгжид олгосон зээл тус тус эзэлж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ А
ASSET BA
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098


ТИ ДИ ВИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

3.4. Санхүүгийн голлох үзүүлэлтүүд


Санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлтүүд

2025 оны II дугаар улирлын байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Нийт хөрөнгө (тэрбум төг)




Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Цэвэр зээл




Хүүгийн орлого



Цэвэр хүүгийн орлого



Цэвэр ашиг




Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 2025 оны 2 дугаар улирлын байдлаар дараах байдалтай байна. Үүнд:


УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ ...
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES


Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлт



Санхүүгийн хөшүүрэг, хүү төлөх чадварын харьцаа



ББСБ салбартай харьцуулсан үзүүлэлт, 2024 он



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагуудын баримтлах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг баримтлан ажилладаг бөгөөд 2024 оны 2, 3, 4 дүгээр улирал болон 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар зохистой харьцааны үзүүлэлтийг дараах байдлаар хангаж ажилласан байна. Үүнд:

Хүснэгт 28: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, 2025 оны II улирал

№	Зохистой үзүүлэлт	Байвал зохих	Тайлан	Шалгуур хангасан эсэх
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт				
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	44.6%	**Хангасан**
2	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	56.2%	**Хангасан**
3	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	30%-аас доошгүй	55.9%	**Хангасан**

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЭК ХХК
ШТЧ2842 7167569 9025080098
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
TDB SECURITIES

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа				
4	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	23.7%	**Хангасан**
Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт				
5	Хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээ	319,851,420.1	+	**Хангасан**
6	Зээл, зээлтэй адилтгах тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	1.3%	**Хангасан**
7	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	50%-аас хэтрэхгүй	17.2%	**Хангасан**
8	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	8.0%	**Хангасан**
Гадаад валютын ханшийн эрсдэл				
9	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	6.1%	**Хангасан**
Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд				
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	52.6%	**Хангасан**
11	Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан		18,268,663.6	**Хангасан**
12	Өрийн бичгийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	20.4%	**Хангасан**
Үндсэн хөрөнгийн үзүүлэлт				
13	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1,8%	**Хангасан**

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭ
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098


ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

3.5. Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлагын бүтэц

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Си И Си Инвестмент ББСБ" ХХК нь эрсдэлийн удирдлагын "Гурван давхар хамгаалалтын шугам"-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг байна.

Зураг 15: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц



Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн хүчин зүйл, эрсдэлийн удирдлага

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн удирдлагын тогтолцоо, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон Дотоод аудитын газраар дамжуулан компанийн үйл ажиллагаанд учирч болох гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох, сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах талаар Эрсдэлийн удирдлагын журмын хүрээнд тодорхойлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавин ажилладаг байна.

Анхны үүрэг гзйцэтгүүлэгч нь Эрсдэлийн удирдлагын журамд ББСБ-д учирч болох эрсдэлийн төрөл болон түүний удирдлагыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Хүснэгт 29: Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн хүчин зүйл	Тайлбар	Эрсдэлийн удирдлагын бодлого
Макро эдийн засгийн эрсдэл	Зах зээл, эдийн засгийн хямрал, ханш, хүү, инфляцын огцом өөрчлөлтөөс үүдэн орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй алдагдал	VaR эрсдэлийн хэмжигдэхүүн, GAP шинжилгээ, бодит өртөг, макро орчны тогтворгүй байдал, симуляци, зах зээлийн эрсдэлийн [illegible] активыг жигнэн байнгын хяналтай байх.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЙ
АССЕТ ВАН ТЗ
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098
TDB SECURITIES
5251494
9021110883
TDB SECURITIES

Зээлийн төвлөрлийн эрсдэл	Нэг болон харилцан хамааралтай зээлдэгч эсвэл нэг салбарт зээлийг төвлөрүүлж олгосны улмаас үүсэх эрсдэл	Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу нэг зээлдэгчид болон хамаарал бүхий этгээдүүд олгох зээлийн хэмжээг тогтоох ба тогтоосон хэмжээнээс хэтрүүлэлгүй хяналттай байх.
Зээлийн эрсдэл	Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал	Зээлийн эрсдэлийн сан байгуулах, эргэн төлөлтийн зөрчлийн мэдээг тогтмол тооцоолох, зээлийн эрсдэлийн төвшингөөр активыг жигнэх, дотоодын зээлдэгчдийн зээлжих зэрэглэлийн оноо тооцох.
Өөрийн хөрөнгийн эрсдэл	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ байхгүйгээс бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадваргүй болох, эсвэл зохицуулагч байгууллагын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж чадахгүй болох	Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны үзүүлэлтийн дагуу хяналт тогтоож өрийн бичиг болон итгэлцлийн зохистой харьцааг хангахын тулд тогтоосон дээд хэмжээнээс давуулж татахгүй байх.
Хөрвөх чадварын эрсдэл	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлж чадахгүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарж болзошгүй нөхцөл байдлаас үүсэх эрсдэл	Хөрвөх чадварын GAP шинжилгээ, хөрвөх чадварын харьцаа болон бусад шалгуур үзүүлэлтүүдийг ханган баримтлах.
Үйл ажиллагааны эрсдэл	Дотоод үйл ажиллагаа, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсвэл гадны хүчин зүйлсийн улмаас хүлээж болзошгүй алдагдал	Үйл ажиллагааны эрсдэлээс үүсэж гарсан алдагдлын мэдээлэл, статистикт дүн шинжилгээ хийж, үндсэн хүчин зүйлүүдэд стандарталчилсан аргаар эрсдэлийг тооцох.
Аюулгүй байдлын эрсдэл	Бодит болон мэдээллийн аюулгүй байдал алдагдах, мэдээллийн системд халдлага хийх эсвэл түүнийг зөрчсөний улмаас үүсэх гарз хохирол болон алдагдал	ISO 27001:2013 Мэдээллийн технологи, аюулгүй байдлын арга техник, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж сертификат авах, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх.
Ёс зүйн эрсдэл	Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсвэл харилцагчтай шударга харилцах зарчмыг хэрэгжүүлээгүйн улмаас гарч болзошгүй алдагдал	Байгууллагын дотоод дүрэм, журамд ёс зүйн хэм хэмжээ, хариуцлагыг бүрэн тусгаж өгч, ажилтнуудад ёс зүйн үнэлгээ хийх, сургалт явуулах арга чилал боловсруулж мөрдөж ажиллах.
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн стандарт, байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс үүдэн нэр хүндээ алдах, тусгай зөвшөөрөл, лиценз хураалгах, торгууль, акт тавиулах, санхүүгийн хувьд үүсэх алдагдал	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохицуулагч байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан боялого дүрэм, журамд мэдрэг хандах цаг тухай бүр нийцүүлэн ажиллах.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169569 9025080098

ТДБ ЦЭНХЭС ХХК
TDB SECURITIES
+902 1108 525 494
TDB SECURITIES

Нэр хүндийн эрсдэл	Олон нийтийн сөрөг ойлголтоос үүдэн байгууллагын нэр хүндэд хохирол учрах, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэл	Байгууллагын дотоод нууц хадгалах гэрээг ажилтан, хамтран ажиллагч байгууллага бүртэй байгуулах болон нэр хүндэд халдсан, хохирол учруулахаар зүйлд цаг хугацаа алдахгүй арга хэмжээ авч ажиллах.
Стратегийн эрсдэл	Нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнесийн шийдлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн боломжоо алдах, алдагдал хүлээх	Бизнес төлөвлөгөөг богино, дунд, урт хугацаагаар боловсруулан мөрдөж, зах зээлийн болон хуулийн өөрчлөлт зэрэг бизнест нөлөөлж болохуйц зүйл тохиолдвол цаг тухай бүрт бизнес төлөвлөгөө болон стратегийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

Мөн түүнчлэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрсдэл бүрийн хяналт болон удирдлагыг хэрэгжүүлэх хамгаалалтын бүсийг тодорхойлон зааж өгсөн байна.

Хүснэгт 30. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хамгаалалтын бүсийн ангилал, эрсдэлийн төрлөөр

Эрсдэлийн төрөл	Хамгаалалтын 1 дүгээр бүс	Хамгаалалтын 2 дугаар бүс
Макро эдийн засгийн эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж
Зээлийн төвлөрлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж
Зээлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж
Өөрийн хөрөнгийн эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж
Хөрвөх чадварын эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж
Үйл ажиллагааны эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Аюулгүй байдлын эрсдэл	Бүх нэгжүүд	Мэдээллийн болон бодит аюулгүй байдал хариуцсан нэгж
Ёс зүйн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Хянан нийцүүлэлтийн эрсдэл	Бизнес /Арын албаны нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Нэр хүндийн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Стратегийн эрсдэл	Гүйцэтгэх захирал	Төлөөлөн удирдах зөвлөл

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

04

УНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

4.1. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.16 дахь заалт, 87, 88 дугаар зүйл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7, 10, 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн №360 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын холбогдох зүйл, хэсэг, заалт, "Си И Си Инвестмент ББСБ" ХХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 25/025 тоот тогтоолыг тус тус үндэслэн "Си и Си Ая Ассет Ван ТЗК ХХК"-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 08 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолоор нийт 3.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахаар тогтоож, үнэт цаасны ерөнхий нөхцөлийг баталсан байна.

4.2. Үнэт цаасны хүүгийн түвшин тогтоох үндэслэл

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад санал болгох хүүгийн түвшнийг зах зээлийн нөхцөл байдал болон үнэт цаасны онцлог шинжтэй уялдуулан тогтоосон байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 6 дугаар сарын 12,13-ны өдрүүдийн хурлаар төв банкны бодлогын хүү 12.0 хувь байсныг хэвээр хадгалах шийдвэр гаргасан билээ.

2025 оны 8 дугаар сарын байдлаарх банкны салбарын 24 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү 13.5 хувь, 24 сарын хугацаатай шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү мөн адил 13.5 хувь байгаа бол олон нийтэд нээлттэй санал болгосон бүртгэлтэй байгаа 24 сарын хугацаатай 6 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 18.5 хувь байна.

Зураг 16: ХБҮЦ-ны хүүгийн түвшний харьцуулалт




Эх сурвалж: Монголбанк, Хүү, хугацааны тайлан;
Арилжааны банкнуудын цахим хуудас;
Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж, Чингис хаан хөрөнгийн бирж

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хүү нь 2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн байдлаарх системийн нөлөө бүхий 5 банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн зарласан хүүгээс 5.5%-иар, бүх арилжааны банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн зарласан хүүгээс 4.9%-иар тус тус өндөр байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Зураг 17: Нээлттэй зах зээлд бүртгэлтэй ХБҮЦ-ны хүү



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, Улаанбаатар үнэт цаасны бирж, Чингис хаан хөрөнгийн бирж

Хөрөнгө оруулагч нь ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг улирал тутам хүлээн авснаар дахин хөрөнгө оруулалт хийж, бодит өгөөжийн түвшингээ нэмэгдүүлэх боломжтой байна. Хаалттай бонд болон хадгаламжийн хүүгийн орлогоос 10%-ийг тооцож суутгадаг бол нээлттэй хүрээнд санал болгож буй ХБҮЦ-ны хүүгийн орлогоос 5%-ийн татвар тооцож байгаа нь хөрөнгө оруулагчдад бий болгож буй өгөөжийн түвшнийг өндөр байлгахад нөлөөлж байна.

4.3. Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаасыг эзэмшигч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

1. Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах;
2. Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
3. Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах;
4. Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах;
5. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах, биелүүлээгүйн улмаас өөрт учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах;
6. Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

4.4. Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн хуулийн дагуу дараах нийтлэг үүрэгтэй байна. Үүнд:

1. Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
2. Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;
3. Компанийн дүрэм, баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, баталгаат үнэт цаасны танилцуулгад заасан шаардлагын биелэлтийг хангах;
4. Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасны дагуу Компанийн бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл болон бусад хууль тогтоомж, Хороо, Биржээс батлагдсан журамд заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд тухай бүр Хороо, Бирж болон Үнэт цаас эзэмшигчдэд нээлттэй мэдээлэх;
5. Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7169
9025080098
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ХХК
TDB SECURITIES
5251494
9021110
TDB SECURITIES

6. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол тухайн хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч рүү буцаан худалдаж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг бүрэн төлж барагдуулах;
7. Холбогдох хууль тогтоомж, журам, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

4.5. Үнэт цаасны эрсдэл

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тодорхой хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт болох мөнгөн урсгал болон түүний барьцаа хөрөнгө, баталгаа, барьцааны шаардах эрхээр баталгаажсан байдгаараа бусад өрийн хэрэгсэлтэй харьцуулахад харьцангуй эрсдэлийн түвшин багатай хөрөнгө оруулалтад тооцогддог. Гэсэн хэдий ч аливаа өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх нь их бага хэмжээгээр эрсдэл дагуулж байдаг. Тэдгээр эрсдэлүүдийг оновчтой тодорхойлон, тэдгээр эрсдэлийг удирдах нь зайлшгүй шаардлагатай юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хувьд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн онцлог, тус зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, оролцогч талууд, хууль эрх зүйн зохицуулалттай холбоотой эрсдэлүүд үүсэх болзошгүй байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь эдгээр эрсдэлүүдийг тодорхой хэмжээнд удирдах зорилгоор Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 12 тоот тогтоолоор “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”-ыг батлажээ.

Тус журамд ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотой учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилан, тухайн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулжээ. Үүнд:

Зээлийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл

1. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх эрсдэл

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор өөрийн зээлийн эрсдэлийг удирдах журмын хүрээнд зээлийн хяналтыг хэрэгжүүлэх, зээл төлүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэх ба Зээлийн хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээл олгох үйл ажиллагаанд дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн чанаргүй зээлийн түвшин 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 4.9 хувь байгаа нь ББСБ-ын салбараас 2.8 нэгж хувиар бага буюу тус компани эрсдэлээ оновчтой удирддаг болохыг харуулж байна;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Шалгуур үзүүлэлт болон бусад шаардлагыг хангасан Орлуулах зээлийн хөрөнгөөр солихоор үүрэгжүүлсэн;
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө бүрийг сонгоход тавигдсан шалгуур үзүүлэлтийн дагуу зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг тэргүүн ээлжид гаргуулах боломжтой байхаар тусгасан байна;
- Мөн Үнэт цаас гаргагч нь Зээлийн хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг Хорооноос баталсан активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана. ТЗК нь хагас жил тутамд зээлийн эрсдэлийн санг холбогдох журмын дагуу тооцож, эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.
- Түүнчлэн хөрөнгийн багцад байгаа хөрөнгүүд эргэн төлөгдөх баталгаа алдагдаж, багцын мөнгөн урсгалд эрсдэл учирсан тохиолдолд хөрөнгийн багц дахь хөрөнгөөс Үнэт цаас гаргагчийн “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам”-д заасан дарааллын дагуу тэргүүн ээлжид үнэт цаас эзэмшигчдийн хүүгийн болон үндсэн төлбөрийг гаргуулан авна. Үлдсэн хөрөнгөөс гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг үндэслэн тус журамд заасны дагуу холбогдох төлбөрүүдийг төлнө. Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө нь аливаа эрхийн доголдолгүй, өмчийн маргаангүй бөгөөд гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэл хангуулахаар барьцаалаагүй болно.

2. Зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө эргэн төлөх эрсдэл

- Зээлдэгчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан зээлийн гэрээнд зээлээ урьдчилан бүрэн төлж, хаахыг хориглосон заалт байхгүй бөгөөд энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцад урьдчилсан төлөлт хийгдэх, зээлийн гэрээнд өөрчлөлт орох боломжтой байна. Энэхүү нөхцөл нь хөрөнгийн багцын эргэн төлөлтөөс орж ирэх Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалд нөлөөлж болзошгүй ч Үнэт цаас гаргагч, түүнийг төлөөлж Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Үнэт цаас гаргагчийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасны дагуу хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл

1. **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график нь үнэт цаасны төлбөрийн графикаас зөрүүтэй байх эрсдэл**

   - Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-нд тусгасны дагуу хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график болон үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн график дээр хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх, эсхүл буцаан худалдах арга хэмжээг авна.

2. **Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хөрөнгийн багц чанаргүй болох эрсдэл**

   - Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багц чанаргүйдэх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг нэмэгдүүлэх, солих эсхүл хөрөнгийн багцыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаан худалдах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Оролцогч талуудтай холбоотой эрсдэл

1. **Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл** /Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөд өөрчлөлт оруулах үүргээ биелүүлэхгүй эсхүл биелүүлэх боломжгүй байх, төлбөрийн чадваргүй болох, татан буугдах/

   - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх боломжгүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид үүссэн нөхцөлийг тодорхойлж, хөрөнгийн багц дахь зээлийн эрсдэлийг Хороо, Бирж, Үнэт цаас эзэмшигчдэд холбогдох журмын дагуу мэдэгдэх, ХБҮЦ-ны Хөрөнгийн багцын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг Үйлчилгээ үзүүлэгч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран хэрэгжүүлэх эсхүл тус хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах бөгөөд энэхүү эрсдэлийг Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран удирдана;
   - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг солих, нэмэгдүүлэх боломжгүй байх болон Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-д заасан бусад нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тус гэрээний дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийг хэсэгчлэн болон бүхэлд нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах эрхтэй байна;
   - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан худалдан авах үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үнэт цаас гаргагч нь "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасны дагуу уг Хөрөнгийн багцыг гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүхэлд нь худалдан борлуулах эрхтэй байна;
   - Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээний дагуу Үнэт цаас гаргагчид Фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх бий болох бөгөөд гуравдагч этгээдэд худалдан борлуулаагүй

зээлийн хөрөнгийн хувьд Фидуцийн зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэн авах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагааг эхлүүлнэ;

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгч этгээд байх тохиолдолд эдгээр этгээд нь хуульд заасан үндэслэлээр татан буугдах болон "Үйчлилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам"-д заасны дагуу Үйлчилгээ үзүүлэгчийг солих нөхцөл үүссэн бол Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ны хөрөнгийн багцыг шинэ үйлчилгээ үзүүлэгч рүү шилжүүлэх ажиллагааг тус журмын дагуу хийж гүйцэтгэнэ;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

2. **Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл** /Зээлийн эргэн төлөлтийг бүрэн гүйцэд, гэрээнд заасан хугацаанд цуглуулан, Үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй байх, тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах/

- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг Худалдаа, хөгжлийн банканд тусгайлан нээсэн зээлийн эргэн төлөлт цуглуулах дансанд цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгах ба Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийг төлөөлөн тус дансанд сар бүр хяналт тавьж ажиллана;
- Төлбөр цуглуулах үйл ажиллагааг Үйлчилгээ үзүүлэгч нь цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчид ажлын 5 хоногт зөрчлийг арилгах талаар мэдэгдэл хүргүүлнэ. Энэхүү зөрчлийг заасан хугацаанд арилгаагүй нөхцөлд Үйлчилгээ үзүүлэгчийг Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан гэж үзэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг арилгах ба учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Үйлчилгээ үзүүлэгч өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна;
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгийн багцтай холбоотой түүний авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг зохих журмын дагуу сонгогдсон, өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх буюу үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна;
- Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

3. **Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл** /Хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд зааснаас бусад зорилго, зориулалтаар буюу Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, гэрээнд заасан үүргийг зохих ёсоор биелүүлэхгүй байх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, татан буугдах, дампуурах эсвэл гэрээнд заасан үүргээ биелүүлэх чадваргүй болох/

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө болон түүний эргэн төлөлтийг удирдахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-ний дагуу Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад холбогдох тайлан мэдээллийг тогтмол хүргэх бөгөөд хууль тогтоомж болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа тогтоох эрхтэй байна. Мөн, зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгасан байна.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг эрх бүхий зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон хөрөнгө итгэмжлэн удирдагчид Үнэт цаас гаргагчийн Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгө, түүний эргэн төлөлтөд хамаарах бүх баримт бичиг, данс, тооцоо, бэлэн мөнгө, тайлан зэргийг цахим болон бусад хэлбэрээр ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгөх үүрэгтэй байна.

4. **Захиргааны үйлчилгээ үзүүлэгч** /Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн болон хэсэгчлэн гүйцэтгээгүй байх, тусгай зөвшөөрлийг Хорооноос цуцлах, Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах/

- Захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь гэрээнд заасан үйлчилгээг заасан хугацаанд бүрэн гүйцэт болон хэсэгчлэн үзүүлээгүй, санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас Үнэт цаас гаргагч болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд Захиргааны үзүүлэгч өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна;
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас холбогдох гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай аливаа үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон цуцалсан, бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь өөр хэвийн үйл ажиллагаатай захиргааны үйлчилгээ үзүүлэгчийг сонгож, солих арга хэмжээг авна.
- Үнэт цаас гаргагч нь Захиргааны үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

5. **Үнэт цаас гаргагчтай холбоотой эрсдэл**

- Үнэт цаас гаргагчийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үүргийг бүрэн хэрэгжүүлж дуусаагүй хугацаанд тусгай зөвшөөрлийг зохицуулагч байгууллагаас түдгэлзүүлэх, татан буулгах шийдвэрийг гаргаж болзошгүй ч энэ нөхцөлд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгийн багцыг эзэмшилдээ авах эрх хүлээн авагчийг зохицуулагч байгууллагаас томилж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл

1. **Хууль эрх зүйн орчинтой холбоотой эрсдэлийн удирдлага**

- Хөндлөнгийн хуулийн зөвлөхийн дүгнэлтийн дагуу, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь аливаа хууль эрх зүйн зөрчилгүй байгаа ба цаашид хууль тогтоомж, журам, зохицуулалттай холбоотой эрсдэлийг удирдах үүднээс Үнэт цаас гаргагчийн ТУЗ хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хөндлөнгийн хуулийн зөвлөхийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтран ажиллах, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллахаар “Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам”-д тусгасан байна.

2. **Макро эдийн засаг болон бизнесийн гадаад орчны өөрчлөлттэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- Макро эдийн засгийн хямрал, барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буусантай холбоотой зээлийн эрсдэл бий болсон аливаа нөхцөлийг холбогдох тайланд тусгахын зэрэгцээ Үнэт цаас эзэмшигчид болон зохицуулагч байгууллагад тайлагнаж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
- Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээ тогтмол байх хэдий ч үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар зах зээл дэх хүүгийн түвшнээс харьцангуй өндөр байна. Мөн хөрөнгө оруулагч нь энэхүү үнэт цаасанд хөрөнгө оруулснаар улирал тутам хүүгийн төлбөрийг авах ба үүнийг дахин хөрөнгө оруулах замаар хүүгийн түвшний эрсдэлээ бууруулах боломжтой байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭК
ХХК
ТДБ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
9021110883
TDB SECURITIES

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалт хийх арга хэрэгсэлд хүүгийн түвшин буурсан зах зээлийн нөхцөл, тус хэрэгсэл нь хязгаарлагдмал нөхцөлд орж, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-д тайлагнаж, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөөр багц худалдан авах шийдвэрийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-аар гаргуулах;
- Бусад гадаад болон дотоод эдийн засаг, бизнесийн орчинтой холбоотой эрсдэлийг Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч хамтран тухай бүр шийдвэр гаргаж, арга хэмжээ авч, холбогдох этгээдэд мэдээлж ажиллана.

3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс

- Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс үүсэх эрсдэлтэй холбогдуулан Үнэт цаас гаргагчийн ТУЗ хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллагыг хөлслөн ажиллуулах, эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, хамтран ажиллах, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулах;
- Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон тухай Үнэт цаас эзэмшигчдэд брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, Үнэт цаас гаргагч болон Биржийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлсийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна. Мөн, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөхгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн үүрэг биелүүлэх хугацаа нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хязгаарлагдмал нөхцөл

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь зөвхөн хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлт, түүний барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүдээс орж ирэх мөнгөн урсгалаар баталгаажна. Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргаагүй болно.

Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон эсхүл хугацааны эцэст төлөх хөрөнгийн багцын дүн хүрэлцээгүй болсон тохиолдолд Үүсгэн байгуулагч болон хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчдын өмнө өөрийн хөрөнгөөр үүрэг хүлээх эрх зүйн нөхцөл үүсээгүй болно. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны улмаас Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

05

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

5.1. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага

Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 31: Монгол Улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, 2022-2025 оны I улирал

Үзүүлэлт	Нэгж	2022	2023	2024	2025.I
Үндэсний тооцоо					
ДНБ, оны үнээр	Тэрбум төгрөг	53,851.5	70,441.5	79,956.3	18,968.5
ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	Тэрбум төгрөг	28,455.1	30,453.5	32,053.9	6,220.7
ДНБ, жилийн бодит өсөлт	Хувь	5.0	7.4	4.9	2.4
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	Мянган төгрөг	16,121.0	20,824.1	23,384.6	-
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн орлого	Тэрбум төгрөг	17,126.9	23,294.9	29,589.3	6,149.7
Төсвийн зарлага	Тэрбум төгрөг	18,159.7	22,509.0	30,365.5	6,502.7
Төсвийн тэнцэл	Тэрбум төгрөг	(1,032.7)	785.9	(776.2)	(353.0)
Засгийн газрын нийт өр	Тэрбум төгрөг	31,945.1	30,765.0	33,429.8	34,616.3
Гадаад худалдаа					
Эргэлт	Сая ам.доллар	21,243.0	24,437.2	27,398.0	11,269.5
Экспорт	Сая ам.доллар	12,538.6	15,186.9	15,783.4	6,036.7
Импорт	Сая ам.доллар	8,704.4	9,250.3	11,614.7	5,232.9
Тэнцэл	Сая ам.доллар	3,834.2	5,933.7	4,168.7	803.9
Мөнгөний нийлүүлэлт					
Мөнгө М1	Тэрбум төгрөг	7,201.3	9,853.1	11,687.4	10,137.9
Мөнгө М2	Тэрбум төгрөг	29,664.8	37,624.1	43,334.0	41,483.4
Хүүгийн түвшин					
Инфляцын түвшин /жилийн/	Хувь	13.2%	7.9%	9.0%	9.1%
Бодлогын хүү	Хувь	13.0%	13.0%	10.0%	12.0%
Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү	Хувь	13.0%	13.1%	9.9%	11.9%
Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /төгрөг/	Хувь	9.0%	11.4%	11.8%	12.9%
Хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /валют/	Хувь	2.5%	3.4%	3.7%	4.4%
Зээлийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /төгрөг/	Хувь	15.9%	17.0%	17.0%	17.4%
Зээлийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү /валют/	Хувь	10.9%	11.5%	9.6%	11.2%
Гадаад валютын ханш					
Ам.долларын ханш /хугацааны эцэс/	Төгрөг	3,444.6	3,410.7	3,420.5	3,475.4
Гадаад валютын албан нөөц	Сая ам.доллар	3,399.6	4,921.5	5,509.8	4,996.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
#9021108 5251494
TDB SECURITIES

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)


2024 онд нүүрсний экспорт анх удаа 80 сая тонныг давж, 83.7 сая тоннд хүрсэн нь өмнөх оноос биет хэмжээгээр 20 гаруй хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн 2025 оны улсын төсөвт зам, тээврийн салбарт 1.4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тусгасан нь аймгийн төвүүдийг боомтуудтай холбох, аялал жуулчлалын чиглэлийн авто замуудыг барих зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулагдана. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжиж, 2025 онд эдийн засгийн өсөлт 6.6 хувьд хүрэх төлөвтэй байгаа хэдий ч олон улсын зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт, хөрш орнуудын геополитикийн асуудлуудтай холбоотойгоор импортын үнэ нэмэгдэх зэргээс шалтгаалан тус өсөлт нь тогтворгүй байх магадлалтай байна.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон Монгол Улсын ДНБ 19.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 2.5 их наяд төгрөгөөр өсжээ. ДНБ-ийг салбаруудын бүтцээр нь авч үзвэл 36.5 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 9.7 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, 7.2 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 4.5 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 5.9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, үлдсэн 33.2 хувийг үйлдвэрлэлийн бусад салбарууд тус тус бүрдүүлж байна.

Үнийн өсөлтийг арилгасан буюу 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон Монгол Улсын бодит ДНБ өмнөх оны мөн үеэс 2.4 хувь буюу 0.1 их наяд төгрөгөөр өсөж, 6.2 их наяд төгрөгт хүрчээ. Үнийн өсөлтийг арилгасан ДНБ-ийг салбаруудын бүтцээр авч үзвэл 16.3 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар, 14.8 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 10.2 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, 5.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 4.2 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үлдсэн 44.9 хувийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар тус тус бүрдүүлж байна.

Бодит ДНБ-ий өсөлтөд эдийн засгийн салбаруудын оролцооны түвшнийг авч үзвэл 2025 оны 1 дүгээр улиралд уул уурхайн салбар 0.8 хувиар өсөж, бодит ДНБ-ий өсөлтийн 0.1 нэгж хувийг, бүтээгдэхүүний цэвэр татвар -2.3 хувиар буурч, бодит ДНБ-ий өсөлтийн -0.4 нэгж хувийг, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа -21.6 хувиар буурч, бодит ДНБ-ий өсөлтийн -1.2 нэгж хувийг, бөөний болон жижиглэн худалдааны салбар -5.8 хувиар буурч, бодит ДНБ-ий өсөлтийн -0.6 нэгж хувийг эзэлж байгаа бол хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар өсөж, бодит ДНБ-ий өсөлтийн 1.0 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 18: ДНБ-ий өсөлтөд эзлэх салбаруудын оролцооны түвшин, 2025 оны I улирал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2025 оны эхний улиралд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал уул уурхайн салбарын зогсонги байдал болон түүнийг дагасан тээвэр, агуулахын салбарын нөлөөгөөр суларч, өсөлт нь удааширчээ.

Мөн Монгол Улсын Засгийн газар 2025 оны 2 дугаар сард таван жилийн хугацаатай, 300 сая ам.доллараар "Century IV" бондыг олон улсын зах зээлд 6.625%-ийн хүүтэйгээр амжилттай арилжаалсан. Тус бондоор зах зээлд гаргасан байсан "Nomad" болон "Century II" бондуудын эргэн хугацаанд авсан нь орлого дарамтыг бууруулж, эдийн засгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлж байна. Ингэснээр дотоодын аж ахуйн нэгжүүдэд олон улсын санхүүгийн зах зээлээс хямд эх үүсвэр татах боломжийг нэмэгдүүлж, 2025 оны өсөлтийн төлөвийг эерэгээр тодорхойлж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭ
ХХК
ШТЧ2842 7169
9025080038

TDB SECURITIES

Монгол банк, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Олон улсын валютын сан зэрэг томоохон байгууллагууд нь Монгол Улсын ирэх жилүүд дэх эдийн засгийн өсөлтийн таамаглалыг шинэчлэн гаргаад байна. Азийн Хөгжлийн Банкны үзэж байгаагаар Монгол Улсын эдийн засгийн сэргэлт энэ онд үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ойрын хугацаанд хадгалагдахаар байгаа бөгөөд Монгол Улсын уул уурхайн салбарын өсөлт сэргэж, түүнийг дагасан тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон үйлчилгээний бусад үйл ажиллагаанд үзүүлэх эерэг нөлөөлөл зэрэгт үндэслэн 2025 онд Монгол Улсын эдийн засаг 6.6 хувиар, 2026 онд 5.9 хувиар тус тус өснө хэмээн таамаглажээ. Тус төсөөлөлд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт, экспортын сэргэлт, дотоод эргэлт дэмжихээр байгаа хэдий ч, өндөр инфляц, түүний эсрэг мөнгөний хатуу бодлого, дотоод санхүүжилтийн нөхцөл чангарсан зэрэг нь хязгаарлаж байгаа ажээ.

Хүснэгт 32: Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал

Байгууллага	Эдийн засгийн өсөлтийн таамаглал				
	2025F	2026F	2027F	2028F	2029F
Дэлхийн банк	6.3%	5.2%	5.2%	-	-
АХБ	6.6%	5.9%	-	-	-
ОУВС	6.0%	5.9%	5.5%	5.5%	5.0%
Монголбанк	7.5%	4.7%	-	-	-
Дундаж	**6.6%**	**5.4%**	**5.4%**	**5.5%**	**5.0%**

Эх сурвалж: Дэлхийн банк, "Дэлхийн эдийн засгийн тойм";
ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төлөв";
Азийн хөгжлийн банк, "Азийн хөгжлийн тойм";
Монголбанк, Инфляцын тайлан.

Инфляцын түвшин

Монголбанкны зүгээс инфляцыг 2025-2026 онд жилийн 5 хувь орчимд, +/-2 хувийн интервалд тогтворжуулахыг зорьж байгаа бөгөөд инфляцын төсөөлөл өмнөх тайлантай харьцуулахад 1 нэгж хувиар багасжээ. 2024 онд зорилтот түвшин рүү буурах хурд нь эдийн засгийн идэвхжил, төсвийн зардал, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой бага зэрэг удаашраад байсан. Гэвч 2025 оны 1 дүгээр улирлын эцэст Монгол Улсын хэмжээнд инфляцын түвшин буурлаа. Геополитик тарифын нөлөө, худалдааны дайны нөлөөлөл байсаар байгаа ч импортын бүтээгдэхүүний инфляц хүлээлтээс бага, мөн хүнсний инфляц хүлээлтээс эрт тогтворжиж буурсан нь үүнд нөлөөллөө. Монголбанкны зүгээс инфляцын хүлээлтийг 2025 онд 8.8 хувь хүрнэ гэсэн төсөөлөлтэй байгаа бол 2026 онд харьцангуй хурдтай буурч, 6.0 хувьд хүрнэ гэж үзжээ.

Монгол Улсын инфляцын түвшин 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд зорилтот түвшнээс илүү буюу 9.1 хувьд хүрч, оны эхэн үеэс 0.4 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын инфляцын түвшнийг олон улсын санхүүгийн байгууллагууд болон Монголбанкны зүгээс ирэх жилүүдэд дараах түвшинд хүрнэ хэмээн таамаглажээ.

Хүснэгт 33 : Монгол улсын инфляцын таамаглал

Байгууллага	Инфляцын таамаглал				
	2025F	2026F	2027F	2028F	2029F
Дэлхийн банк	-	-	-	-	-
АХБ	10.0%	8.0%	-	-	-
ОУВС	9.5%	9.1%	7.9%	7.1%	6.6%
Монголбанк	8.8%	6.0%	-	-	-
Дундаж	**9.2%**	**7.1%**	**7.5%**	**7.2%**	**6.6%**

Эх сурвалж: ОУВС, "Дэлхийн эдийн засгийн төлөв";
Азийн хөгжлийн банк, "Азийн хөгжлийн тойм";
Монголбанк, Инфляцын тайлан.


Бодлогын хүү

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ ASSET BAN ТЗК ХХК
ШТЧ2842 7169569 9025080098

ТДБ СЕКЬЮРИТИС ТЦК ХХК
ТДБ SECURITIES
9902111088 5251494
ТДБ SECURITIES

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2025 оны 3 сарын 6,7-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрээрээ бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12.0 хувьд хүргэсэн. Мөн хэрэглээний болон тэтгэврийн зээлийн зохицуулалтад өөрчлөлт оруулж, өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоосон. Эдгээр арга хэмжээ нь инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байна. Харин 2025 оны 6-р сарын 12, 13-нд дахин хуралдаж, бодлогын хүүгээ 12.0 хувьд хадгалахаар шийдвэрлэлээ. Өмнө нь инфляцын түвшин зорилтот түвшнээс давсантай холбоотойгоор бодлогын хүүг өсгөсөн бол одоо инфляцын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор хадгалах шийдвэр гаргажээ.

Зураг 19: Монгол Улсын бодлогын хүүгийн түвшин, 2022-2025 оны I улирал




Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн бюллетень", 2024 оны 12 дугаар сар

Монгол Улсын мөнгөний бодлогын цаашдын төлөв нь гадаад, дотоод эдийн засгийн орчинд инфляцын төлөв хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч бодлогын дараагийн алхмуудыг авч хэрэгжүүлэх болохыг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос мэдэгдээд байна.

Хүүгийн түвшин

2025 оны эхний улиралд бодлогын хүүг өсгөж 12.0 хувьд хүргэсэн ч тайлант үед үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкнуудын энгийн хугацаатай хадгаламжийн зарласан хүү харьцангуй тогтвортой байсан буюу хугацаанаас хамааран 5.7-14.2 хувьтай байсан байна. Харин тус хугацаанд банк хоорондын зах (БХЗ)-ын жигнэсэн дундаж хүү (ЖДХ) оны эхэн үеэс өсөж 11.9 хувь, банкнуудын тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.0 хувьд хүрч ялимгүй буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 20: Дотоодын зах зээл дэх хүүгийн түвшний харьцуулалт, 2020 оны IV улирлаас 2025 оны I улирал



Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн бюллетень", 2025 оны 3 дугаар сар
Тухайн сард шинээр татсан харилцах, хадгаламж болон тухайн сард олгосон зээл

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7169568
9025080098


ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ХК
TDB SECURITIES

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар биржид бүртгэлтэй, идэвхтэй байгаа нээлттэй хүрээнд гарсан компанийн бондуудын хүүгийн түвшин хугацаанаас хамааран дунджаар 18.0 хувьтай тэнцсэн байна. Түүнчлэн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн түвшин 17.2-20.0 хувьтай байгаагаас үзэхэд үнэт цаасны зах зээл дээр гарч буй бүтээгдэхүүнүүдийн хүүгийн түвшин инфляцын түвшнээс өндөр буюу хөрөнгө оруулагчдын мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлж чадахуйц түвшинд байна.

Мөнгөний нийлүүлэлт

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт (М2) 41.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.1 их наяд төгрөг буюу 10.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү 10.9 хувийн өсөлтийн 10.2 нэгж хувийг бусад хадгаламж болох валютын харилцах, хадгаламж болон төгрөгийн хадгаламжийн өсөлт бүрдүүлж байгаа бол 0.7 нэгж хувийг бага мөнгө (М1) болох хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцахын өсөлт тус тус бүрдүүлж байна. Мөн бүтцийн хувьд М1 мөнгө 10.1 их наяд төгрөгт хүрч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 24.4 хувьтай, бусад хадгаламж 32.5 их наяд төгрөгт хүрч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 78.4 хувьтай тус тус тэнцэж байна.

Зураг 21: Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт, 2025 оны I улирал



Эх сурвалж: Монголбанк, "Статистикийн бюллетень", 2025 оны 3 дугаар сар


Түүнчлэн 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар валютын хадгаламжийн үлдэгдлийн дүн өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар нэмэгдсэн бол валютын харилцахын дүн 14.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин төгрөгийн харилцах тус онд өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өссөн бол хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 10.7 хувиар өсөж, М1 мөнгөний хэмжээг 41.5 их наяд хүрэхэд нөлөөлсөн
байна.

Валютын ханш

2022 онд төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш хурдацтай суларч, 2022 оны эцсийн байдлаар 3,444.6 төгрөгтэй тэнцсэн үзүүлэлттэй байсан. Иймхүү суларч байсан төгрөгийн ханш 2023, 2024 онд тогтвортой байсан ба 2024 оны эцэст 2022 оны эцэстэн харьцуулахад 24.1 төгрөг буюу 0.7 хувиар чангарсан байна. Харин 2025 оны 1 дүгээр улиралд төгрөгийн ханш ам.долларийн эсрэг суларсаар тайлант улирлын эцсийн байдлаар 3,487.6 төгрөгтэй тэнцэж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
TDB SECURITIES

Зураг 22: Монгол Улсын гадаад валютын албан нөөц (ГВАН) болон төгрөгийн ам.доллартой харьцах ханш, 2015-2025 оны I улирал



Эх сурвалж: Монголбанк


Валютын ханшийг тогтмол барих зорилгоор Төв банкнаас интервенц буюу ам.доллар худалдах, зах зээлд нийлүүлэх замаар ханшийг тогтворжуулах ажиллагаа хийгддэг. 2022 онд Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2019-2022 онд жилд дунджаар 7.9 хувиар буурч, 2022 оны байдлаар тус хугацаан дахь хамгийн доод түвшин буюу 3.4 тэрбум ам.долларт хүрчээ. Харин 2022 оны 9 дүгээр сараас хилийн хязгаарлалт суларч, экспорт нэмэгдэж олон улсын зах зээлээс валют татах боломжууд нэмэгдсэнтэй холбогдон 2024 оны 4 дугаар улирлын байдлаар гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өсөн 5.5 тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин тайлант улирлын байдлаар Монгол улсын нийт экспортын 60 орчим хувийг бүрдүүлдэг нүүрсний экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэмжээний хувьд ялимгүй буюу 3.3 хувиар багассан ч олон улсын зах зээл дээрх үнийн уналттай холбогдуулан үнийн дүнгийн хувьд 39.7 хувиар багассан үзүүлэлттэй байна. Монгол улсын гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 2.7 дахин багасаж, 465.1 сая ам.доллар хүрсэн бол гадаад валютын албан нөөц 2025 оны эхнээс тасралтгүй багасан нэгдүгээр улирлын байдлаар 5.0 тэрбум ам.доллар болж буурсан байна.

Төсвийн тэнцэл

2023 оны байдлаар 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан Монгол Улсын төсвийн тэнцэл 2024 оны эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 1,562.0 тэрбум төгрөгөөр бууран 776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2024 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын төсөв 1,626.5 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан бол 2025 оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэсээ -121.7 хувь буюу 1,979.5 тэрбум төгрөгөөр буурч, 353.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Зураг 23: Монгол улсын төсвийн орлого, зарлага, их наяд төгрөг, 2015-2025 оны I улирал



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн Яам

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭК
ХХК
ШТЧ2842 7169
9025080
ТИ ЛИ ДИ СЕКЬЮ ТИ З УЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Тайлант хугацаанд Монгол Улсын төсвийн нийт орлого 6.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэсээ (16.0) хувиар буурчээ. Уул уурхай, тээвэрлэлтийн салбар 1 дүгээр улиралд хумигдаж, үүнийг даган бусад эдийн засгийн салбарын идэвх суларснаар орлогын татвар болон АМНАТ эрс буурч, төсвийн орлого эрс багаслаа. Төсвийн нийт орлогыг бүтцийн хувьд авч үзвэл 94.2 хувь буюу 5.8 их наяд төгрөгийг татварын орлого, 5.8 хувь буюу 354.3 тэрбум төгрөгийг татварын бус орлого тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсын төсвийн зарлагын тухайд өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар нэмэгдэж, 6.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд цалин хөлсний өсөлт болон халамж, урсгал шилжүүлэг тэлснээр төсвийн зардал нэмэгджээ. Улсын зарлагыг бүтцийн хувьд авч үзвэл урсгал зардлын хэмжээ 90.7 хувь буюу 5.9 их наяд төгрөгийг, хөрөнгийн зардлын хэмжээ 9.1 хувь буюу 592.4 тэрбум төгрөгийг, цэвэр зээл 0.2 хувь буюу 9.9 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж байна.

Засгийн газрын өр төлбөр

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.3 хувь буюу 4.8 их наяд төгрөгөөр өсөж, 34.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтөд Засгийн газрын гадаад өрийн хэмжээ, үүнээс Засгийн газрын үнэт цаасны 21.0 хувийн буюу 1.8 их наяд төгрөгийн өсөлт, Засгийн газрын зээлийн 8.8 хувь буюу мөн 1.8 их наяд төгрөгийн өсөлт голлон нөлөөлсөн байна.


Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 8.4 хувь буюу 3.0 тэрбум ам.доллароор өсөж 38.0 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна. Бүтцийн хувьд авч үзвэл нийт гадаад өрийн 46.3 хувь буюу 17.6 тэрбум ам.долларыг компани хоорондын зээллэг, 20.1 хувь буюу 7.7 тэрбум ам.долларыг бусад салбаруудын гадаад өр, 22.7 хувь буюу 8.6 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, үлдсэн 10.9 хувь буюу 4.1 тэрбум ам.долларыг Төв банк болон хадгаламжийн байгууллагын гадаад өр тус тус бүрдүүлж байна. Монгол Улсын нийт гадаад өрийн 8.4 хувийн өсөлтөд компани хоорондын зээллэг өмнө жилийн мөн үеэс 12.2 хувь буюу 1.9 тэрбум ам.доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын Засгийн Газар 2025 оны 1 дүгээр улиралд "Nomad" болон "Century-II" бондуудыг "Century IV" бондын арилжаанаас төвлөрүүлсэн хөрөнгөөр эргүүлэн худалдаж авах замаар тухайн бондуудын үүргийн гүйцэтгэлийг эцэлсэн. Энэхүү бондыг арилжсанаар зээлжих зэрэглэл өндөртэй Узбекистан, Бразил, Доминикан зэрэг орнуудын бондоос 0.1-0.4 пунктээр доогуур хүүтэй бонд гаргасан нь Монгол Улсад итгэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж байгаагийн том үзүүлэлт юм.

Гадаад худалдаа

2025 оны I улирлын байдлаар гадаад худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс 0.5 тэрбум ам.доллароор буурч, 5.6 тэрбум ам.долларт хүрсэн байна. Тус хугацаанд Монгол Улсын экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар буюу 637.9 сая ам.доллароор буурч, 3.0 тэрбум ам.долларт хүрсэн бол импортын хэмжээ 5.55 хувиар буюу 134.1 сая ам.доллароор өсөж, 2.5 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна. Мөн тус тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 772.0 сая ам.доллароор буурч, 464.1 сая ам.долларын ашигтай гарчээ.

Зураг 24: Монгол улсын экспорт, импорт, тэрбум ам.доллар, 2014-2025 оны I улирал




УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЭК ХХК
ШТЧ2842 7169569
9025080098
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2025 оны I улирлын байдлаар нийт экспортын үнийн дүнгийн 89.1 хувь буюу 2.7 тэрбум ам.долларыг эрдэс бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж байна. Тоо хэмжээний хувьд их хэмжээгээр экспортолсон голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл нүүрсний экспорт -3.3 хувиар буурч 17,532.7 мянган тонн, төмрийн хүдэр, баяжмалын экспорт -2.1 хувиар буурч 1,767.7 мянган тонн, боловсруулаагүй нефть -12.9 хувиар буурч 915.4 мянган баррель хүрчээ. Харин жоншны хүдэр ба баяжмалын экспорт нь 51.1 хувиар өсөж 404.6 мянган тонн, адууны махны экспорт 24.3 хувиар өсөж 3,251.6 мянган тонн экспортолсон байна.

Зураг 25: Экспорт, импорт бүтээгдэхүүний төрлөөр, нийт экспорт, импортод эзлэх хувь, 2025 оны I улирал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын дүн 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 33.9 хувиар буурч, 0.7 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд тус үзүүлэлт нь Монгол Улсын ДНБ-ий 12.0 хувьтай тэнцжээ. Тус хугацаанд бөөний болон жижиглэн худалдаа, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа болон боловсруулах үйлдвэрлэл, мэдээлэл, холбооны салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэн бол уул уурхай, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын хөрөнгө оруулалт буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 26: Монгол Улсын ГШХО-ын орох урсгал, ДНБ-д эзлэх хувь, 2012-2025 оны I улирал




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭК
ХХК
ШТ42842 7169
9025080036
ТИ СИ СИ ЭССЕТ ВАН ТЭК ХХК
TDB SECURITIES
TDB SECURITIES

Монгол Улсын уул уурхайн салбар нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хамгийн их татдаг салбар бөгөөд 2020-2024 онуудын хооронд нийт хөрөнгө оруулалтын 65.6-80.9 хувийг тус салбарын хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлсэн байна. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 40.1 хувиар буурч, 494.9 сая ам долларт хүрчээ. Цаашлаад, нийт хөрөнгө оруулалтын 74.4 хувийг уул, уурхайн салбар бүрдүүлэх болж буурсан байна.

Зураг 27: Монгол Улсын ГШХО-ын орох урсгалын бүтэц, салбараар, 2020-2025 оны I улирал




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 онд "Оюу Толгой" ХХК-ийн уурхайн нийт баялгийн 80 хувийг бүрдүүлдэг гүний уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотойгоор 2024 оны 4 дүгээр улиралд уул уурхайн салбарын ГШХО 3.1 тэрбум ам.долларт хүрч, 2024 оны нийт ГШХО-ын хэмжээг 4.2 тэрбум ам.долларт хүргэсэн үзүүлэлттэй байна.

Уг үйл ажиллагаанаас үүдэж Rio Tinto компанийн тооцоолж байгаагаар "Оюу Толгой" ХХК-ийн зэсийн олборлолт 2028 онд 500 мянган тоннд хүрч, 2028 онд дэлхийд тавт эрэмбэлэгдэх зэсийн уурхай болох тооцоололтой байна.

Хүснэгт 34: Дэлхийн томоохон уул уурхайн компаниудын зэсийн олборлолт, 2024 он, 2028 оны төсөөлөл



Эх сурвалж: Mining.com, World's biggest copper mines, 2025
Reuters Report, 2024
Rio Tinto, Newsletter, 2024

Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал нь уул уурхайн салбарт орж буй хөрөнгө оруулалтаас ихээхэн хамаардаг бөгөөд сүүлийн 10 жилийн байдлаар ГШХО-ын дүн ДНБ-ий 12-оос 23 хүртэлх хувийн бүрдүүлж байгаагаас үзэхэд "Оюу Толгой" ХХК-ийн гүний уурхайн олборлолт нь ирээдүйн эдийн засгийн төлөвт эерэг өөрчлөлтийг авчрах төлөвтэй байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЭК ХХК
ШТЧ2842 7[illegible]569
9025088098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
9021[illegible]251494
TDB SECURITIES

5.2. Монгол Улсын банк бус санхүүгийн салбарын нөхцөл байдал, цаашдын чиг хандлага

Банк бус санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд

Зураг 28: Банк бус санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд, 2025 оны I улирал



ББСБ тоо

575



Хувьцаагаа олон нийтэд санал болгосон ББСБ

5



Нийт хөрөнгө

7.6 их наяд төгрөг



Нийт өөрийн хөрөнгө

3.9 их наяд төгрөг



Нийт хүүгийн орлого

603.4 тэрбум төгрөг



Нийт цэвэр ашиг

232.1 тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж, ROE

6.8%



Нийт хөрөнгийн өгөөж, ROA

3.7%



Нийт зээл

6.3 их наяд төгрөг



Нийт итгэлцлийн үйлчилгээний өглөг

1,196.1 тэрбум төгрөг



Зээлийн ЖДХ

3.5%



Нийт өрийн бичгийн үлдэгдэл

618.8 тэрбум төгрөг



Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, NPL

6.7%



Банкны салбарт эзлэх хувь (нийт актив)

10.8%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЭК ХХК
ШТЧ2842 7169999
9025080028

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС УЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Банк бус санхүүгийн салбарын тойм үзүүлэлт

Зураг 29: Банк бус санхүүгийн салбарын онцлох үзүүлэлтүүд, 2021.I – 2025.I

Үзүүлэлт	2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I
Салбарын үзүүлэлтүүд					
ББСБ тоо	530	529	514	531	575
Харилцагчдын тоо, мянган ширхэг	3,481.4	4,645.1	3,862.5	4,458.0	3,739.3
Санхүүгийн үзүүлэлтүүд, тэрбум төгрөг					
Нийт хөрөнгө	2,089.1	2,972.8	3,702.1	5,062.1	7,568.4
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,027.3	1,164.6	1,361.1	1,655.7	1,820.6
Нийт хуримтлагдсан ашиг	410.1	587.7	816.4	1,189.6	1,859.1
Зээлийн багцын ангилал, тэрбум төгрөг					
Нийт зээл	1,422.0	2,293.6	2,864.0	4,249.8	6,325.3
Хэвийн зээл	1,216.3	2,065.3	2,510.0	3,644.9	5,609.8
Анхаарал хандуулах	59.0	79.3	125.9	151.8	290.8
Чанаргүй	146.7	149.0	228.0	282.0	424.8
Хэвийн бус	35.2	31.8	65.4	74.5	144.8
Эргэлзээтэй	26.6	27.4	57.9	74.5	144.8
Муу	84.9	89.8	104.7	138.8	172.9
Зээлийн эрсдэлийн сан	(112.4)	(117.5)	(165.4)	(212.0)	(309.7)
Зээлийн багцын ангилал, нийт зээлд эзлэх хувиар					
Хэвийн зээл	85.5%	90.0%	87.6%	89.4%	88.7%
Хугацаа хэтэрсэн	4.1%	3.5%	4.4%	3.7%	4.6%
Чанаргүй	10.3%	6.5%	8.0%	6.9%	6.7%
Хэвийн бус	2.5%	1.4%	2.3%	1.8%	2.3%
Эргэлзээтэй	1.9%	1.2%	2.0%	1.7%	1.7%
Муу	6.0%	3.9%	3.7%	3.4%	2.7%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.(Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга)

Банк бус санхүүгийн байгууллагын тоо

Үйл ажиллагаа явуулж буй:	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй.	Финтек зээл олгох эрхтэй:	Зээлийн үйл ажиллагааны эрхтэй:	Факторингийн үйлчилгээний эрхтэй :
575	**479**	**72**	**511**	**55**

Итгэмжлийн үйлчилгээний эрхтэй:	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний эрхтэй:	Толборийн баталгаа гаргах эрхтэй:	Төлбор тооцооны хэрэгсэл гаргах эрхтэй:	Биржийн хүлцэлт санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх эрхтэй:

УЛААНБААТАР ХОТ СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК ШТЧ2842 7169586 9025080098

ТИ ДИ БИ ... 9021110888 TDB SECURITIES 5251494 TDB SECURITIES

90 54 28 6 50

Зураг 30: ББСБ-ын тоо, хөрөнгийн интервалаар, 2025 оны I улирал


Нийт хөрөнгө /интервалаар/	ББСБ-ын тоо	Хөрөнгийн хэмжээ, тэрбум төгрөг	Эзлэх хувь	Дундаж хөрөнгө, тэрбум төгрөг
5 тэрбум төгрөг ба түүнээс дээш	176	6,668.0	88.1%	37.9
2.5-5.0 тэрбум төгрөг	231	756.9	10.0%	3.3
1.9-2.5 тэрбум төгрөг	24	55.3	0.7%	2.3
1.4-1.9 тэрбум төгрөг	14	22.6	0.3%	1.6
0.6-1.4 тэрбум төгрөг	38	35.2	0.5%	0.9
0.6 тэрбум хүртэлх төгрөг	92	30.4	0.4%	0.3
Нийт дүн	**575**	**7,568.4**	**100.0%**	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын нийт хөрөнгийн 98.1 хувийг 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш нийт хөрөнгөтэй 407 ББСБ, 0.7 хувийг 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөтэй 24 ББСБ, 1.2 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөтэй 144 ББСБ тус тус бүрдүүлж байна.

ББСБ-ын харилцагч болон зээлдэгч

Зураг 31: Нийт харилцагч болон зээлдэгчийн тоо, 2021.I – 2025.I, мянган ширхэг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.(Банк бус санрүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга)

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар давхардсан тоогоор 575 ББСБ-ын харилцагчдын тоо 3.7 сая байгаа бол зээлдэгчдийн тоо 2.6 сая хүржээ. Нийт харилцагчдын тоо өмнөх оноос давхардсан тоогоор 718,718 буюу 16.1 хувиар буурсан бол зээлдэгчдийн тоо өмнөх оноос 43.3 хувиар өсөж 2,581,334-д хүрсэн үзүүлэлттэй байна.

ББСБ-ын санхүүгийн үзүүлэлт

Хүснэгт 35: Банк бус санхүүгийн салбарын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, 2021.I-2025.I

Үзүүлэлтүүд, тэрбум төгрөг	Үод.	2021.I	2022.I	2023.I	2024.I	2025.I
Мөнгөн хөрөнгө		465.84	374.23	513.66	388.17	662.13
Цэвэр зээл	b	1,309.64	2,176.12	2,698.57	4,037.42	6,268.24
Бусад эргэлтийн хөрөнгө		232.08	324.21	371.51	193.43	298.15
Эргэлтийн хөрөнгийн дүн		**2,007.55**	**2,874.56**	**3,583.75**	**4,819.02**	**7,223.52**
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		81.57	98.29	118.33	243.11	344.86

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 7100691 9025080018
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ХК
TDB SECURITIES

Нийт хөрөнгө	**a**	**2,089.12**	**2,972.84**	**3,702.08**	**5,062.13**	**7,568.39**
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	**d**	159.13	280.35	398.65	759.12	1,196.09
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг		162.69	358.45	393.56	705.48	1,423.85
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	**e**	70.42	184.5	249.58	344.89	618.8
Бусад өр төлбөр		214.71	285.2	343.93	334.99	444.94
Өр төлбөрийн дүн	**c**	**606.95**	**1,108.52**	**1,385.73**	**2144.48**	**3,683.67**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	**f**	1,027.32	1,164.55	1,361.07	1,655.69	1,820.56
Хуримтлагдсан ашиг/алдагдал		410.09	587.68	816.44	1,189.57	1,859.12
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг		44.76	112.09	138.84	72.39	205.03
Өөрийн хөрөнгийн дүн		**1,482.17**	**1,864.33**	**2,316.35**	**2,917.65**	**3,884.71**

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

a. 2021 оны 1 дүгээр улирлаас 2025 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд ББСБ-уудын нийт хөрөнгө жилд дунджаар 38.0 хувиар өссөн бөгөөд 2025 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 2.5 их наяд төгрөгөөр буюу 49.5 хувиар нэмэгдэж, 7.6 их наяд төгрөгт хүрчээ. Мөн салбарын нийт активын 95.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 4.6 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус бүрдүүлж байна.

b. Нийт хөрөнгийн голлох өөрчлөлтүүдийг авч үзвэл цэвэр зээлийн үлдэгдэл сүүлийн 4 жилд дунджаар 47.9 хувь, мөнгөн хөрөнгийн хэмжээ сүүлийн 4 жилд дунджаар 9.2 хувиар тус тус өсжээ. Мөн цэвэр зээлийн үлдэгдэл тайлант онд өмнөх оны мөн үеэс 2.2 их наяд төгрөг буюу 55.3 хувиар, мөнгөн хөрөнгийн хэмжээ тус хугацаанд 74.0 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

c. Салбарын нийт хөрөнгийн 3,683.7 тэрбум төгрөг буюу 48.7 хувийг бусдаас татсан эх үүсвэр, үлдсэн 3,884.7 тэрбум төгрөг буюу 51.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.
2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

d. Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 90 ББСБ-аас 87 ББСБ 13,979 итгэмжлэгчээс 1,196.1 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.
   1. Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 1,189.0 тэрбум төгрөгийн 62.6 хувийг иргэдээс, 33.3 хувийг бусад хэсгээс төвлөрүүлсэн итгэлцэл тус тус эзэлж байна.
   2. Нийт татан төвлөрүүлсэн итгэлцлийн өглөгийн 52.8 хувийг иргэдээс, 47.2 хувийг хувийн байгууллагаас татан төвлөрүүлсэн байна.

e. 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 54 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гарган, өрийн бичгийн үлдэгдэл нийлбэр дүнгээрээ 618.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 79.4 хувь буюу 273.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт бол салбарын өрийн бичгийн үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улирлаас 2025 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд 13.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

f. Салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ сүүлийн 4 жилд дунджаар 15.4 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 10.0 хувь буюу 164.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.


Зээлийн багц

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 575 ББСБ-ын 2.6 сая зээлдэгчдийн цэвэр зээлийн хэмжээ нийлбэр дүнгээрээ 6.3 их наяд төгрөгт хүрсэн нь банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 82.8 хувийг бүрдүүлж байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн дүн 55.1 хувиар өссөн бөгөөд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 6.7% болж өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр буурсан байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК
ШТЧ2842 716956
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Зураг 32: Салбарын нийт зээлийн хэмжээ, зээлийн бүтцээр, 2021.I-2025.I, тэрбум төгрөг




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 33: Нийт олгосон ба төлөгдсөн зээл, 2022.I-2025.I, тэрбум төгрөг



Зураг 34: Нийт олгосон зээл, ангиллалаар, 2022.I-2025.I, тэрбум төгрөг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар ББСБ-ууд нийт 3.6 их наяд төгрөгийн зээл олгосон бол 3.0 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 6.3 их наяд төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ. Олгосон зээлийн 94.1 хувь буюу 3.4 их наяд төгрөгийг иргэдэд олгосон бол 5.9 хувь буюу 214.4 тэрбум төгрөгийг хуулийн этгээдэд олгосон байна.


Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал"-аар нийт олгосон зээлийн 82.1% буюу 3.0 их наяд төгрөг нь бусад ангилалд (ихэвчлэн хэрэглээний зээл), 6.7% буюу 241.8 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 83.0% буюу 2.5 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 6.3% буюу 191.7 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Банк бус санхүүгийн салбарын цаашдын чиг хандлага

2022 онд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос хэд хэдэн удаа бодлогын хүүг өсгөсний улмаас арилжааны банкнуудын шинээр олгосон зээлийн хүү тухайн жилийн эцэст өссөн. Харин 2023 онд инфляцын түвшин тогтворжиж, бодлогын хүүд өөрчлөлт ороогүй учир арилжааны банкнуудын зээлийн хүүд төдийлөн өөрчлөлт ороогүй байна. ББСБ-уудын хувьд 2025 оны 1 дүгээр улиралд шинээр олгосон зээлийн өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурууллан 3.5 хувьд хүрчээ.

УПАЛНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭК
ХХК
ШТЧ2842 7169
9025080
ХАН-БАНК БИРЖЭЭР ҮЦК ХХК
9021110883
5351494
TDB SECURITIES
TDB SECURITIES

Зураг 35: Банк болон ББСБ-аас шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, хувь




Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

2021 оны байдлаар финтек буюу онлайн зээлийн үйлчилгээг зохицуулах эрх зүйн орчин тодорхойгүй байсны улмаас аппликейшн ашиглан бага дүнтэй, богино хугацаатай хэрэглээний зээл олгодог ББСБ-ууд нэмэгдсэнтэй холбоотойгоор зээлдэгчдийн тоо тухайн онд огцом өссөн байна. Харин 2022 онд финтек зээл олгодог ББСБ-уудыг "Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам"-ыг даган мөрдөж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх зохицуулалттай болсноор ББСБ-ын тоо болон харилцагчид, зээлдэгчдийн тоо багасаж эхэлсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 70 хувиас 60 хувь хүртэл бууруулсан бөгөөд суудлын автомашин худалдан авах зээлийн зээл үнэлгээний харьцааг 60 хувьд байлгах шийдвэрийг тус тус гаргасан. Энэ нь богино хугацаанд ББСБ-уудын зээлийн олголтод саармаг нөлөө үзүүлэх эрсдэлтэй ч урт хугацаандаа салбарын тогтвортой байдлыг хангах, зээлийн чанарыг сайжруулах, улмаар өрхийн худалдан авах чадварыг дэмжих эерэг хандлагатай. Эдгээрээс үүдэн ББСБ-ын салбарт зээл олголт буурах, харилцагчдын тоо буурах зэргээр эрсдэл үүсэх магадлалтай байна.

Зураг 36: ББСБ-ын тоо болон харилцагчдын тоо, 2021.I – 2025.I он



Эх сурвалж:, Санхүүгийн зохицуулах хороо


2021-2024 оны эцэс хүртэлх хугацаанд нээлттэй өрийн бичиг гаргаж зээлийн эх үүсвэрээ бүрдүүлж байгаа хоёр ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 72.9 хувиар, цэвэр ашгийн хэмжээ жилд дунджаар 76.5 хувиар, нийт цэвэр зээлийн хэмжээ жилд дунджаар 79.6 хувиар, нийт харилцагчдын тоо жилд дунджаар 42.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.[2]

Зураг 37: Салбарын болон нээлттэй бонд гаргасан ББСБ-уудын өсөлт, 2021-2024 он

[2] Нээлттэй ББСБ-уудын нийт хөрөнгө, цэвэр ашиг, нийт зээлийн багцын хэмжээ, нийт харилцагчдын тоон мэдээллийг "Инвескор ББСБ" ХК, "Сэндэл ББСБ" ХК болон "ЛэндМН ББСБ" ХК-ийн нээлттэй мэдээллийг ашиглан тооцоолсон.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭК
ХХК
ШТЧ2842 7169059
9025080006

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
5251491
4.0211110883
TDB SECURITIES
TDB SECURITIES



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо
Нээлттэй ББСБ-уудын үйл ажиллагааны тайлан

Дээрх үзүүлэлтүүд нь нээлтэй болон хаалтай хүрээнд өрийн бичиг гаргаж эх үүсвэр татаж буй ББСБ-ууд нь салбарын өсөлтөөс илүү хурдацтай өсөж байгааг харуулж байна.

Харин Хорооноос ББСБ-уудын итгэлцэл татах, өрийн бичиг гаргах харьцаа үзүүлэлтүүдийг бууруулж, ХБҮЦ гаргах дүнгийн дээд хэмжээг тогтоон, дотоодын банк санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байх зохицуулалт оруулснаар ББСБ-уудын хувьд өсөлт удаашрах хүлээлттэй байна.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 716958
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

06

ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ

6.1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам", болон Биржийн "Арилжааны журам"-д заасны дагуу явуулна.

Үнэт цаас гаргагч нь тус хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 100 хувь олон нийтэд санал болгох бөгөөд Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнэ (өгөөж)-ийн аргаар Улаанбаатар үнэт цаасны биржээр дамжуулан зохион байгуулна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 08 тоот "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэгж бүрийг тогтоосон үнийн аргаар 100,000 төгрөгөөр санал болгохоор шийдвэрлэсэн байна.

6.2. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна. Үүнд:

Зураг 38: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө



6.3. Зохицуулагч байгууллагын шийдвэр

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Хороо болон Биржид гаргаж, тус зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс өмнө энэ талаарх мэдэгдлийг Хороо болон Биржид ажлын гурваас доошгүй хоногийн өмнө гаргах богоод тус мэдэгдлийг хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно. Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, анхдагч зах зээлийн арилжааг эхлэх, дуусгах өдрийг товлон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авч, арилжаат зохион байгуулан, санхүужилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан үг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Биржийн дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ. Хороо нь үг тайланг хүлээн авч, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийн бүртгэл хийх зөвшөөрөл болон Биржид үнэт цаасны хөрөнгөтэй зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ МЭНЭЖМЕНТ
ХХК
ШТЧ2842 7169
9025080
TDB SECURITIES

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь дээрх албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаасны бүртгэлийг хийж, Хороо болон Биржид мэдэгдэх ба Бирж нь бүртгэл хийгдсэн тухай мэдэгдэлд үндэслэн ажлын 2 өдрийн дотор үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

6.4. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах

Бирж болон Хороо нь үнэт цаасыг бүртгэж, үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдахыг зөвшөөрсний дараа Андеррайтер нь тухайн үнэт цаасны танилцуулах аяныг эхлүүлэх талаар мэдэгдлийг ажлын гурваас доошгүй хоногийн өмнө Хороонд хүргүүлж, үнэт цаасыг нийтэд мэдээлэх, танилцуулах аяныг ажлын арав хоногт багтан зохион байгуулна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэхээс өмнөх бэлтгэл үе шатанд Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь түнш болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй хөрөнгө оруулалт татах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийж болох бөгөөд үүнийг үнэт цаасыг нийтэд санал болгосонд тооцохгүй.

6.5. Анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл

Үнэт цаасыг нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай Хорооноос шийдвэр гаргасны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг тодорхойлж, Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3 хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг Хороонд хүргүүлж, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногт хүлээн авах ба ХБҮЦ-ны захиалгын бүртгэлийг Биржийн анхдагч зах зээлийн арилжааны программаар дамжуулан зохион байгуулна.

6.6. Үнэт цаасны хуваарилалт

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 12 тоот "Журам батлах тухай" тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд арилжаалах журмыг баталсан байна. Тус журамд үнэт цаасны хуваарилалт хийх үйл ажиллагааг Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөж, Биржийн "Арилжааны журам"-ыг баримтлан хэрэгжүүлэх ба анхдагч зах зээлийн арилжааны хэлцэл биелүүлэх ажиллагааг Үнэт цаасны танилцуулга болон Андеррайтераас ирүүлсэн хүсэлтэд тусгасан хуваарилалтын нөхцөлийн дагуу Бирж гүйцэтгэнэ.

Хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан үнэт цаасны нийт захиалгын тоо хэмжээ Үнэт цаасны танилцуулгад тусгасан үнэт цаасны тоо хэмжээнд хүрсэн тохиолдолд Анхдагч зах зээлийн арилжааг хааж холбогдох хуваарилалтыг хийнэ.

Үнэт цаасны танилцуулгад тусгасан үнэт цаасны тоо хэмжээнээс давсан захиалгыг цуцална.

6.7. Үнэт цаас худалдан авах, захиалга огох заавар

Хөрөнгө оруулагч нь Улаанбаатар үнэт цаасны биржид бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгөө байршуулах ба үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгнө. Үүнд:


1. **Данс нээх:** Үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэнэ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАНТЭЖ
ХХК
ШТЧ2842 [illegible]569
9025[illegible]998

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИЗ УЦК ХХК
9021[illegible]
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

2. **Дансаа цэнэглэх:** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээрх өөрийн нэр дээрх дансанд ХБҮЦ худалдан авах мөнгө байршуулна.
3. **Захиалга өгөх:** Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид ХБҮЦ худалдан авах захиалга өгнө.
4. **Үнэт цаасаа хүлээн авах:** Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдаж, эрх бүхий байгууллага зөвшөөрснөөр хөрөнгө оруулагчийн нэр дээр ХБҮЦ шилжинэ.

Зураг 39: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар



Мөнгөн хөрөнгө байршуулах

Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх өөрийн нэрийн дансанд мөнгөн хөрөнгөө байршуулна.

ХБҮЦ худалдан авах мөнгө байршуулах заавар

Хүлээн авагчийн банк	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Хүлээн авагчийн нэр	Нэр
Дансны дугаар	**** **** **** 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (Үйлчлүүлдэг ҮЦК-аас лавлах)
Үнийн дүн	ХБҮЦ үнэ + Шимтгэл
Гүйлгээний утга	"Си и Си Ая Ассет Ван ТЗК" ХХК-ийн ХБҮЦ-ийн мөнгө, [Овог, нэр, регистрийн дугаар]

Арилжааны шимтгэл

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн Үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд эрх бүхий байгууллагууд болон арилжаа эрхлэх байгууллагын шимтгэл багтсан байна. Биржийн гишүүн Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг хөрөнгө оруулагч та бүхэн анхаарна уу.

Албан татвар

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 21.2.4, 21.2.5 д зааснаас үл хамаарах Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад, дотоодын үнэт цаасны арилжаа болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдах өрийн хэрэгсэл, хувьцаа, нөхөн эрх, эзэмшиг албан татвар төлөгчийн тухайн хувьцаа, нөхөн эрх, өрийн бичиг гэх мэт хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэгчийн орлогод 5 хувиар албан татвар ногдуулна." гэж заасны дагуу Үнэт цаас гаргагчийн нээлттэй хүрээнд биржийн зах зээлд гаргаж буй энэхүү хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг эзэмшиж буй Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон Монгол Улсад байрладаг гадаад улсын иргэн, ААН-ийн хүүгийн орлогод 5 хувийн татвар ногдоно[3].

[3] Давхар татварын гэрээний хүрээнд албан татвар ногдуулж, суутгал хийнэ.

Валютын ханш

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

6.8. Арилжааны төлбөр тооцоо, хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Биржийн дүгнэлтийн хамт Хороонд хүргүүлнэ. Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд Үнэт цаас гаргагчийн Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг хийх болон Биржид үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь Хорооны албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны эрхийн бүртгэлийг хийх ба энэ талаар Хороо, Биржид мэдэгдэнэ. Бирж нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн ХБҮЦ-ны бүртгэлийг хийсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЗК
ХХК
ШТЧ2842 7169569
9025080038

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9021110883
5251494
TDB SECURITIES
TDB SECURITIES

07

ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ

7.1. Андеррайтер

"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК

Регистрийн дугаар:	5251494
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө - 19, Худалдаа хөгжлийн банкны төв байр
Утас:	(976) 11 311914, (976) 7010 0261
Цахим шуудан:	info@tdbsecurities.mn
Вэб хуудас:	www.tdbsecurities.mn

"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь анх 2011 онд "Ти Ди Би Капитал" ХХК нэрээр үүсгэн байгуулагдаж, дотоодын болон олон улсын зах зээл, эдийн засгийн салбаруудын бие даасан онцлог болон тэдгээрийн хоорондын харилцан хамаарлын талаар мэдлэг, мэдээллийг хослуулан хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулж буй Монгол Улсын тэргүүлэх үнэт цаасны компани юм.

Тус компани нь харилцагчдын хэрэгцээ шаардлага, хүсэл зорилгыг эрхэмлэсэн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээ, шийдлийг мэргэжлийн өндөр түвшинд түргэн шуурхай хүргэн үндэсний баялаг бүтээгчдийг дэмжиж, харилцагчдын найдвартай зөвлөх байхыг зорин ажиллаж байна. Мөн, харилцагчдадаа хөрөнгө оруулалтын банкны болон үнэт цаасны зуучлалын үйлчилгээг үзүүлж, хувьцаа, бонд зэрэг үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүд, бүтэцжүүлсэн санхүүгийн хэрэгслийг нээлттэй болон хаалттай зах зээлд гаргах замаар санхүүжилт татах, үнэт цаас гаргах бэлтгэл ажилд зөвлөх, үнэт цаас гаргасны дараа нэмэлт үйлчилгээ үзүүлэх, компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох, компанийн стратеги төлөвлөлтөд зөвлөх, бизнесийн үнэлгээ гаргах, гадаад дотоодын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцоход зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг.

Андеррайтер нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн гадаад болон дотоодын зах зээлд нээлттэй болон хаалтай хүрээнд үнэт цаас гаргах нийт 4.8 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий төслүүд дээр ажилласан туршлагатай бөгөөд зах зээлийн дэд бүтцийн хөгжилд томоохон хувь нэмрийг оруулж буй үнэт цаасны компани юм.

Андеррайтер нь Хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, номинал данс эзэмших, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авсан байх бөгөөд эдгээр үйл ажиллагаагаа мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл



С. Батчимэг
Гүйцэтгэх захирал
Ажлын туршлага:
23 жил


С.Батчимэг нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг банк санхүү, эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, Их Британийн Вестминстерийн их сургуулийг хөрөнгө оруулалт, санхүүгийн эрсдэл чиглэлээр магистрын зэрэгтэй дүүргэж, London Stock Exchange Group Academy-д мэргэжил дээшлүүлжээ.

Тэрээр Худалдаа, хөгжлийн банканд 10 гаруй жил, Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК-д 14 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд корпорацын санхүүжилт, байгууллагын зээл, уул уурхайн төслийн үнэлгээ судалгаа, өрийн болон хувьцааны санхүүжилт, төслийн удирдлага, хөрөнгө оруулалтын чиглэлээр арвин туршлагатай, мэргэшсэн үнэлгээчин юм.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ МЭНЭДЖМЕНТ ХХК
ШТЧ28 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
9011110883
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

Компанийн бүтэц, зохион байгуулалт



Үнэт цаас гаргагчийн андеррайтертай байгуулсан гэрээ

Үнэт цаас гаргагч болон "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нар нь хоорондоо сонирхлын зөрчилгүй бөгөөд 2025 оны 6 дугаар сарын 20-ний өдөр TDBS-776/2025 дугаартай "Андеррайтер – зуучлалын үйлчилгээний гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээ нь 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуусталх хугацаанд үйлчлэх бөгөөд гэрээний хүрээнд Андеррайтер нь Үнэт цаас гаргах төслийн бэлтгэл ажлыг хангах, Үнэт цаас гаргагчаас шаардлагатай баримт бичгүүд, төсөв төлөвлөгөө, мэдээ мэдээллийн талаар зөвлөгөө өгөх, Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичиг, мэдээлэл болон хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын боловсруулсан дүгнэлт, тайланд үндэслэн Үнэт цаас гаргахад шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, Үнэт цаасны танилцуулга, Андеррайтерийн мэдэгдэл, дүгнэлт болон Үнэт цаасны багц баримт бичгүүдийг боловсруулах андеррайтер, зуучлалын үйлчилгээг үзүүлэхээр тусгасан байна.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн биржийн зах зээлд нээлттэй хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах төсөлд андеррайтер, зуучлалын үйлчилгээг үзүүлэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай хууль тогтоомж, Эрх бүхий байгууллагын холбогдох дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулахаар харилцан тохиролцсон.

Түүнчлэн, Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3 дахь заалтын дагуу хөрөнгө оруулагчид тухайн Үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхээр тус гэрээнд заажээ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ ВАН ТЭЙ
ХХК

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
TDB SECURITIES

7.2. Зээлийн шинжилгээ гаргагч

“Релаэнс секюритиз аудит” ХХК

Регистрийн дугаар:	5468639
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Сакура тауэр, 5 дугаар давхар, 508 тоот
Утас:	(976) 8810 4785, (976) 9906 9630
Цахим шуудан:	info@rsa.mn
Вэб хуудас:	www.rsa.mn

Релаэнс секюритиз аудит ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд аудит, баталгаажуулах үйлчилгээ, санхүүгийн болон эрсдэлийн зөвлөх үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Тус компанийн аудитын партнер Б.Анхтайван нь олон улсын “4 том” аудитын компанийн нэг болох Делоиттын Австрали болон Монгол Улс дахь салбаруудад 10 гаруй жил ажилласан, дотоодын болон үндэстэн дамнасан томоохон компаниудад аудит болон зөвлөх үйлчилгээ үзүүлсэн арвин туршлагатай.

Тус байгууллагын аудитор болон зөвлөхүүд нь банк, санхүү, хөрөнгө оруулалт, даатгал, уул уурхай, барилга, үйлдвэрлэл, худалдаа, тээвэр, хөдөө аж ахуй, дэд бүтэц, технологи, харилцаа холбоо зэрэг бүхий л бизнесийн салбарын компаниудад үйлчилгээ үзүүлсэн ба аудит, санхүүгийн тайлагнал, татвар, бизнесийн нэгдэл, СТОУС, эрсдэлийн менежмент, дотоод аудит, дотоод хяналт, комплаэнсийн талаар нарийн мэргэшсэн багийг бүрдүүлэн ажиллаж байгаа ажээ.

Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл




Б.Анхтайван
Гүйцэтгэх захирал

Б.Анхтайван нь аудит болон баталгаажуулах үйлчилгээний салбарт 16 жил ажилласан ба олон улсын 4 том компанийн тэргүүлэх компани болох Делоиттын Монгол болон Австрали дах салбаруудад 10 жил ажилласан туршлагатай. Тэрээр Делоиттын Австрали болон Монгол дох салбаруудад уул уурхай, барилга, банк, санхүү, хөрөнгө оруулалт, даатгал, үйлдвэрлэл, худалдаа, тээвэр, хөдөө аж ахуй, дэд бүтэц, технологи, харилцаа холбоо зэрэг бизнесийн салбарт ажилладаг олон улсын болон дотоодын томоохон компаниудад аудит, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн нийтдээ 16 жилийн туршлагатай.

Б.Анхтайван нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Аудитын Олон Улсын Стандарт, бусад баталгаажуулах үйлчилгээний олон стандартаар мэргэшиж, эдгээр стандартуудын эрчимжсэн сургалтуудад хамрагдсан байна.

Компанийн бүтэц, зохион байгуулалт



100

Үнэт цаас гаргагчийн зээлийн шинжилгээ гаргагчтай байгуулсан гэрээ

Үнэт цаас гаргагч нь зээлийн шинжилгээ гаргагчтай 2025 оны 06 дугаар сарын 23-ний өдөр зээлийн шинжилгээ гаргах тухай "Харилцан тохирсон ажил үйлчилгээний гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээ нь Хамааралтай ажил үйлчилгээний олон улсын стандарт 4400-ний дагуу явагдахаар тохирсон. Гэрээний дагуу аудитын байгууллага нь гэрээний тусгай нөхцөлд тусгасан Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч бөгөөд Үүсгэн байгуулагчаас худалдан авах зээлийн багцаас түүвэрлэн шалгахаар тохиролцсон байна.

7.3. Хуулийн зөвлөх

MDSKhanLex **"Өмгөөллийн ЭмДиЭс Энд Хаанлекс" ХХН**	Регистрийн дугаар: Хаяг: Утас: Цахим шуудан: Веб хуудас:	5495997 Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар дүүрэг, Сүхбаатарын талбай 2, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот (976) 1133-0048 info@mdsa.mn www.mdsa.mn

"Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан бөгөөд 3 (гурав) партнер, 9 (есөн) хуульч, эрх зүйчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

"Өмгөөллийн ЭмДиЭс энд ХаанЛекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн бөгөөд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажилласан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал:

- "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төсөл;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах;
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO, 5 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох, олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, нэмэлт хувьцаа, 2 удаагийн нээлттэй бонд, 2 удаагийн нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хаалттай хүрээнд өрийн хэрэгсэл гаргах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах, давуу эрхийн хувьцаа гаргах;
- "Түмэн шувуут" ХК-ийн IPO;
- "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах;
- "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах;
- Монголын ипотекийн корпорацын 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах;
- "ҮЦСК актив нэг ТЗК" ХХК, "ҮЦСК актив хоёр ТЗК" ХХК-ийн уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- "Монголын Финтек Групп" ХХК-ийн хаалттай хүрээнд хувьцаа гаргаж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлэхэд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- "Мобифинанс ББСБ" ХХК-ийн нээлттэй бонд гаргах;
- "Сэндли ББСБ" ХК-ийн IPO, 2 удаагийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах, биржийн бус зээлд өрийн хэрэгсэл гаргах;
- "Ай Си Рэит" ХХК-ийн биржийн бус зах зээлд хаалттай бонд гаргах;
- "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 4 удаагийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төсөл;

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494

- “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн 3 удаагийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төсөл;
- “Төрийн банк” ХК-ийн IPO;
- “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн IPO;
- “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн IPO;
- “Инвескор Глобал Кью” Хамтын биржээр арилжаалагддаг “ХОС”-д хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах;
- “Тэнгэр Даатгал” ХХК-ийн IPO;
- “Инвескор Хэтэвч ББСБ” ХХК-ийн биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл гаргах;
- “Хайпэй” ХХК-ийн биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл гаргах;
- “Эс Жи Капитал ҮЦК” ХХК-ийг худалдах ажиллагаа;
- “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийн уул уурхайн биржийн брокерийн тусгай зөвшөөрөл авах ажиллагаанд тус тус хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж, холбогдох баримт бичиг боловсруулах, хянах, компанийн үйл ажиллагаанд хууль зүйн магадлан шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог Asia Law сэтгүүлээс “Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН-ийг 2021, 2022, 2024 оны “Монгол улсын шилдэг хуулийн фирм”-ээр, 2024 онд хуулийн фирмийн партнер Д.Дүгэржавыг “Монгол Улсын Тэргүүлэх Эмэгтэй Хуульч”, партнер С.Батбуянг “Монгол Улсын Хүндэт Хуульч”-аар тус тус шалгаруулж, фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байдаг.

Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл



Ж. Майзориг
Гүйцэтгэх захирал

Ж.Майзориг нь үйлчлүүлэгчиддээ төслийн санхүүжилт, компанийн нэгдэл ба худалдан авалт (M&A) болон компанийн эрх зүйн зэрэг асуудлаар зөвлөгөө өгдөг.

Тэрээр тус нөхөрлөлийн Төр, хувийн хэвшлийн түншлэл /PPP/ ба Төслийн санхүүжилт, Дэд бүтэц, Маргаан хянан шийдвэрлэх болон Олон улсын арбитрын салбаруудыг ахалж ажилладаг.

“Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс” ХХН нь тухайсан бүтэцгүй бөгөөд 3 (гурав) партнер, 9 (есөн) хуульч, эрх зүйчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагчийн хуулийн зөвлөхтэй байгуулсан гэрээ

“Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс” ХХН нь Үнэт цаас гаргагчтай 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдөр “Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ”-г байгуулсан бөгөөд тус гэрээгээр Үнэт цаас гаргагчийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас” гаргахтай холбогдох асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хуулийн дүгнэлт гаргах болон барьцаа хөрөнгийн багцад шинжилгээ хийх ажлыг гэрээнд заасны дагуу бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд гүйцэтгэхээр заасан байна.

Мөн тус хугацаанд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн Зөвлөх үйлчилгээний цар хүрээ, даалгаврыг Үнэт цаас гаргагчаас тогтоон, нарийвчилсан дэлгэрэнгүй ажлын даалгаврыг “Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар”-т тусган гэрээний салшгүй хавсралтаар оруулсан бөгөөд тус үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гэрээний явцад гарган өгсөн зөвлөгөө, үйлчилгээ нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцсэн бөгөөд мэргэжлийн өндөр түвшинд байлгах бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллах баталгаа гаргасан байна.

Түүнчлэн Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох этгээдтэй аливаа ашиг сонирхлын зөрчилгүй бөгөөд өөрийн хуульчид, өмгөөлөгчдийг сонирхлын зөрчил бүхий хэлцэлд ажиллуулахгүй байх тухай тус гэрээнд тусгажээ.

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ
АССЕТ
ХХ
ШТ 842 7169569
9025080098

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
5251494
9021110883
TDB SECURITIES
TDB SECURITIES

7.4. Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Си и Си Ая Ассет Ван ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Си И Си Инвестмент ББСБ" ХХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эдгээр байгууллага нь Үнэт цаас гаргагч болон үүсгэн байгуулагчтай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

1. Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Монголын ипотекийн корпораци ОССК" ХХК;
2. Зээлийн шинжилгээ гаргагч "Релаэнс секюритиз аудит" ХХК;
3. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн ЭмДиЭс Энд Хаанлекс" ХХН;
4. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК;
5. Хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэгч "Мүүрь аудит" ХХК.

Оролцогч байгууллагуудын мэдэгдлийг хавсралтаас харна уу.

Үнэт цаас гаргагч:

“Си и Си Ая Ассет Ван ТЗК” ХХК

CECI ASSET ONE
Си И Си Ая Ассет Ван ХХК

Улаанбаатар, Хан-Уул, 18-р хороо, их монгол улс, стадион оргил, 22, Моннис бьюлдинг 3 давхар

(976) 7772 5511

Андеррайтер:

“Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК

TDB SECURITIES

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Худалдаа, хөгжлийн банкны төв байр

(976) 7010 0261
(976) 11 311914

info@tdbsecurities.mn
www.tdbsecurities.mn

ТУЗ-ИЙН ДАРГА
А.ГЭРЭЛТ-ОД

СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Л.ХОНГОРЗУЛ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Б.ТҮМЭННАСАН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.БАТЧИМЭГ

ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
TDB SECURITIES
5251494
9021110883

УЛААНБААТАР ХОТ
СИ И СИ АЯ АССЕТ ВАН ТЗК ХХК